

ДОРНОД АЙМАГ ЦАГААН-ОВОО СУМ “АЛТАН ЦАГААН ОВОО” УУРХАЙ



2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-017111/
/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6101615/

Хянасан:	БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч
Биелэлтийг тайлагнасан:	“Степ Голд” ХХК-ийн Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал /Т.Батаа/
	“Степ Голд” ХХК-ийн Байгаль орчны менежер /Г.Мөнхжин/

АГУУЛГА

Агуулга.....	2
Зургийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт	5
Графикийн жагсаалт.....	5
Товчилсон үгийн тайлбар	5
1. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
1.1. Уурхайн нэр, байршил	7
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл	7
1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал	7
1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал.....	9
1.5. Төслийн үр ашиг.....	10
1.6. Уурхайн техник, тоног төхөөрөмж	11
1.7. Ажиллах хүчний тухай мэдээллүүд	11
1.8. Уурхайн технологийн дараалал	12
1.9. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө түүний хэрэгжилт	14
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	15
2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог	15
2.2. Уур амьсгал.....	15
2.3. Гадаргын ус.....	15
2.4. Газрын доорх ус.....	16
2.5. Хөрсөн бүрхэвч.....	16
2.6. Ургамлан нөмрөг	17
2.7. Амьтны аймаг	18
2.8. Түүх соёлын өв	19
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	20
3.1. Газрын гадарга, хэвлий	20
3.2. Агаарын чанар	20
3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус.....	20
3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг	21
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	22
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	23
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	32
5.2.1. Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбай	32
5.2.2. Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайн өргөтгөл	33
5.2.3. Хамгаалалтын ойн зурвас	35
5.2.4. Эвдэрсэн газрын технологийн нөхөн сэргээлт	38
5.2.5. Цианидаар бохирдсон хүдрийн овоолгын нөхөн сэргээлтийн туршилт судалгааны ажил	40
5.2.6. Шимт хөрсний овоолго #1-ийн 1/3-ийг хэлбэржүүлэх	41
5.2.7. Модны мэнд үлдэлтийн тооллого.....	42
5.2.8. Ажилчдын кемпийн ногоон байгууламж.....	45
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	47
5.3.1. Сэргээн нутагшуулсан тарваганы мониторинг	48
5.3.2. Тосон Хулстайн БНГ, түүний орчимд тарвага нутагшуулах ажил - 2022 он.....	49
5.3.3. Цагаан-Овоо сумын 2-р багын Бэлчээрийн мониторинг судалгаа.....	50

5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	52
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	53
5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	54
5.6.1. Химийн бодисын эрсдлийн менежмент	54
5.6.2. Бусад осол эрсдэлийн менежмент	56
5.6.3. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	58
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	62
5.7.1. Ахуйн хог хаягдал	65
5.7.2. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж	66
5.7.3. Хог хаягдлын менежментийн чиглэлээр хийгдсэн бусад ажил	66
5.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	70
5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	72
5.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн биелэлт	74
6. ДҮГНЭЛТ	81

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Уурхайн байршил	7
Зураг 2. Уурхайн дэд бүтцийн байршлыг харуулсан ерөнхий зураг	8
Зураг 3. Уурхайн ажилчдын хотхон	8
Зураг 4. Дизель түлш түр хадгалах, түгээх станц	9
Зураг 5. Ажилчдын хотхоны цахилгаан эх үүсвэрийн дизель генератор	9
Зураг 6. Уурхайн техникийн парк	11
Зураг 7. Хүдэр бутлах тоног төхөөрөмж	12
Зураг 8. Нуруулдан уусгалтын талбай	12
Зураг 9. Баяжуулах үйлдвэрийн барилга	14
Зураг 10. Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайн схем зураг	32
Зураг 11. Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайн өргөтгөл шуудууг ухаж буй байдал	33
Зураг 12. Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайн өргөтгөл дэвсэг талбайнуудыг ухаж буй байдал	33
Зураг 13. Байгалийн ургамлаас хайлаас модны үр түүж, цайруулж буй байдал	34
Зураг 14. Байгалийн модноос тайрдас мөчир бэлдэж буй байдал, бэлдсэн тайрдас мөчрийг тарилт хүртэл газарт булж хадгалж буй байдал	34
Зураг 15. Бэлдсэн дэвсэгт тайрдас мөчир тарьж буй байдал	35
Зураг 16. Бэлдсэн дэвсэгт нарс модны үрсэлгээ тарьсан байдал	35
Зураг 17. тайрдас мөчрөөр тарьсан чацаргана, бургас, улиас ургасан байдал	35
Зураг 18. Хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайн зураг	36
Зураг 19. Хамгаалалтын ойн зурвас хэлбэрийн шуудууг ухаж бэлдсэн байдал	36
Зураг 20. Хамгаалалтын ойн зурвасын усалгааны 25 тонны ёмкост	37
Зураг 21. Хамгаалалтын ойн зурвасын шуудуунд дуслын усалгааны систем холбосон байдал	37
Зураг 22. Хамгаалалтын ойн зурваст тайрдас мөчрөөр улиас мод ургасан байдал	37
Зураг 23. Барилгын хог хаягдлын түр цэг доторх үлдэгдэл хог хаягдлыг цэвэрлэсэн байдал	38
Зураг 24. Хөмсөг хэлбэрээр байрлуулсан байсан шимт хөрсийг түрж, эвдэрсэн талбайг хучиж буй байдал	38
Зураг 25. Хөмсөг хэлбэрээр байрлуулсан байсан шимт хөрсийг түрж, эвдэрсэн талбайг хучиж дууссан байдал	38
Зураг 26. Хучсан шимт хөрсийг гараар тарааж, хэлбэржүүлэлт хийсэн байдал	39

Зураг 27. Олон наст ургамлын үр тарьж буй байдал	39
Зураг 28. Нөхөн сэргээлт хийсэн талбай 2 сарын дараа	39
Зураг 29. Баяжуулах үйлдвэрийн баганан уусгалтын туршилтаас гарсан 60 ppm орчим цианид концентрацитай хүдрийг байрлуулж, 3 янзаар шимт хөрсөөр хучсан байдал.....	40
Зураг 30. Цианидын концентраци бүхий овоолго дээр 10 см шимт хөрс дэвссэн талбайд тарьсан ургамал ургасан байдал	40
Зураг 31. Цианидын концентраци бүхий овоолго дээр 20 см шимт хөрс дэвссэн талбайд тарьсан ургамал ургасан байдал	41
Зураг 32. Цианидын концентраци бүхий овоолго дээр 30 см шимт хөрс дэвссэн талбайд тарьсан ургамал ургасан байдал	41
Зураг 33. Шимт хөрсний овоолго #1-ийг хэлбэржүүлэх ажил.....	42
Зураг 34. Хэлбэржүүлсэн шимт хөрсний овоолго #1 дээр гар багажаар шан татаж буй байдал.....	42
Зураг 35. Уурхайн зочдын талбайд зүлэгний үр тарьсан байдал	45
Зураг 36. Уурхайн зочдын талбайд тарьсан зүлэгний үр ургасан байдал	45
Зураг 37. Өлзий Энвайронментал ХХК-ийн боловсруулсан Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө болон зорилтот судалгааны ажлын тайлан	47
Зураг 38. Тосон Хулстайн БНГ, түүний орчимд монгол тарвага сэргээн нутагшуулсан байршил	48
Зураг 39. Тарвага сэргээн нутагшуулах газрыг Цагаан-Овоо сумын засаг даргатай хамтран сонгож буй байдал.....	49
Зураг 40. Эрэн Толгой-д тарвага нутагшуулж буй байдал	50
Зураг 41. Бэлчээрийн судалгааны хүрээнд орон нутгийн иргэнтэй уулзалт хийж буй байдал	50
Зураг 42. Угай соёл төслийн зураг авалт	53
Зураг 43. Химийн бодисын агуулахын өргөтгөл	55
Зураг 44. Сургалтыг оролцсон орон нутгийн байгууллагын төлөөллүүд	57
Зураг 45. Сургалтын уусмалын санд унасан хүнийг аврах болон анхны тусламж	58
Зураг 46. Уусмалын хоолой задрах болон цианидын асгаралтын үеийн сургалтын арга хэмжээ	58
Зураг 47. Байгууламжийн гал унтраах сургалтын арга хэмжээ	58
Зураг 48. Компост байгууламжийн бүтээн байгуулалтын зураг.....	63
Зураг 49. Хоол үйлдвэрлэлээс гарсан хоолны хаягдлыг малын өтөг бууцтай хольж компост бордоо хийж буй байдал.....	63
Зураг 50. Ашигласан тос, тосолгооны материал түр хадгалах ёмкост байрлуулж, насос холбож буй байдал.....	64
Зураг 51. Уурхайн хог хаягдлын цэгт байрлуулсан 20 тонны контейнер	64
Зураг 52. Ажилчдын кемпийн хог хаягдлын цэгийн харагдах байдал	65
Зураг 53. Хуванцар сав дахин боловсруулах үйлдвэр рүү нийлүүлэхээр ачиж буй байдал	65
Зураг 54. Ундны ус түгээх цэгт хаягдал хуванцар сав хийх хогийн сав хүлээлгэн өгсөн	67
Зураг 55. Цагаан-Овоо сумын 2-р багийн төвд ангилан ялгалт бүхий хогийн сав байрлуулсан.....	67
Зураг 56. Цагаан-Овоо сумын Эко клубийн сурагчид.....	74
Зураг 57. Хяналтын хорооны гишүүд уурхайн талбайд хүрэлцэн ирж, үйл ажиллагаатай танилцаж буй байдал.....	75
Зураг 58. ОХШХ-ийн 3-р улирлын дээжлэлт, хэмжилтийн ажилд орон нутгийн төлөөллүүд оролцож буй байдал.....	75
Зураг 59. Орон нутгийн иргэдийн худагт хэмжилт хийж буй байдал	76
Зураг 60. Байгаль орчны мэргэжилтэн Г.Гүнбат болон Пенин ХХК-н аюулгүй ажиллагааны ажилтан Цэрэндулам нар 2-р багын ИНХ-д мэдээлэл танилцуулсан.....	76
Зураг 61. Орон нутгийн төлөөллүүд уурхайн талбайд зочилж буй байдал	76
Зураг 62. Дорнод аймгийн албан тушаалтнууд уурхайн талбайд хүрэлцэн ирж, хяналт, шалгалт хийсэн.....	77
Зураг 63. Хэрлэн голын сав газрын захиргааны ажилчид уурхайн талбайд зочилж буй байдал	77

Зураг 64. Хөлөнбуйр сумын ЗДТГ-н төрийн албан хаагчид уурхайн талбай болон мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайтай танилцаж буй байдал.....	78
Зураг 65. Сайн дурын кодексийн гишүүн байгууллагуудын төлөөлөл уурхайн талбайгаар зочилж буй байдал.....	78
Зураг 66. MERIT төслийн сургалтад хамрагдсан зочид төлөөлөгчид.....	79
Зураг 67. Хээрийн дадлага, сургуулилтыг хийж буй байдал.....	79

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ТЭЗҮ-нд тусгагдсан улсад төлөх татварын хэмжээ.....	10
Хүснэгт 2. 2022 оны БОМТ-ний биелэлт бүлэг тус бүрээр.....	23
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	24
Хүснэгт 4. Мод үржүүлгийн талбайн мэдээлэл.....	43
Хүснэгт 5. Салхины хамгаалалтын зурвасын туршилтын ажлын мэдээлэл.....	45
Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	46
Хүснэгт 7. Монгол тарваганы тооллогын мэдээ.....	48
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	51
Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	52
Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	53
Хүснэгт 11. 2022 оны химийн бодис, урвалжийн ашиглалтын тооцоо.....	54
Хүснэгт 12. 2022 оны 6-р сарын байдлаарх баяжуулах үйлдвэрт ашигласан химийн бодисын хэмжээ.....	56
Хүснэгт 13. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	59
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	67
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт.....	70
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт.....	72
Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн хэрэгжилт.....	79

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. 2022 оны намрын мэнд үлдэлтийн тооллого.....	44
График 2. Тайрдас мөчир болон үрээр тарьсан модны мэнд үлдэлт.....	44
График 3. Тосон Хулстайн БНГ-н нутаг дахь монгол тарвага.....	49

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БОАЖЯ – Байгаль орчин аялал жуулчлалын яам

МХГ – Мэргэжлийн хяналтын газар

ЭБМЗ – Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл

ТЭЗҮ – Техник эдийн засгийн үндэслэл

БОМТ – Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БОЯБ – Биологийн олон янз байдал

УТХГ – Улсын тусгай хамгаалалттай газар

ОХШХ – Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

БОННУ – Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

НУБ – Нуруулдан уусган баяжуулах

АЦО – Алтан Цагаан-Овоо

ШТС – Шатахуун түгээх станц

БНГ – Байгалийн нөөц газар

ЗДТГ – Засаг даргын тамгын газар

ХХХ – Хувийн хамгаалах хэрэгсэл

УБУ - Уусгалтын баян уусмал

УСУ - Уусгалтын суларсан уусмал

1. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт орших “Урд Цагаан-Овоо”-гийн /хуучин нэрээр/ XV-006727 дугаартай 109,118 га хэмжээтэй талбайн хайгуулын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын хайгуулын ажил гүйцэтгэхээр 2003 оны 12-р сарын 30-нд “Кожеговь” ХХК анх авсан. Үүний дараагаар нь 2007 онд АМГТХЭГ-ын КБТ-ын (хуучин нэрээр) даргын 1620 тоот шийдвэрээр 85,500 га талбайг хэсэгчлэн буцааж өгснөөр 23,597.51 га хэмжээтэй талбай үлдсэн. Энэ талбайг “Сентеррагоулд Монголия” ХХК нь АМГ-ын ГУУКХ-ийн даргын 2010 оны 5-р сарын 04-ний 513 тоот шийдвэрийн дагуу өөрийн нэр дээр шилжүүлэн авсан байдаг. Тухайн үед ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Сентеррагоулд Монголия” ХХК-ийн захиалгаар “Гложекс ХХК” 2012 оны 7-р сараас эхлэн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 2013 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан.

Харин 2016 оны 3-р сарын 28-нд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7-р зүйлийн 7.3, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 3-р зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн БОНХЯ-наас /хуучин нэрээр/ ирүүлсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу “Эко Трейд” ХХК “Алтан Цагаан овоогийн Алт-Холимог Металлын Үндсэн орд, Давхарын арын хөндийн газрын доорх усыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г боловсруулан 2017 онд батлуулсан байдаг.

“Степ Голд” ХХК нь 2017 оны 9-р сарын 05-ны өдөр MV-017111 дугаар бүхий 5492,63 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг “Сентеррагоулд Монголия” ХХК-аас МУ-ын холбогдох хууль, тогтоомжын хүрээнд АМГТГ-ын 544 тоот шийдвэрээр шилжүүлэн авч албан ёсны төсөл хэрэгжүүлэгч нь болсон.


Тухайн төслийн талбайд нэмэлтээр 2012-2014 онуудад хийгдсэн геологийн хайгуулын ажлын үр дүнгээр 2019 онд ордын нөөцөд тодотгол хийж АМГТ газрын даргын 2019.06.10 өдрийн Н/45 дугаар тушаалаар бүртгүүлсэн. /Хавсралт 1. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаал/. Мөн ондоо “Мидас майнинг” ХХК төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан. ТЭЗҮ тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор БОННУ тодотгол тайлангийн ажлыг “Мейк Грийн” ХХК гүйцэтгэсэн. /Хавсралт 2. БОННУ тодотгол тайлангийн батлагдсан нүүр хуудас/.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618-р тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Степ Голд” ХХК нь 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж, Дорнод аймгийн Засаг даргын 2019 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дээрх төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлүүлж 92.9%-ийн үнэлгээ авсан болно /Хавсралт 3. БОМТ-2021-ийн хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн хуудас/.

Төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол улсын хууль, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, өмнөх жилийн ажлын хэсгийн дүгнэлтээр гарсан зөвлөмж зэргийг удирдлага болгож, төслийн хэмжээнд 2022 онд хийгдэх үйл ажиллагаатай уялдуулан боловсруулж БОАЖЯ-р батлуулсан. Тус батлагдсан төлөвлөгөөг Дорнод аймгийн БОАЖГ, МХГ, Дорнод бүсийн УТХГ-уудын хамгаалалтын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргаа, Цагаан-Овоо сумын ЗДТГ зэрэг байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. (Хавсралт 4. БОМТ-2022 хүргүүлсэн баримт)

1.1. Уурхайн нэр, байршил

“Алтан Цагаан Овоо” Алт, холимог металлын ордыг ил аргаар ашиглах уурхай нь Монгол улсын зүүн хэсэгт, Дорнод аймгийн “Цагаан-Овоо” сумын II багийн нутагт оршдог. Улаанбаатар хотоос 650км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос 180км, Цагаан-Овоо сумаас баруун зүгт 38км, Улаанбаатар - Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай замаас хойд зүгт буюу Хөлөнбуйр сумаас хойд зүгт 65км зайд Давхарын Арын хөндий, Хүрэн толгой, Мянган хоньт, Намхайн толгойн бэл орчмын хуурайшилт ихтэй, үржил шимт хөрстэй, тал хээрийн экосистем буюу хуурай хээрийн бүсэд оршдог.



Зураг 1. Уурхайн байршил


1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр:	“Степ Голд” ХХК
Аж ахуйн нэгж бүртгэлийн дугаар:	9019083110
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:	Гадаад худалдаа, Ашигт малтмал ашиглалт /2012.08.31-2042.08.31/, Ашигт малтмалын хайгуул /2018.02.25-2019.02.25/
Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла төв, Шангри-Ла оффис 12-р давхар
Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Гүйцэтгэх захирал Т.Батаа, 99107777, bataa@steppegold.com
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Байгаль орчны менежер Г.Мөнхжин, 99139291, munkhjin.g@steppegold.com

1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

Бид 2018 оноос бүтээн байгуулалтын үйл ажиллалгааг эхлүүлж байсан ба үүнд дотоод сайжруулсан шороон зам, дэд бүтцийг барьж байгуулах ажлууд хийгдсэн. Бүтээн байгуулалтын ажлын

хүрээнд хүдэр бутлах хэсэг, уусгах талбайн 1, 2-р үүр, шимт хөрсний овоолгууд, хаягдал чулуулгийн овоолго, хөрсний овоолго, уурхайн дотоод зам болон ажилчдын хотхон, түлш түр хадгалах, түгээх станц, баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулсан. Нуруулдан уусгах талбайн 3, 4, 5-р үүрийн бүтээн байгуулалтын ажил 2020 онд эхэлсэн бөгөөд 2022 онд бүрэн хийгдэж дууссан. 2022 онд уурхайн үндсэн бутлуурын бүтээн байгуулалтын ажил эхэлсэн бөгөөд 2022 оны 10-р сарын 20-ны байдлаар угсралт, шалгалтын ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна. Дээрх дэд бүтцүүдийн хоорондын буюу уурхайн дотоод сайжруулсан шороон замын нийт урт 25км байна.



Зураг 2. Уурхайн дэд бүтцийн байршилыг харуулсан ерөнхий зураг

Ажилчдын кемп:

Уурхайн ажилчдын кемп нь нийт 200 – 250 хүн хүлээн авах чадалтай. Тухайн ажилчдын кемпийн барилга байгууламж нь нийтийн халуун ус, ариун цэврийн байгууламж 2, уурын зуух, 76 гэр, захиргаа, оффисын хэсэг, гал тогоо, угаалга, хамгаалалтын пост, унд, ахуйн усны худаг, автомашины паркийн талбай зэргээс бүрдэнэ.



Зураг 3. Уурхайн ажилчдын хотхон

Анхдагч сульфидын хүдэр баяжуулах үйлдвэрт флотацийн технологиор хар тугалга болон цайрын баяжмалыг үйлдвэрлэнэ. Хар тугалга болон цайрын баяжмалд алт, мөнгө дагалдах байдлаар гарна. Флотацийн камерын бүтээгдэхүүн болох пиритийн баяжмалыг дахин СІL уусгалтын технологиор баяжуулах ба технологиос алт, мөнгө гарган авна.

Анхдагч сульфидын хүдэр баяжуулах үйлдвэр нь ил уурхайгаас ирэх алт-холимог металлын хүдрийг флотаци-уусгалтын аргаар баяжуулж, төслийн хугацаанд нийт 62113.05 тонн хар тугалганы баяжмал, 91191.94 тонн цайрын баяжмал үйлдвэрлэх ба хар тугалга болон цайрын баяжмалд 4.29 тонн алт болон 25.27 тонн мөнгө дагалдан гарна. Пиритийн баяжмалыг уусгалтын технологиор баяжуулан 4.99 тонн алт, 20.35 тонн мөнгө гарган авна. Анхдагч сульфидын хүдэр баяжуулах үйлдвэрийн нийт металл авалтын хэмжээ нь хар тугалгад 67.91%, цайрт 58%, алт 71.15%, мөнгө 77.08% тус тус байна.

1.5. Төслийн үр ашиг

Алтан Цагаан-Овоо төсөл хэрэгжсэнээр ордыг ашигласнаар нийт 250 хүнийг ажлын байраар хангаж, улс орон нутгийн төсөвт 11 жилийн хугацаанд нийт 284.8 тэрбум төгрөг төвлөрүүлэх ба үүнээс 242.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт 42.7 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр ТЭЗҮ-д тусгасан. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуй нэгжийн орлогын албан татвар, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл, авто тээврийн хэрэгсэл, өөрөө явагч механизмын татвар, ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын төлбөр болон бусад татвар, төлбөрийг Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцоолов. Ордын нөөцийг ашиглах үед улс орон нутгийн төсөвт төлөх татвар төлбөрийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. ТЭЗҮ-нд тусгагдсан улсад төлөх татварын хэмжээ

Татвар	Хэмжих нэгж	Нийт	Улсын төсөв	Орон нутгийн төсөв
АМНАТ				
Алт	сая.төг	49,937	34,956	14,981
Мөнгө	сая.төг	3,274	2,292	982
Хар тугалганы баяжмал	сая.төг	4,856	3,399	1,457
Цайрын баяжмал	сая.төг	12,089	8,462	3,627
Тусгай зөвшөөрлийн төлбөр	сая.төг	2,779	2,779	0
Газар ашигласны төлбөр	сая.төг	1,022	0	1,022
Ус ашигласны төлбөр	сая.төг	10,867	0	10,867
ААНОАТ				
Нийгмийн даатгалын шимтгэл	сая.төг	29,103	29,103	0
Хувь хүний орлогын албан татвар	сая.төг	8,131	0	8,131
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	сая.төг	1,616	0	1,616
Агаарын бохирдлын төлбөр	сая.төг	3.47	3.47	0
ТХӨЯМ Татвар	сая.төг	39	0	39
Гаалийн татвар	сая.төг	15,435	15,435	0
НӨАТ				
	сая.төг	35,783	35,783	0
Нийт	сая.төг	284,856	242,134	42,722

1.6. Уурхайн техник, тоног төхөөрөмж

Ил уурхайн хөрс болон хүдрийг өрөмдлөг тэсэлгээний аргаар сийрэгжүүлж, өрөмдлөгийн ажилд Atlas Copco DM 25 маркийн 127-140 мм диаметр хошуутай өрмийн машин, хөрс хуулалт болон хүдэр олборлолтод CAT 349, Hyundai 500, CAT 320 экскаваторууд, хөрс, хүдэр тээвэрт 30 тн даацтай Howo маркийн автосамосвалууд, мөн Hyundai 780, Hyundai 50 зэрэг дугуйт ачигч, CAT D8 болон CAT D6 бульдозер, Liugong брэндийн автогрейдэр тус тус ашиглан ажиллаж байна.



Зураг 6. Уурхайн техникийн парк

1.7. Ажиллах хүчний тухай мэдээллүүд

Алтан Цагаан Овоо уурхайн талбайд 2022 оны 10-р сарын 31-ны байдлаар “Степ Голд” ХХК-ийн үндсэн ажилтнаас гадна Степ Ийст ХХК, Хүннү Секюрити, Пенин ХХК, Засагт Хаан ХХК, Окс лимитед оператор, Биомедфарм ХХК, Поларис Энженер Консалтинг, РЭС ХХК, Крестлайн ХХК, Хан Тамсаг ХХК зэрэг гэрээт компаниудын ажилчид ажиллаж байна. Төслийн талбайд хоногт дунджаар 250 гаруй хүн ажиллаж байна.

Үндсэн болон гэрээт компаниудын ажилчдын тоо бүртгэлээс харахад төслийн талбайд нийт 614 ажилтан ажиллаж байгаагаас 423 ажилтан нь Дорнод аймгийн харьяалалтай байна. Цагаан-Овоо сумаас 190 ажилтан Дорнод аймгийн бусад сумдаас (Баяндун, Хэрлэн, Баян-Уул, Баянтүмэн г.м.) 233 ажилтан ажиллаж байна.

“Мидас майнинг” компанийн боловсруулсан ТЭЗҮ-д төслийн талбайд 258 хүн ажиллахаар тусгасан байна. Үндсэн болон гэрээт ажилчид 20 хоног ажиллаж 10 хоног амрах зохицуулалттайгаар ажилладаг байсан бол Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнээр 2022 оны 02-р сарын 01-ээс эхлэн төслийн талбайд ажиллаж буй бүх ажилчид 14 хоног ажиллаж 14 хоног амрах зохицуулалттайгаар ажиллаж байна. Уурхайд ажиллах нийт ажилчдын цалин хөлсийг бусад уул уурхайн компаниудын цалингийн дундажтай ижил байхаар тогтоосон байна. Ил уурхай, баяжуулах үйлдвэр, уурхайн ажилчдын цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 53.1 -р зүйлд зааснаар тооцсон.

Бид уурхайн ажиллах хүчний дийлэнх хувийг орон нутгийн иргэдээс хангах мөн туслан гүйцэтгэгч, гэрээт компаниуд ажилчдын тодорхой хувийг орон нутгаас авч ажиллуулж байна. Цаашид орон нутгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна.

1.8. Уурхайн технонологийн дараалал

Хүдэр бутлалт: Нуруулдан уусгалтанд хүдрийг бэлтгэх хөдөлгөөнт бутлах төхөөрөмж байхаар төсөлд сонгож авсан. Хүдрийг бутлахад KE860-1 маркийн хөдөлгөөнт хацарт бутлуур, КН300-2 маркийн конусан бутлуур бүхий 3 шатны бутлалтаар буталж нийт орж байгаа хүдрийн 80%-ийг 25мм-ээс бага ширхэгтэй болгож бутлагдсан хүдрийн овоолгод туузан конвейероор өгнө. Уусгалтанд шаардагдах уусмалын орчин рН-ыг 10.0-11.0 хооронд байлгахын тулд бутлагдсан хүдэр бутлуураас гармагц түүн дээр шатаасан чулуун шохой нэмж өгнө. Бутлах төхөөрөмжийг иж бүрдлээр нь Хятад улсад үйлдвэрлэсэн.



Зураг 7. Хүдэр бутлах тоног төхөөрөмж

Уусгалтын талбай: Буталсан хүдрийг утгуурт ачигчаар 35-55тн-ын даацтай машинуудад ачиж уусгалтын талбай руу тээвэрлэх ба 8м-ийн өндөр үе үүсгэн хураах ба 35 градусын налуугийн өнцөг бүхий нийт 3 давхар үе үүсгэнэ. Уусгалтын талбай нь 100х230м орчим талбайг эзлэн далайн түвшнээс дээш ойролцоогоор 1,010 – 1,060 метрт оршино. Уг уусгалтын суурь нь 5.6 сая тонн хүдэр багтаах дээд багтаамжтай.



Зураг 8. Нуруулдан уусгалтын талбай

Хураагдсан хүдрийн дундаж нягтыг 1.6 тн/м³, овоолгын өндрийг суурийн жийргэвчээс дээш 24м өндөртэйгөөр хийхээр бодож овоолгын багтаамжийг гаргасан. Уусгалтын овоолгын дор 300мм нягтруулсан шороон ул хийж, дээгүүр нь 1.5мм-ийн зузаантай бага нягтралтай полиэтилен (HDPE) синтетик жийргэвчээр хучаад, 500мм-ийн зузаантай буталсан чулуулгаар бүрхэж суурийг бэлтгэсэн.

Үндсэн уусмал цуглуулагч нь хоорондоо 15м зайтайгаар овоолгын нийт суурийн дагууд тараан байрлуулсан 100мм-ийн нүхэлсэн хоолойнуудаас бүрдэнэ. 100мм-ийн хоолойнууд нь илүү том диаметр

бүхий 300 мм-ийн давхар ханатай цуглуулагч хоолойнууд уруу цутгах бөгөөд эдгээр хоолойнууд нь уусмалыг талбайн дундуур дамжуулж, талбайн доод хэсэгт хүргэнэ. Эндээс гуравдагч хоолой буюу 710 мм диаметртай хоолойтой холбогдож цааш уусмал нь баяжсан уусмалын санд өгнө.

Хүдрийг овоолгын суурийн нийт периметрийн дагууд үе үүсгэн хураах бөгөөд овоолгын нийт дундаж налуу нь 1:1.43 (босоо тэнхлэгийг хэвтээ тэнхлэгт) байна. Овоолгын налууг ажлын үеийн болон хаалтын дараах үеийн тогтворжилтыг ердийн үед ба газар хөдлөлтийн үед хангах нөхцөлөөр аюулгүйн статик ба динамик хүчин зүйлүүдийг тус тус 1.5 ба 1.1 байхаар сонгосон.

Уусгах ажиллагаа ба алт, мөнгө авалт: Зуны улиралд уусгалтыг хэвийн байдлаар явуулахын тулд нуруун дээр уусмалын шугам хоолойг байрлуулж түүнээс нарийн шугам салаалан авч уусмал өгөх дусаагуур хоолойг холбон идэвхтэй уусгалт явуулах талбайд уусмалыг өгнө. Идэвхтэй уусгалтын үүр ойролцоогоор 31,900 м² хүртэл талбайтай байна. Зуны туршид нэмэлт нэвчилтийн хоолойнуудыг байрлуулах боломж олгохын тулд үүр тус бүрд хүдрийг хураах хугацаа (30 хоног) нь уусгалтын хугацаанаас (30-60 хоног) богино байна. Уусмал түгээх хоолой дахь хавлагууд уусмалыг шаардлагатай тохиолдолд чиглэлийг нь өөрчлөх боломжтой байна.

Өвлийн нөхцөл байдлыг зохицуулахын тулд хүйтэн цаг агаарт нуруулдан уусгалтыг явуулж ирсэн төрөл бүрийн аргуудыг ажлын төлөвлөгөөнд тусгаж өгсөн. Дулаалга бүхий суларсан уусмалын шугам хоолойнууд, суларсан уусмалыг халаагч, нөөц эрчим хүчний эх үүсвэр зэргийг үүнд хамруулж болно. Хавар уусгалтыг дахин эхлүүлэхийн өмнө хөлдсөн хүдрийг урьдчилан гэсгээж, овоолгод байж болзошгүй мөсний давхаргуудыг хайлуулахын тулд түр хугацаатай дээгүүр нь усаар шүрших, шугам хоолойнуудыг зогсоохын өмнө шавхах, баяжсан уусмалын санд хөлдөлтийн хамгаалалт хэрэглэх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг мөн авна.

Нуруулдан уусгалтын талбайд хүдрийг суурийн түвшингээс дээш 8м-ийн үеүд үүсгэн 24м хүртэл өндөртэйгөөр хураана. Хүдрийг хураах ба уусгах процесс жилийн турш үргэлжилнэ. Нуруулдсан хүдэрт уусмал дусаагуур хоолойгоор дамжуулан 408,320 тонн хүдрийг багтаасан ажлын нэг үүрэнд 30-60 хоногийн уусгалтын мөчлөгийн туршид натрийн цианид (NaCN)-ийн уусмалыг 8-12л/мин/м² зарцуулалттай өгөх ба уусгалтын гүйцэтгэлээс хамааруулан уусгалтын хурдыг тохируулна. Уг уусмал нуруулдсан хүдрийн биетээр нэвчин хүдэр дэх алт болон мөнгийг уусган гараад хүндийн жингээрээ урсан, уусгалтын баян уусмалын (УБУ) санд цугларна. Уг сангаас уусмалыг нүүрсний багана руу насосоор шахна. УБУ-ыг багануудаар дамжуулж алт болон бусад металлуудыг идэвхжүүлсэн нүүрсэнд шингээж, (адсорбци) уусгалтын суларсан уусмал (УСУ) болгоно. Алтаар баяжсан нүүрснээс алт мөнгийг салгаж (дисорбци) хандалсан уусмал гарган авах ба алтгүй болсон нүүрсийг буцаан ашиглана. Алтны өндөр агуулгатай хандалсан уусмалаас электролизын (катод, анод) аргаар алтыг ялгана. УСУ-ыг халааж шахуургаар шахаж нуруулдан уусгалтад эргүүлэн ашиглана.

Нүүрсэнд алт, мөнгө сүүлгах процесс: УБУ-аас идэвхжүүлсэн нүүрсээр дүүргэсэн 2 м-ийн голчтой 4.5 м-ийн 6 ширхэг багануудаар дамжуулан алт мөнгийг нүүрсэнд суулгана. УБУ-ыг баганын доод талаас тэжээж, халиа нь дараагийн баганын тэжээл болох маягаар урсана. Харин нүүрсний урсгал сүүлийн баганаас өмнөх багана руу дамжуулагдан цааш зөөвөрлөгдөнө. Эхний баганын нүүрсний алтны агуулга хангалттай болоход үйлдвэрийн нүүрснээс алт ялгах хэсэг рүү тээвэрлэж нүүрснээс алт мөнгийг салгана. Алтыг Нүүрсэнд Шингээх СИС үйлдвэр нь УБУ-ын сангийн зэргэлдээ байрлана. УБУ нь Алт, мөнгийг Нүүрсэнд Шингээх СИС цехийн зүүн талаас орж ирэх бөгөөд баруун тийш дамжин өнгөрнө. УСУ-ын санд нэмэлт ус болон цианидын агуулгын тогтворжуулалтыг ахин хийнэ. Хэт их ачаалал, их хэмжээний хур тунадас орсон үед УБУ-ын сангаас УСУ-н санруу илүүдэл уусмал хальж орох бөгөөд УСУ-н сангийн илүүдэл уусмал үерийн санруу хальж орох зохицуулалттай. УСУ нь хүйтний улиралд хөлдөхөөс урьдчилан сэргийлж дулааны станцаар дамжих бөгөөд энд уусмалыг овоолгод өгөхийн өмнө 10° С хүртэл халаана.

Баяжсан нүүрснээс алт, мөнгө салгах хэсэг-Десорбц: Алт агуулсан баяжсан нүүрсийг боловсруулах дараагийн ажилбар нь боловсруулах үйлдвэрт байх десорбцийн буюу нүүрснээс алтыг салгах хэсэг юм. Алтыг нүүрсний гадаргуугаас салгах циклийн ажиллагаанд Zadra десорбцийн процессыг хэрэглэнэ. Нуруулдан Уусгах төслийн баяжсан нүүрс 2000-5000 г/тн алтны агуулгатай байна. Баяжсан нүүрсийг 2 тонн багтаамжтай хүчлээр угаах баганад давсны хүчлээр угааж кальцийн төрлийн бохирдол болон гадаргуу дээрх бохирдлыг зайлуулна.

Хүчлээр угаасан нүүрсийг десорбцийн баганад цианид, натрийн шүлтийн уусмалд 120-150°C хүртэл температурт халааж 0,5 мПа даралтын доор ойролцоогоор 6 цаг байлгана. Алтыг нүүрсний гадаргуугаас салгах процесс дуусахад нүүрсэн дэх алтны агуулга 100 г/тн-ээс илүүгүй болтол буурсан байна. Алтнаас суларсан нүүрсийг усан хөөргөгчөөр сэргээлтийн зуухруу шахна. Энд шаардлагатай тохиолдолд нүүрсийг халаан идэвхжлийг 95% хүртэл сэргээнэ. Суларсан нүүрсийг шингээлтийн хэсэгрүү буцаан явуулна.

Электролиз ба хайлуулалт: Десорбцийн баганаас гарсан алт, мөнгөөр баяжсан уусмал нь даралт босоо хяналтын шүүрүүдээр дамжин электролизын ваннуудаар дамжин цааш элюшн уусмалын танкруу орж цааш эргэлдэнэ. Электролизын ваннуудад уусмал дахь алт болон бусад металлууд нь ноосорхог ган катод дээр ялгарч сууна. Алт бүхий ноосорхог ганг даралтад усаар шүршин угааж алт болон бусад металлыг цуглуулж авч шүүнэ.

Шүүж авсан sludge буюу хольц бүхий шаврыг азотын хүчлийн танканд хийж хутгалтаар уусгаж алтны шаврыг ялгаж авна. Гаргаж авсан алтны шаврыг усаар сайтар угаан шүүж, хатаана. Хатсан алтны шаврыг хайлуулах зууханд флакс бодисуудын хамт хийж хайлуулан алтан гулдмай гаргаж авна. Азотын задаргааны дараа үлдсэн уусмалд хоолны давс хийж хлорт мөнгөний тунадас гаргаж авна. Үүссэн мөнгөний тунадасыг сайтар угааж, хатаана. Цааш алт шавар хайлуулах явцтай адилаар мөнгөний гулдмай гаргаж авна.



Зураг 9. Баяжуулах үйлдвэрийн барилга

1.9. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө түүний хэрэгжилт

Алт, Холимог металлын Алтан Цагаан-Овоо ордод 2012-2014 онуудад хийгдсэн геологийн хайгуулын ажлын үр дүнгээр 2019 онд ордын нөөцөд тодотгол хийж АМГТ газрын даргын 2019.06.10 өдрийн Н/45 дугаар тушаалаар улсын нөөцөд бүртгүүлсэн. Мөн 2019 онд “Мидас майнинг” ХХК төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан. Бид уурхайн ашиглалтын үйл ажиллагааг батлагдсан ТЭЗҮ-н дагуу төлөвлөн ажиллаж байна.

“Алтан Цагаан-Овоо” уурхайн уулын ажлын төлөвлөгөөний дагуу олборлолтын үйл ажиллагааны хүрээнд энэ онд 2022 оны 10-р сарын 15-ны өдрийн байдлаар нийт 183,090 м³ хаягдал чулуулга, 22,684 м³ шимт хөрс, 853,420 тн хүдэр олборлосон байна.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог

Урд цагаан овоо лицензийн талбай нь Цагаан-Овоо сумын төвөөс баруун зүгт 50 км, Улаанбаатар хотоос зүүн зүгт 650 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос баруун хойш 180 км зайд оршино. Талбай орчмын нутаг нь Монгол орны геоморфологийн мужлалаар Ухаа гүвээт талын хэв шинжид хамаарагдах ба Монгол орны дорнод хэсгийн ихэнх нь энэ хэв шинжид хамаарагдана. Энэ тал дахь ухаа гүвээ харьцах өндрөөрөө 10-20 метрээс үл хэтэрнэ. Тус лицензийн талбай Цагаан Овоо сумын Дуут нуур, Цагаан нуур, Хөшөөт, Давхарын арын хөндий, Дөрөө, Баян голын уулзвар, Бидэр толгой, Бор толгой, Яруу уулын орчмыг хамарна.

Газрын гадарга нь намхан гүвээ толгод бүхий тэгшивтэр гадаргууд хамаарагдах ба энд тэнд салангид байрласан намхан уулсын цогцолборуудаас бүрдэнэ. Лицензийн талбай орчмын нутаг дэвсгэрийн дундаж өндөр далайн түвшнээс дээш (д.т.д) 1050м бөгөөд хамгийн нам газар нь Баян голын голдирлын (нутгийн иргэд Бидэр горхи гэдэг) дагуу 920 м, хамгийн өндөрлөг цэг нь лицензийн талбайгаас баруун зүгт орших Баян уул 1236м, Яруу уул 1200м өндөрт оршино.

2.2. Уур амьсгал

Энэ бүс нутагт өвөлдөө цас бага унадаг, агаарын чийгшил багатай, хавартаа салхи, шуурга ихтэй, дулаан, хүйтний горим нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Хаврын улирал тус сумын нутагт 3 дугаар сарын 15-аас 5 дугаар сарын 15-19-н хүртэл нийт 60-64 орчим хоног, зуны улирал 5 дугаар сарын 15-19-өөс 9 дүгээр сарын 15-н хүртэл нийт 120 орчим хоног, намрын улирал 9 дүгээр сарын 15 орчмоос 10 дугаар сарын 25 хүртэл дунджаар 40 хоног, өвлийн улирал 10 дугаар сарын 25-наас 3 дугаар сарын 15-19-н хүртэл нийт 5 сар орчим (140-145 хоног) үргэлжилнэ.

Агаарын хамгийн бага температур нь -45.5°C , хамгийн их температур нь 39.8°C хүрдэг. Жилийн дундаж агаарын температур -0.4°C хүрнэ. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -21.8°C , хамгийн халуун 7 дугаар сарын дундаж температур 19.1°C байдаг. Цагаан-Овоо сумын нутагт жилд дунджаар 250 мм хур тунадас унадаг. Цагаан-Овоо сумын хувьд салхины хурдны олон жилийн дундаж нь төдий л ихгүй ойролцоогоор 2.5-3.0 м/с байдаг. Салхины горимын 1 онцлог үзүүлэлт болох салхигүй буюу намуун байх үеийн давтагдал нь 21% байдаг байна. Харин салхины их хурдын хувьд ихэнх саруудад 15 м/с-с их, хаврын саруудад 28 м/с хүрч байжээ

2.3. Гадаргын ус

АЦО-ийн алт, холимог металлын ордыг ашиглах талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Номхон далайн ай савд, Монгол орны Хэрлэн голын сав газарт тус тус багтана. АЦО-ийн алт, холимог металлын ордыг ашиглах талбайн ойролцоо Шалз, Элст, Дөрөөгийн, Баян зэрэг жижиг гол, горхи, Хараатын горхи болон Их цагаан, Дунд, Ар хоолойн, Цавтын, Баян мөнхийн цагаан, Холбоо, Чавганцын, Хайчийн, Хаялага, Салбарын, Цагаан хошууны, Дуут, Овоот, Ухаагийн цагаан, Эрэгцэг, Шандын, Давхарын цагаан зэрэг нуурууд, мөн жижиг давст нуур, шал, тойрмууд тохиолдох боловч ихэнх нь хатаж ширгэсэн байдалтай байна.

2011 оны 8, 9-р сард хийсэн хээрийн судалгааны ажлын үед АЦО-ийн алт холимог металлын орд, түүний орчимд нийт 1 гол, 3 нууранд бичиглэл, тэмдэглэл хийсэн. Харин усны дээжлэлтийг 1 гол, 1 нуураас авсан бөгөөд 2 нуурын ус маш их хагшаас бүхий булингартай, шаварлаг, дээж авах боломжгүй байсан байна. АЦО-ийн алт, холимог металлын ордыг ашиглах төслийн талбайн ойролцоох нууруудын хувьд малын хөлд их бохирдсон, унд ахуйн зориулалтаар ашиглах боломжгүй.

2011 оны усны шинжилгээгээр Баян голын усны магнийн агууламж MNS 0900:2005 стандартад заасан хэмжээнээс 7.06 мг/л-ээр, Эрэгцэг нуурын усны рН-ийн хэмжээ 1-ээр, аммиакийн агууламж 2.5 мг/л-ээр, хлоридын агууламж 219.34 мг/л-ээр, нитритийн агууламж 0.03 мг/л-ээр, сульфатын агууламж 5158.97 мг/л-ээр MNS 4586:1998 стандартад заасан хэмжээнээс тус тус хэтэрсэн байна. 2014 оны усны хүнд металлын шинжилгээний дүнгээс харахад Баян голын усны магнийн агууламж MNS 0900:2005 стандартад заасан хэмжээнээс 6.45 мг/л-ээр, борын агууламж 0.07 мг/л-ээр тус тус давсан байна. Эрэгцэг нуурын усны хлорын агууламж MNS 4586:1998 стандартад заасан хэмжээнээс 1061.63 мг/л, сульфат 7099.33 мг/л-ээр, усан орчин 0.82-оор, хүнцэл 1.139 мг/л-ээр, хром 0.035 мг/л-ээр, молибден 1.573 мг/л-ээр тус тус хэтэрсэн байна.

Харин 2022 оны БОМТ-ний ОХШХ-ийн хүрээнд гадаргын усны дээжүүдийн шинжилгээний үр дүнгүүдийг холбогдох стандарттай харьцуулахад гадаргын усны хяналт шинжилгээний цэгүүдийн дээжүүдэд зарим элементүүдийн агууламж стандартаас хэтэрсэн байдаг. Энэ нь зарим нуур болон голууд нь тогтмол, урсац байхгүй усны сэлгэлт муу, зөвхөн хур тунадасны усаар тэжээгддэг мөн ойр орчмын айл өрхийн малын өтөг бууцнаас шалтгаалж хэтэрсэн гэж үзэж байна. Ил урсацтай голуудын хувьд 7-10-р саруудад бага зэргийн урсацтай байсан хэдий ч бусад саруудад урсацгүй байсан байна.

2.4. Газрын доорх ус

АЦО-ийн алт, холимог металлын ордыг ашиглах төслийн талбай болон түүний ойролцоох талбайнууд нь газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг тархсан бүсэд хамаардаг. Газрын доорх ус хүртэлх гүн (усны тогтсон түвшин) 30-35 м-ийн хооронд хэлбэлздэгээс үүдэн Дөрөвдөгчийн хурдаснууд болон өгөршсөн ул чулуулгийн хэмжээнд байж болох усаар ханасан бүсийн зузаан нь 10 м-ээс бага байна. Төслийн талбайн газрын доорх усны урсгал нь ерөнхийдөө топографын градиентийн дагуу урсдаг.

Тус төслийн талбайд 2010 онд гүйцэтгэсэн судалгааны дүнгээс үзэхэд цөмийн соронзон резонанс (ЦСР)-ын тандалтын аргаар гүйцэтгэсэн нийт 17 цэгийн 3 цэгт уст үе илэрсэн. 1 цэг дээр 100 метрийн гүний хэмжилтийг хийхэд 20-30 м-т уст үе, 50 м-ийн гүнээр нарийвчлан үзэхэд 20-40 м-т уст үе илэрсэн. Энэ үеийн зүүн талд уст үе багасаж чийгтэй үе болж хувирсан харин баруун талд нь 10-15 м-т уст үе ажиглагдсан. Тухайн уст цэг нь хагарлын ус байж болох бөгөөд уст үеийн гүн рүүгээ цэнгэг байх боломжтой гэж дүгнэсэн байна. Мөн тус компани 2011 оны 6-7 сард Давхарын хөндий нэртэй газар нийт 31 цэгт хэмжилт хийсэн байна.

Судалгаагаар 1-9% усны агууламж бүхий янз бүрийн зузаантай усны давхаргууд илэрсэн. Эдгээрээс хамгийн их устай байж болох 10 цэг байна. Тус хөндийн төвөөр илэрч байсан өндөр усжилттай давхаргын усны агууламж баруун хэсэгт буурсан, зүүн талд усны хэмжээ багассан байна. Эдгээр судалгааны үр дүнд Давхарын Арын хөндийн хурдасд ус агуулагдсан байгааг тогтоосон.

2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай орчим нь Монгол орны хөрсний бүс бүслүүрийн ангиллаар тал хээрийн хүрэн хөрсний бүсэд хамаарагдана. Хойшоо харсан хажууд хар хүрэн, хүрэн хөрс, урагшаа харсан хажууд хүрэн, цайвар хүрэн хөрс голлоно. Гадагш урсгалгүй буурц хонхруудад хужир, марз тогтож түүний эргэн тойронд тогтож мараа мараалаг хөрс зонхилно. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвчийн экологийн нөхцөл (ургамалжилт, газрын хотгор гүдгэр, чийг температурын горим, хөрс үүсгэгч чулуулаг зэрэг)-өөс хамаарч дараах 5 хэв шинж хөрс ялгагдана. Үүнд:

Уулын нимгэн хар хүрэн хөрс:

Хөрсний дээжийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд дээд үедээ урвалын орчин (рН) 6.52 буюу сул хүчиллэг, ялзмаг 3.8%, 100гр хөрсөн дэх хөдөлгөөнт фосфор 2.15мг, солилцох кали 12.5 мг, карбонатгүй. Доод үедээ урвалын орчин 6.75 болж 2.39% ялзмаг, хөдөлгөөнт фосфор 1.98 мг/100г, кали

10.6 мг/100г агуулагдана. Хөрсний зүсэлтийн дагуу элс (2-0.05мм)-ний агууламж 65.9-73.3 %-ийн хооронд хэлбэлзэж, тоос (0.05-0.002мм)-ны хэмжээ 17.6-23.4 %-ийн хооронд хэлбэлзэж, шаварлаг наангилаг хэсэг (<0.002)-ийн хэмжээ 9.2-10.6%-ийн хооронд тус тус хэлбэлзэнэ.

Нугархаг хар хүрэн хөрс:

Ялзмаг 3.59%, карбонатгүй, хөдөлгөөнт фосфор 2.34 мг/100г, кали 13.4мг/100г агуулна. Түүний доод В давхаргадаа 1.86% ялзмагтай, карбонатгүй, хөдөлгөөнт фосфор 0.98 мг/100г, кали 9.4мг/100г агуулна. Хөрсний зүсэлтийн дагуу элс (2-0.05мм)-ний агууламж 63-70.3%, тоос(0.05-0.002мм) 19-27.8 %, шаварлаг наангилаг хэсэг (<0.002) 7.2-10.6%-ийн хооронд тус тус хэлбэлзэж байна.

Зузаан хар хүрэн хөрс:

Ялзмаг 3.09%, карбонатгүй, хөдөлгөөнт фосфор 2.64 мг/100г, кали 10.4 мг/100г агуулна. Түүний доод В давхаргад 2.15% ялзмагтай, карбонатгүй. Хөдөлгөөнт фосфор 2.64мг/100г, кали 10.4мг/100г агуулагдана. Харин С давхаргадаа ялзмаг 1.58%, хөдөлгөөнт фосфор 1.03мг/100г, кали 9.7мг/100г агуулагдана. Зүсэлтийн дагуу элс(2-0.05мм)-ний агууламж 65.9-77.7%, тоос (0.05-0.002мм) 16.1-24.9%, шаварлаг наангилаг хэсэг (<0.002)-ийн хэмжээ 6.3-9.2%-ийн хооронд тус тус хэлбэлзэж байна.

Дүнд зэргийн зузаан, шавранцар, хар хүрэн хөрс:

Ялзмаг 6.11%, хөдөлгөөнт фосфор 1.98мг/100г, кали 12.6мг/100г агуулна. Доод үед 2.08% ялзмагтай, карбонатгүй, хөдөлгөөнт фосфор 1.64мг/100г, кали 11.9мг/100г агуулагдана. Хөрсний зүсэлтийн дагуу элс (2-0.05мм)-ний агууламж 68.9-74.7%, тоос (0.05-0.002мм)-ны хэмжээ 16.1-21.9%, шаварлаг наангилаг хэсэг (<0.002)-ийн хэмжээ 7.7-10.6%-ийн хооронд тус тус хэлбэлзэж байна

Аллювийн нугын хөрс:

Ялзмаг 3.86%, урвалын орчин 8.67 буюу хүчиллэг, хөдөлгөөнт фосфор 2.15мг/100г, кали 9.4мг/100г агуулна. Хөрсний зүсэлтийн дагуу элс (2-0.05мм)-ний агууламж 60.1-65.9%, тоос(0.05-0.002мм)-ны хэмжээ 21.9-24.9%, шаварлаг наангилаг хэсэг (<0.002) 9.2-10.6%-ийн хооронд тус тус хэлбэлзэж байна.

2.6. Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь ойт-хээр, хээрийн бүсийн зааг орчимд хамрагдана. Ургамал ургах тогтмол дулааны хугацаа 150-170 хоног. Хөрсөн бүрхэвчийн хувьд үржил шим сайтай нунтаг карбонатлаг, цайвар элсэнцэр, хөнгөн шавранцар хөрс голлох бөгөөд, гол, горхи нуурын эрэг болон нам дор газартаа марцлаг цайвар шавранцар, хүрэн шаварлаг хөрстэй, уул, толгодын орой, энгэр, хажуу, сайр дагаж чулуурхаг, хайргархаг элсэнцэр цайвар хүрэн хөрстэй ба судалгааны явцад тухайн орчимд нийт 41 овгийн 133 төрлийн 214 зүйлийн ургамал, 8 ландшафт, 12 бүлгэмдлийн 21 дэд бүлгэмдэл тодорхойлогдсон. Ургамлын бүлгэмдлийн хувьд ландшафтын дараах төрлүүд зонхилон тархсан байна.

1. Чийгсүү-чулуусаг хээрийн ландшафт
2. Чийгсүү-хуурайвтар хээрийн ландшафт
3. Чийгсэг, нугархаг хээрийн ландшафт
4. Хуурайсаг (ксерофит)ургамлууд давгайлсан “Е. Дэгнүүлт үетэнт жинхэнэ хээрийн” ландшафт
5. Чийгсүү-намагсаг татмын нугархаг хээрийн ландшафт
6. Чийглэг-марцлаг нугын ландшафт
7. Чийгсүү-давслаг нуур, тойрмын ландшафт
8. Сукацессийн өөрчлөлтөд орсон ландшафт

Талбайн 60-70 %-д ямар нэг хэмжээтэйгээр Хялгана-нангиад түнгэт хээрийн хэвшил оролцсон бэлчээр зонхилно. Хэдийгээр судалгааны талбайд Хялгана голлох боловч Нангиад Түнгийн оролцоо Хялганы бүрхцээс дутахгүй ба зүр өвст хэвшил ч тодорхой хувийг эзэлнэ. Уулын орой энгэр хэсгээр

голчлон чийгсүү-чулуусаг (мезопетрофиты) ургамлуудтай бүлгэмдлүүд зонхилно. Энд “Ботууль (*Festuca lenensis*), Нангиад түнгэ (*Elymus chinensis*), Саман дурваа (*Agropyron cristatum*), Дааган сүүл (*Koeleria macrantha*)” зэрэг хуурайсаг бүлгийн ургамлууд “Үлд өвс (*Orostachys spinosa*), Гэсэрдэй (*Arctogeron gramineum*), Цагаан навчит гичгэнэ (*Potentilla leucophylla*)” зэрэг чийгсүү-чулуусаг алаг өвст ургамлуудтай хамт бүлгэмдэл үүсгэнэ. Уулын арын энгэр хэсгээр Хуурайсаг бүлгийн ургамлууд Чийгсүү хуурайсаг бүлгийн ургамлуудтай зэрэгцэн ургаж, өвөрмөц завсрын “чийгсүү-хуурайсаг” хээрийн ландшафтыг үүсгэнэ.

Уулын бэл хормой чийгийн хангамж сайтай хэсэгт “Чийгсэг, нугархаг” хээрийн ландшафт ажиглагдах ба энд Сибирийн Гүйлс (*Armeniaca sibirica*), Удвал навчит тавилгана (*Spiraea aquilegifolia*), Дагуурын Сарнай (*Rosa dahurica*) зэрэг ургамлууд бүлгэмдэлд сөөгөн эрэмбийн ташинга үүсгэнэ. Эндээс доошлоод нам дор газартаа залгаа орших чийгсэн бүлгийн ургамлууд ургах “Чийгсэг, нугархаг хээрийн” ландшафт ажиглагдана.

Голын хөндийн ландшафт талбайн багахан хэсгийг эзлэх ба энд чийгсүү-хуурайсаг бүлгийн ургамлууд зонхилно. Мөн чийгсүү давссаг нуурын ландшафт ажиглагдах ба тэнд Чийгсүү-давссаг, хуурайсаг-давссаг экологийн бүлгийн ургамлууд зонхилох боловч зарим тохиолдолд ургамалгүй цул элсэн хөрстэй байх нь тааралдана. Түүнээс гадна суксесд орсон ландшафт нэлээдгүй хувийг эзэлнэ.

2.7. Амьтны аймаг

Төслийн талбай нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Монгол дагуурын тойргийн нутагт хамрагдана. Төслийн талбайд 2011 хийсэн төлөв байдлын судалгаагаар 32 зүйл шувуу, 1 зүйл мөлхөгч, 1 зүйл туулай хэлбэртэн, 1 зүйл салаа туурайтэн, 6 зүйл мэрэгчтэн, 3 зүйл махан идэштэн бүртгэгдсэн байна. Эдгээр зүйлүүдэд ховор болон нэн ховор статус бүхий амьтад тодорхойлогдоогүй.

Шувуу: Ажиглалтын явцад махчин шувууны үүр 4 байсан ба бүгд эзэнгүй болсон үүрнүүд байв. Тас, Бүргэд, Элээний үүрүүд байв. Хээрийн махчин шувууд өндөрлөг газар, уулын орой хад асгатай газар, ганц нэгээрээ ургасан моднуудад үүрлэдэг. Ажиглалтын явцад махчин шувуудаас Бүргэд элбэг тархаж байлаа. Шонхор, Элээ, Сар шувууд цөөн тоотойгоор ажиглагдлаа. Хээрийн махчин шувууд нь хээрийн экосистемд чухал байр суурь эзэлдэг. Энэ бүс нутагт монгол оронд түгээмэл тархалттай жижиг шувууд элбэг тархана.

Мөлхөгчид: Судалгааны талбайд ажиглалтад мөлхөгчид үзэгдээгүй бөгөөд махчин шувууны үүрэн доорх идэш тэжээлийн үлдэгдэлд гүрвэлийн үлдэгдэл олдсоныг тодорхойлоход Монгол гүрвэл /*Eremias argus* / хэмээх зүйл байв. Энэ нь тухайн газар монгол гүрвэл тархдагийг харуулж байна.

Туулай хэлбэртэн: Монгол дагуурын хээрт Дагуур огдой хэмээх зүйл элбэг тархана. Дагуур огдой нь ажиглалтын талбайд тавьсан амьд баригчид баригдаагүй боловч тухайн амьтны амьдралын ул мөр болон махчин шувуудын идэш тэжээлд зонхилох байр суурь эзлэх тул огдойн үлдэгдэл, гавал эрүүний яс зэргээр тодорхойлж судалгааны талбайд тархдаг болохыг тогтоов.

Мэрэгчтэн: Судалгааны хугацаанд ажиглагдсан зүйлүүд Монгол тарвага, Дагуур зурам, Монгол оготно, Хөх шишүүхэй, Үлийн цагаан оготно, Шивэр алагдаага гэх мэт эдгээр зүйлүүд тархдаг байна. Ажиглагдаж тэмдэглэгдсэн зүйлүүдээс хамгийн элбэг тархалттай буюу давамгай мэрэгчид нь Хөх шишүүхэй, Монгол оготно, үлийн оготно, цөөн тоотой тархдаг зүйл Дагуур зурам бусад мэрэгчийн зүйлүүд байгаа юм. Харин үлийн цагаан, Сибирь алагдаага, Тарвага зэргийг махчин шувууны идэш тэжээлийн үлдэгдэл, амьдралын түгээмэл ул мөрөөр тодорхойлов. Нэмж хэлэхэд тарвага тухайн судалгааны талбай орчим үзэгдэхээ больж бараг үгүй болсон нь эзэнгүй удсан нүхнүүд нь бараг битүүрсэн байгаагаас үзэхэд тодорхой байгаа юм. Нутгийн иргэдийн хэлж байгаагаар энэ орчим байсан тарвагыг ашиг олохын тулд нутгийн иргэд өөрсдөө болон хулгайн ангийн нөлөөгөөр тоо толгой нь цөөрч үзэгдэхээ больсон гэж байв.

Махан идэштэн: Ажиглалтын хугацаанд Хярс 2, Үнэг 1, тэмдэглэгдэв. Энэ бүс нутагт Үнэг, Хярс, Саарал чоно гэх зүйлүүд элбэг тархдаг гэдгийг нутгийн иргэд ярьцгааж байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Салаа туурайтан: Судалгааны талбайд хамгийн олон тоотойгоор ажиглагдсан нь том хөхтнөөс Цагаан зээр юм. Энэ бүс нутаг нь Цагаан зээр бэлчээрлэх, үржих, өвөлжих гол бүсүүдийн нэг. Судалгааны талбай, түүний ойр орчмын нутаг дэвсгэр нь Цагаан зээрийн нүүдэл, бэлчээрлэх, өвөлждөг гол бүсүүдийн нэг бөгөөд зээрийн хамгийн том сүрэг 1500-3000 орчим байна.

2.8. Түүх соёлын өв

Монгол Улсын "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн 17.10-р заалтыг үндэслэн Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн Шинжлэх ухааны сургуулийн Археологи-Антропологи тэнхимийн магистр археологич “Эко трейд” ХХК -ний захиалгаар археологийн хайгуул судалгааг тухайн үеийн 6727Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд буюу 11 мянган га талбайг хамарсан судалгааг явуулсан.

Судалгааны дүнд нийт 51 дурсгал илрүүлэн бүртгэсэн нь цөм эртний булш оршуулга, байгууламж бүхий дурсгал байна. Хайгуулын явцад лицензийн талбайг хиллэн орших Баян 1, Түмэндэлгэр 6, Салхит 19, Найман ханат 23, Майхант 1 зэрэг уулын энгэр бэлээр байх археологийн дурсгалыг олж илрүүлсэн. (*Хавсралт 5. Археологи, Палеонтологийн ажлын дүгнэлт*)

Хайгуулаар илрүүлсэн археологийн дурсгалуудын байршил, тархалт газар зүйн байдал, гадаргын тогтцоос хамааран харьцангуй жигд тархсан бөгөөд гол төлөв уулын энгэр, наран эвэр газар оршиж байна. Археологийн хайгуул судалгааны үр дүнгээс үзвэл Монголын түүхийн хүрэл зэвсгийн үе, хожуу нүүдэлчдийн үе хүртэл уг нутагт эртний нүүдэлчид оршин амьдарч байсныг тогтоосон.

Судлаачдын дүгнэлтээр уурхайлалтын үйл ажиллагааны төлөвлөлтөөс үзэхэд дээрх дурсгалууд нь нөлөөлөлд өртөхгүй хэдий ч компанийн хариуцлагын хүрээнд ямарваа нэгэн түүх дурсгалын зүйлс олдсон тохиолдолд мэргэжлийн байгууллагуудтай хамтран авран хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсөн байдаг.

2018 онд ашиглалтын тусгай зөвшөөрлийн MV-017111 дугаартай талбай буюу 5462.63 га талбай Археологийн хүрээлэнгийн судлаачид “Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажил”-ыг гүйцэтгэж холбогдох дүгнэлтийг гаргасан болно.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслөөс байгаль орчны бүрдэл хэсгүүд болох газрын гадарга, хэвлий, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал зэрэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННУ-ний тодотгол тайланд нарийвчлан тусгаж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байдаг.

3.1. Газрын гадарга, хэвлий

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг товч дурдвал:

- Барилгажилт, дэд бүтэц барьж байгуулах болон уулын ашиглалтын үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хэвлийн хэлбэр дүрс өөрчлөгдөх
- Шатах тослох материалын агуулах, засварын газар, машины зогсоол зэргээс шатах тослох материал алдагдах, өнгөн хөрсийг бохирдуулах улмаар газрын хэвлийг бохирдуулж болзошгүй.

3.2. Агаарын чанар

Уурхайн талбай дахь овоолго, дэд бүтэц барилгын ажил, ил задгай хөрснөөс хийссэн тоос шороо нь орчны агаарыг бохирдуулах нэг эх үүсвэр болж болзошгүй. Шатахуун түгээх станцын үйл ажиллагаанаас ууршилт үүсэж агаарын чанарт нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Шинж чанар: Хуурайшилт ихтэй улиралд сул хөрс шороо салхинд хийсэж ойр орчны агаарыг тоосоор бохирдуулдаг. Тоос нь нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, ус үл нордгоос нордог хүртэлх хэмжээтэй хөрс, шорооны нийлмэл шинж чанартай байна.

Эх үүсвэр: Овоолго, эвдэрсэн газар, зам талбай. Үржил шимт өнгөн хөрсийг ачих, буулгах, тээвэрлэх, овоолго хийхэд үүсэх тоос.

Тархалт: Уурхай, шатахуун түгээх станц, үйл ажиллагаа явагдаж буй талбайн орчим.

Нөлөөлд өртөх зүйлс: Тоосжилт өндөртэй ажлын байранд байгаа хүмүүс.

3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус

АЦО төсөлд гадаргын усны нөөцийг ашиглахгүй бөгөөд ахуйн усны хэрэгцээг кемпийн худаг, үйлдвэрлэл усны хэрэгцээг Флотацийн шатанд Акватерра компанийн гүйцэтгэсэн судалгааны үр дүнд санал болгосон давхрын арын хөндийд өрөмдөгдөх 2-3 цооногуудаас хангах юм. НУБ-ын технологийн дагуу усны эргэлт битүү системээр явагдах ба тус усыг цооногийн аргаар шүүрүүлэх зориулалт бүхий 1-2 цооногоос хангаж байна.

Хүчтэй хур тунадас болон үерийн үед нуруулдан уусгалтын талбайгаас ирэх уусмал нь баян уусмал цуглуулах санд орох ба баян уусмалын сан нь суларсан уусмалын санд халина. Хэрэв суларсан уусмалын сан нь халивал үерийн санд орох ба сангуудын багтаамж нь Баян уусмалын сан: 9,000м³, Суларсан уусмалын сан: 6,000м³, Хур тунадас цуглуулах сан: 58,000м³ тус тус байна.

Энд дундаж цаг уурын нөхцөл болон 100 жилийн дундаж давталтын интервал зэргийг харгалзан үзэж, мөн төслийн нуруулдан уусгалтын талбайн циклд хэрэглэгдэх усны хэмжээ зэргийг тооцож төлөвлөсөн болно. НУБ-ын технологи нь циклээс гадагш ямар нэгэн уусмал гаргахгүй учир энэ төслийн үйл ажиллагааны явцад гадаргын усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

Хөрс хуулах, шинээр зам гаргах зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэхийн зэрэгцээ түүний үржил шим алдагдах, элэгдэлд өртөх зэргээр сөрөг нөлөө үүсэх боломжтой.

Үргэлжлэх хугацаа: Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд

Шинэ чанар: Шинээр ашиглагдах талбайн үржил шимт хөрс бүрэн хуулагдаж, газрын хэвлийд хонхор үүсэх бөгөөд газрын гадарга дээр овоолго бий болох зэргээр газрын ландшафтын өөрчлөлт бий болно.

Эх үүсвэр: Барилгажилт, дэд бүтцийн үйл ажиллагаа

Үргэлжлэх хугацаа: Энэхүү төлөвлөгөөний хамрах хүрээнд

Нөлөөлөлд өртөх зүйлс: Тухайн орчны хөрс, ургамал, амьтан

3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг

Барилгажилт, дэд бүтэц байгуулах үйл ажиллагаагаар хөрс хуулагдах талбайн ургамал нөмрөгт шууд сөрөг нөлөө үзүүлнэ. Мөн үйл ажиллагаагаар үүсэх тоосжилт нь орчны ургамлын ургалт, өсөлт хөгжилтөд болзошгүй сөрөг нөлөө учруулна. Төслийн ерөнхий үнэлгээгээр нэн ховор статус бүхий амьтан тодорхойлогдоогүй.

Шинэ чанар: Төслийн БОННУ-ээр нэг зүйл ховор ургамал бүртгэгдсэн ба газар хөндөхөөс өмнө тухайн талбайд үзлэг хийж ургамлын зүйлийг тодорхойлж байх шаардлагатай. Төслөөс үүсэх дуу чимээнээс амьтад дайжих, хамгаалалтын хашаа барьснаар бэлчээрийн талбай хумигдах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Эх үүсвэр: Хөрс хуулалт, тээвэрлэлт, хашаа барих, барилгажилт

Үргэлжлэх хугацаа: Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд

Нөлөөлөлд өртөх зүйлс: Тухайн орчны хөрс, ургамал, амьтан

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Степ Голд” ХХК нь “Алтан Цагаан-Овоо” уурхайн үйл ажиллагаа явагдах газар нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг мэргэжлийн байгууллагын судалгаа, түүний үр дүнд тулгуурласан, талуудын оролцоог хангасан хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж мөн нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Бид 2022 онд Уурхайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлангийн судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна,

Уурхайн 2022 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний гол зорилт нь уурхайн олборлолт ашиглалт, хүдэр баяжуулалтын үйл ажиллагаа, химийн бодис тээвэрлэх, хадгалах болон ашиглах, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, барилга бүтээн байгуулалт зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Бид 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн, 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн ажлын хэсэг, Дорнод аймгийн БОАЖГ зэрэг талуудын оролцоог ханган, бидэнд ирүүлсэн санал, зөвлөмж (*Хавсралт 6. Дорнод аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн 2022 оны 01-р сарын 21-ны 78 тоот “Санал хүргүүлэх” тухай албан тоот*) болон Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж зэргийг удирдлага болгож, төслийн үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөсөн болно.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь MV-017111 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай, түүнээс гадна ОХШХ-т багтсан хяналт шинжилгээний цэгүүд хамаарна.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Алтан Цагаан Овоо” Алт, холимог металлын ордыг ашиглах уурхайн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 168 төсөвт болон төсөвт бус арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2022 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар БОМТ-ний биелэлт компанийн дотоод аудитын хэлтсийн үнэлгээгээр 95.8 хувьтай байна. Доорх хүснэгтэд 2022 оны БОМТ-ний хэрэгжилтийг бүлэг тус бүрээр тусгав. БОМТ-ний хэрэгжилттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллүүдийг уг тайлангийн холбогдох бүлгүүдээс харна уу.

Хүснэгт 2. 2022 оны БОМТ-ний биелэлт бүлэг тус бүрээр

№	БҮЛЭГ	БИЕЛЭЛТ
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	94%
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	100%
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	89%
4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	100%
5	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох	100%
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	100%
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	97%
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	89%
9	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	100%
10	БОМТ-2022 хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	89%
11	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт	95.8%

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулах зөвлөмжийн дагуу уурхайн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваасан. Тус бүрэлдэхүүн хэсэг болох агаар, хөрс, гадаргын ба газрын доорх ус, амьтан, ургамал, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн энэхүү төлөвлөгөөг боловсруулсан.

БОННУ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн төслийн 2022 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй 28 сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ бүрд тухайн сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, шаардагдах төсөв, баримтлах стандарт, хуулийн шаардлагыг тусгасан болно.

Тайлант онд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 60 арга хэмжээ төлөвлөснөөс 56 ажлыг хэрэгжүүлсэн буюу тогтмол хэрэгжиж байгаа. Үүнээс 17 ажил бүрэн хэрэгжиж дууссан, үлдсэн 39 ажил нь тогтмол байнга хэрэгждэг арга хэмжээ болно. Үлдсэн 4 ажил хэрэгжиж эхэлсэн бөгөөд бүрэн дуусаагүй ажлууд болно. Тус ажлуудыг бид тайлант жилд багтаан бүрэн хэрэгжүүлж дуусахаар төлөвлөн ажиллаж байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 10-р сарын 31-ны өдрийн байдлаар 94%-тай байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажлуудын биелэлтийн тайлбарыг доорх хүснэгтээс, мөн нотлох баримтыг хавсралтаас харна уу.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Агаар			
1	0%	Уурын зуухнаас гарах угаанд агаарт ялгарах бохирдлын хэмжээг тодорхойлуулах, агаарын бохирдуулсны төлбөрийг төлөх	2021 оны 11-р сарын 08-ний өдрийн 554 дугаартай албан тоотыг 11-р сарын 09-нд Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газарт хүргүүлсэн. Тухайн байгууллага янданд агаар шүүгч байрлуулсны дараа хэмжилтийг гүйцэтгэнэ гэсэн тайлбар өгсөн. Уурын зуухны янданд шүүлтүүр байрлуулах ажлыг гүйцэтгэхээр дотоод төлөвлөгөөнд тусгаад байна.
2	100%	Олон салаа зам гаргахаас сэргийлэх шаардлагагүй замыг хаах, тэмдэг байрлуулах хурдны хязгаар тогтоох, хурд хэмжих багаж худалдан авах	Уурхайн үндсэн замаас зочид хүлээн авах талбай руу чиглэсэн ашиглалтаас гарсан замыг хааж техникийн нөхөн сэргээлт хийсэн. Аюулгүй ажиллагааны хэлтэс хурд хэмжигч багаж худалдан авсан бөгөөд түүгээр автомашинуудын хурдны хэмжилтийг тогтмол хийж ажиллаж байна. (Хавсралт 24. Тээврийн хэрэгслийн хурд хэмжсэн тухай бүртгэл)
3	100%	Хурдны хязгаарыг тогтмол бариулж тээврийн хэрэгслүүд замын хөдөлгөөнд оролцох. Мөн хурдны хязгаарыг хэмжих. /Тусгай хурд хэмжигч багажаар/	Хөнгөн тэрэгнүүдэд хурд хэмжигчтэй радио станц суурилуулсан. Диспетчер тухайн радио станцаар дамжуулан хөнгөн тэрэгнүүдийн хурдыг хянаж, хэмжиж байна. Аюулгүй ажиллагааны хэлтэс хурд хэмжигч багаж худалдан авсан бөгөөд түүгээр хэмжилтийг тогтмол хийж ажиллаж байна. (Хавсралт 24. Тээврийн хэрэгслийн хурд хэмжсэн тухай бүртгэл) \
4	100%	Уурхайн дотоод замыг шаардлагатай үед услах, тоосжилт бууруулах технологийн замуудад Dust lock бүтээгдэхүүн ашиглах	Усны машинаар зам усалгааг тогтмол /өдөрт багадаа 3 удаа/ хийж гүйцэтгэж байна. 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар нийт 11997 м3 усыг зам талбайн усалгаанд ашигласан байна (Хавсралт 8. Засагт Хаан ХХК-ийн зам усалгааны бүртгэл). Автомашинны замын тоос дарах Dustlock бүтээгдэхүүний захиалга, түүний худалдан авалтын төлбөрийг 10-р сарын 7-ний өдөр Эко Сойл ХХК-ний дансруу шилжүүлсэн бөгөөд нийлүүлэгч байгууллага 60 хоногийн дотор уурхайн талбайд нийлүүлэхээр тохирсон. Тухайн тоос дарах бүтээгдэхүүн нь АЦО уурхайн талбайд дээр 12-р сарын 7-ны өдөр багтан ирэх бөгөөд бид ашиглаж эхлэхээр төлөвлөж байна (Хавсралт 72. Нийлүүлэгч байгууллагад төлбөр шилжүүлсэн баримт).
5	30%	Зориулалтын усан буу худалдан авч бутлуур орчимд усалгаа хийх	Усны машинд суурилуулсан мананжуулагч усан буу судалж байна.
6	100%	Агаарын чанарын хэмжилтийг ОХШХ-ийн дагуу гүйцэтгэх	ОХШХ-ийн дагуу сар тутам агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэж байна. (Хавсралт 9. Агаарын чанарын хэмжилтийн хуудас)
7	100%	Цаг агаарын станц худалдан авч цаг уурын мэдээллийн сан бий болгох /Ууршилт хэмжих багаж/	2021 онд худалдан авсан цаг агаарын багаж ашиглалтын явцад эвдэрсэн. Ууршилтыг гар аргаар хэмжиж байна. Тухайлбал 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар АЦО уурхайн талбайд нийт 423 мм хур тунадас орсон байна. (Хавсралт 10. Ууршилт хэмжих хуудас)

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
8	100%	Суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон зуухны төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийх,	Уурхайн засварын хэлтэс хөдөлгөөнт тоног төхөөрөмжид 5000 км тутамд, суурин тоног төхөөрөмжид 5000 мот.цаг тутамд үзлэг хийдэг бөгөөд тайлант жилд 1.Хөдөлгөөнт техникүүдэд 7 хоног тутам төлөвлөгөөт засвар үйлчилгээ, үзлэг 2.Суурин тоног төхөөрөмжүүдэд 7 хоног тутам төлөвлөгөөт засвар үйлчилгээ, үзлэг хийсэн. (Хавсралт 11. Хөдөлгөөнт техник, суурин тоног төхөөрөмжид үзлэг, засвар үйлчилгээ хийсэн хуудас).
9	100%	Түлшний савны хавхлаг битүүмжлэлийг тогтмол хянах, үзлэг хийх	ШТС-ын оператор өдөр тутам холбогдох үзлэгийг хийдэг бөгөөд нийт 292 удаагийн үзлэгийг хийгээд байна. (Хавсралт 12. ШТС-ын операторын өдөр тутмын үзлэгийн хуудас).
10	100%	Шатахуун түгээх станцын орчимд агаарын чанарын хэмжилтийг ОХШХ-ийн дагуу гүйцэтгэх	ОХШХ-ийн дагуу хэмжилтийг тогтмол гүйцэтгэж ажиллаж байна (Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ-ийн бүлгээс харна уу).
11	100%	Нууралдсан хүдэрт шохой холих	Нуруулдсан хүдэрт шохой хольсноор хүдрийн урвалын орчин шүлтлэг болдог бөгөөд энэ нь цианидын уусмалаас синилын хүчил үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлдэг. 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар нийт 2432.8 тн шохой худалдан авснаас нийт 1931.6 тонн шохой нуруулдсан хүдэрт хольсон байна. (Хавсралт 26. Шохой хүлээн авсан бүртгэл)
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Хөрс			
12	100%	Асгаралтаас урьдчилан сэргийлж техник хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хийх, улсын үзлэгт оруулах	Уурхайн засварын хэлтэс хөдөлгөөнт тоног төхөөрөмжид 5000 км тутамд, суурин тоног төхөөрөмжид 5000 мот.цаг тутамд үзлэг хийдэг бөгөөд тайлант жилд 1.Хөдөлгөөнт техникүүдэд 7 хоног тутам төлөвлөгөөт засвар үйлчилгээ, үзлэг 2.Суурин тоног төхөөрөмжүүдэд 7 хоног тутам төлөвлөгөөт засвар үйлчилгээ, үзлэг хийсэн. (Хавсралт 11. Хөдөлгөөнт техник, суурин тоног төхөөрөмжид үзлэг, засвар үйлчилгээ хийсэн хуудас).
13	100%	ШТС-г байнгын хяналтад байлгаж өдөр тутмын хяналтын хуудасны дагуу үзлэг хийх	ШТС-ын оператор өдөр тутам холбогдох үзлэгийг хийдэг бөгөөд нийт 292 удаагийн үзлэгийг хийгээд байна. Энэхүү үзлэгээр ШТС-н тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, гэнэтийн эвдрэлээс урьдчилан сэргийлэх улмаар болзошгүй түлшний асгаралт үүсгэхгүй байх ач холбогдолтой болно (Хавсралт 12. ШТС-ын операторын өдөр тутмын үзлэгийн хуудас).
14	100%	Асгаралтаас урьдчилан сэргийлэх практик болон онолын сургалт зохион байгуулах	Уурхайн талбайд тохиолдож болзошгүй аюул, эрсдэлийн үед авах арга хэмжээний практик дадлага сургуулилтыг 2022 оны 6-р сарын 9-ны өдөр зохион байгуулсан. Тус дадлага сургалтад Дорнод аймгийн Онцгой байдлын газар, БОАЖГ, Хэрлэн голын сав газрын захиргаа, Дорнод аймгийн зарим уурхайн аюулгүй ажиллагаа болон байгаль орчны ажилтнууд оролцсон. Дорнод аймгийн Онцгой байдлын газрын албан хаагч практик сургалтын үед хөндлөнгийн ажиглагчаар оролцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
			хамтран ажилласан. (Хавсралт 13. Онцгой байдлын дадлага сургалтын тайлан
15	100%	Асгаралттай тэмцэх иж бүрдлийн бүрэн байдлын үзлэгийн сар тутам Аюулгүй ажиллагааны хэлтэстэй хамтран гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүрд цэнэглэх	Аюулгүй ажиллагааны хэлтэс болон Байгаль орчны хэлтэс хамтран сар бүр үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд асгаралттай тэмцэх иж бүрдлийн цэнэглэлтийг хийж байна. Өнгөрсөн хугацаанд хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөс 5 удаагийн шатах тослох материалын асгаралт үүсэж тухай бүрд нь асгаралттай тэмцэх иж бүрдлийг ашиглаж арга хэмжээ авсан. (Хавсралт 14. Асгаралттай тэмцэх иж бүрдэл шалгасан хуудас)
16	100%	Техник тоног төхөөрөмжийн ашигласан хаягдал тосыг зориулалтын саванд хуримтлуулах, бүртгэлжүүлэх	Шинэ хог хаягдлын цэгт хаягдал тос хадгалах 25 тонны сав байрлуулж, ашиглаж байна. Энэхүү тайлангийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хэсгээс холбогдох зургийг харна уу.
17	100%	Хаягдал тосыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Өнгөрсөн болон тайлант жилд хуримтлагдсан хаягдал техникийн тос, тосолгооны материалыг уурхайн хог хаягдлын цэгт байрлуулсан 25 тонны танканд юүлж шилжүүлсэн. 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар “Алтан Оршихуй Групп” ХХК-д 20 тонн хаягдал тос, тосолгооны материал нийлүүлээд байна (Хавсралт 68. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгсөн бичиг баримт).
18	100%	Цахилгааны генераторуудаас асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлж тогтмол үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийнэ	Уурхайн засварын хэлтэс суурин тоног төхөөрөмжид 5000 мот.цаг тутамд үзлэг хийдэг бөгөөд 7 хоног тутам төлөвлөгөөт засвар үйлчилгээ, үзлэг хийсэн. (Хавсралт 11. Суурин тоног төхөөрөмжид үзлэг, засвар үйлчилгээ хийсэн хуудас).
19	20%	Төслийн 2 дахь шатны бүтээн байгуулалтын ажлын хүрээнд засварын газартай болох зориулалтын газар засвар үйлчилгээ хийх	Засварын газрын зураг төсөл боловсруулагдаж батлагдсан. 2 дахь шатны барилга байгууламж бүтээн байгуулалтын ажлын хүрээнд тайлант жилд шинэ бутлуурын барих ажил хийгдэж байна. Одоогоор тус ажил дуусаагүй учир засварын газрыг 2023 онд байгуулахаар хойшлуулсан.
20	100%	Барилгын явцад үүссэн хог хаягдлыг төрөлжүүлж ангилан хадгалах, бүртгэлжүүлэх дахин ашиглах боломжтой хаягдлыг /хаягдал мод, төмөр/ өрхийн хэрэгцээнд ашиглах зориулалтаар орон нутгийн малчин иргэдэд олгох	Хог хаягдлыг бүртгэлжүүлж, хог хаягдлын цэгээс нийт 18 л багтаамжтай төмөр торх 6 ш, 60 кг хуванцар, 2 машин мод болон төмөр, 10 ш хувин, 25 ш техникийн хаягдал дугуй зэрэг дахин ашиглах боломжтой хог хаягдлыг орон нутгийн иргэдэд хүлээлгэн өгсөн. Орон нутгийн иргэд нь тухайн дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ахуйн хэрэгцээнд ашиглахаар авсан болно. Мөн 340 м3 орчим ахуйн хог хаягдал, 2750 кг орчим хуванцар сав зайлуулсан байна.
21	100%	Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг хаяхдаа зохих журмын дагуу ангилан ялгаж, хог хаягдлын түр цэгт хаях бөгөөд хэлтэс, нэгж, гэрээт компани бүртгэл хөтөлнө. Ахуйн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ гэрээг сунгаж нийлүүлэх, бүртгэл хөтөлөх	Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-тай гэрээг сунгаж нийт 340 м3 орчим ахуйн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлсэн. /Хавсралт 15. Хог хаягдал зайлуулсан бүртгэл/

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
22	100%	Үндсэн болон гэрээт компанийн ажилчдад SG-ENV-SOP-005-02 Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх устгах журмын сургалт орох	Нийт хэлтэс, гэрээт компаниудын өглөөний наряд зааварчилгаанд очиж 5 удаагийн сургалтаар 66 ажилтанд хог хаягдлын журмын талаар сургалтыг орсон /Хавсралт 16. Сургалт орсон бүртгэлийн хуудас/
23	100%	Химийн бодисын сав баглаа боодлыг түр цэгт хадгалах	Химийн бодисын сав баглаа боодлыг химийн бодисын агуулахын дэргэдэх зориулалтын 40 тонны 2 ширхэг контейнерт түр хадгалан Түмэн Эгшиг ХХК-д хүлээлгэн өгч байна.
24	100%	Химийн бодисын сав баглаа боодлыг устгалт оруулах Түмэн Эгшиг ХХК-д гэрээний дагуу нийлүүлэх	Тайлант жилд Түмэн Эгшиг ХХК-д нийт 5333 ширхэг төмөр торх, 10 принтерийн хор, 0.492 тн канистр, 12.3 тн зэсийн хаягдал уусмал, 23.7 тн хүчлийн хаягдал уусмал тус тус хүлээлгэн өгч устгуулсан байна. /Хавсралт 17. Хог хаягдал зайлуулсан маягт/
25	100%	Шинээр хөндөгдөх газарт, газар хөндөх зөвшөөрөл авч, заавал шимт хөрсийг хуулах, хадгалах, бүртгэлжүүлэх	Тайлант он гарснаас хойш нийт 10 удаа шинээр (шилэн кабел татсан талбай, шинэ бутлуурын бүтээн байгуулалтын талбай, гэрээт компанийн паркийн талбай, ажилчдын кемпийн нөөц худгуудын шугам хоолойн талбай гэх мэт) газар хөндөх үйл ажиллагаа явагдсан бөгөөд нийт 101,025.17 м ² буюу 10.1 га газар хөндөгдсөн.
26	100%	Хөрснөөс дээж авч холбогдох лабораторид шинжлүүлэх, хими, физик шинж чанар, бохирдлыг тодорхойлох	Хөрсний дээжлэлтийг ОХШХ-ийн дагуу улирал тутамд хийхээр төлөвлөсөн. Үүний хүрээнд 1, 2, 3 дугаар улирлын дээжлэлтийг хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ-ийн бүлгээс харна уу.
27	100%	Уусмал хөрсөнд алдагдахаас урьдчилан сэргийлж тогтмол үзлэг хийх	Нуруулдан уусгалт, уусмалын сангийн операторууд өдөр тутам үзлэг, шалгалтыг нуруулдан уусгалтын талбай, уусмалын сангуудад хийж байна. Мөн химийн бодисын агуулахад баяжуулах үйлдвэрийн оператор, химийн мэргэжилтэн өдөр тутам үзлэгийг хийж байна. (Хавсралт 18. Нуруулдан уусгалт, уусмалын сангийн операторын өдөр тутмын үзлэгийн хуудас, Хавсралт 19. Химийн бодисын агуулахын өдөр тутмын үзлэгийн хуудас)
28	100%	Шимт хөрсний овоолго #01-н 1/3 талбайг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах	Шимт хөрсний овоолго #1-н 1/3 талбайг хэлбэржүүлж, ургамалжуулах ажлыг бүрэн хэрэгжүүлж дууссан. Дэлгэрэнгүй мэдээллийг Нөхөн сэргээлтийн бүлгээс харна уу.
29	100%	Шимт хөрсний овоолгод түүсэн нутгийн ургамлын үрээр тариалалт хийх, туршилт судалгааны ажил хийх	Шимт хөрсний овоолго #1-н 1/3 талбайг хэлбэржүүлж, ургамалжуулах ажилд үр үйлдвэрлэгчээс худалдан авсан олон наст ургамлын үр болон нутгийн ургамлаас түүсэн үрийг ашигласан. Дэлгэрэнгүй мэдээллийг Нөхөн сэргээлтийн бүлгээс харна уу.
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Гадаргын ус			
30	100%	Урсацтай байгаа голуудын урсцын хэмжилт хийх, V-Notch байрлуулах	Уурхайн талбайн ойр орчимд байх голуудад тайлант жил хэмжилт хийхээр хэд хэдэн удаа очсон боловч хэмжилт хийхээр урсац бүрэлдээгүй байсан.
31	100%	Урсацтай байгаа голуудын усны дээжлэлтийг тогтсон хугацаанд хийж холбогдох стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллах	ОХШХ-ийн дагуу дээжлэлтийг тогтсон хугаарийн дагуу хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ-ийн бүлгээс харна уу.

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
32	100%	Нуруулдан уусгалтын талбай болон уусмалын сангийн далан, шугам хоолойд тогтмол үзлэг шалгалт хийх	Нуруулдан уусгалтын талбай болон уусмалын сангийн операторууд үзлэг, шалгалтыг өдөр тутам хийж гүйцэтгэж байна. (Хавсралт 18. Нуруулдан уусгалт, уусмалын сангийн операторын өдөр тутмын үзлэгийн хуудас)
33	100%	Газрын доорх усны хяналтын цооногуудаас усны дээжлэлтийг тогтмол хийх	ОХШХ-ийн дагуу энэ оны дээжлэлтийг тогтсон хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ-ийн бүлгээс харна уу.
34	100%	Газрын доорх усны хяналтын цооноогоос авсан шинжилгээний дүнг нэгтгэн улирал бүр аймгийн БОАЖГ-т хүргүүлнэ	ОХШХ-ний дагуу 1, 2, 3, 4 дүгээр улирлын дээжлэлт, хэмжилтийн ажлууд бүрэн хийгдсэн. 2022 оны эхний хагас жилийн ОХШХ-ийн тайланг холбогдох талуудад хүргүүлээд байна. Мөн 4 дүгээр улирлын дээжүүдийн лабораторийн хараахан гарч амжаагүй бөгөөд 4 дүгээр улирлын шинжилгээний үр дүн гарсны дараагаар 3, 4 дүгээр улирлын шинжилгээний үр дүнгүүдийг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэх болно.
35	100%	Уусмалын сангийн түвшний хэмжилтийг гар аргаар тогтмол хийх	Уусмалын сангийн операторууд өдөр тутам хэмжилтийг хийж байна.
36	100%	НУБ болон ашиглалтын цооногт автомат ажиллагаатай түвшин хэмжигч төхөөрөмж суурилуулах, Улсын газрын доорх усны хяналтын мэдээллийн санд оруулах	2022 оны 3-р сарын 15-ны өдөр Нуруулдан уусгалтын талбай болон уусмалын сангийн голд байрлах HL MB 05D цооногт автомат ажиллагаатай түвшин хэмжигч багаж In-Situ Level Troll 400 загварын багаж суурилуулж холбогдох талуудад хүлээлгэн өгсөн. Тухайн багажийн хэмжилтийн мэдээллийг улирал тутамд холбогдох талуудад цахим хэлбэрээр хүлээлгэн өгөхөөр тохиролцсон бөгөөд Улсын газрын доорх усны хяналтын мэдээллийн санд оруулах албан хүсэлт өгсөн болно. (Хавсралт 20. 2022 оны 3-р сарын 15-ны өдрийн автомат түвшин хэмжигч багаж суурилуулж, хүлээлгэн өгсөн тухай албан тоот)
37	100%	Уусмалын сангийн усны түвшнийг 2/3 хэтрүүлэхгүй байх технологийн горимыг холбогдох хэлтэс баримталж ажиллах	Уусмалын сангийн усны түвшин 2/3 хэтрүүлэхгүй байх технологийн горимыг баяжуулах үйлдвэр болон нуруулдан уусгалт, бутлуурын хэлтэс баримталж ажиллаж байна.
38	100%	Шинэ баригдсан бохир ус цэвэрлэх байгууламжийн оролт гаралтаас дээж авч лабораторид шинжлүүлэх	2022 оны 2-р сард цэвэрлэх байгууламжийн оролт болон гаралтаас дээж авч Ус сувгийн удирдах газрын харьяа Усны төв лабораторид шинжлүүлсэн. Тус шинжилгээний хариуг цэвэрлэх байгууламжийг байгуулсан Чимэрүү ХХК-д хүлээлгэн өгсөн байдаг. (Хавсралт 21. 2022 оны 02-р сарын 25-ны өдрийн Шинжилгээний хариу хүргүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн баримт) Мөн ОХШХ-ийн хүрээнд улирал тутам дээж авч, магадлан итгэмжлэгдсэн Хан Лаб лабораториор шинжлүүлж байна.
39	100%	Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тухайн байгууламж хариуцсан ажилтан тогтмол үзлэг хийх, бүртгэлжүүлэх	Бохир ус цэвэрлэх байгууламжийг Пенин ХХК-ний сантехникч хариуцаж, үзлэг, хяналтыг 7 хоног тутам хэрэгжүүлж ажиллаж байна (Хавсралт 67. Бохир цэвэрлэх байгууламжийн үзлэгийн хуудас)
40	100%	Химийн бодис материалын агуулах, ШТС-н агуулахад тогтмол үзлэг хийх	Баяжуулах үйлдвэрийн Химич мэргэжилтэн, ШТС-ын оператор нар өдөр тутам холбогдох үзлэгийг хийж байна. (Хавсралт 19. Химийн бодисын агуулахын үзлэгийн хуудас, (Хавсралт 12. ШТС-ын операторын үзлэгийн хуудас)

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
41	100%	Нуруулдан уусгалтын талбай орчмын хяналтын цооногт 7 хоног бүр усны түвшний хэмжилт хийх	Тайлант он гарснаас хойш нийт 41 удаагийн хэмжилтийг хийгээд байна. 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар хур тунадастай холбоотойгоор түвшин бага зэрэг хэлбэлзэл бүртгэгдсэн (<i>Хавсралт 22. Долоо хоног тутмын газрын доорх усны түвшин хэмжилтийн хуудас</i>)
42	100%	Төслийн ус ашиглах дүгнэлт авах, гэрээ байгуулан ажиллах	Монгол улсын Усны газраас 2022 оны 4-р сарын 6-ны өдөр Дугаар 44 Ус ашиглуулах дүгнэлт, Хэрлэн голын сав газрын захиргаатай 2022 оны 4-р сарын 29-ны өдөр Дугаар 05 Ус ашиглах гэрээг байгуулж, мөн тус өдөр Дугаар А/19 Ус ашиглах зөвшөөрлийг Хэрлэн голын сав газрын захиргаанаас авсан. (<i>Хавсралт 23. АЦО уурхайн Ус ашиглуулах дүгнэлт, Ус ашиглах гэрээ, Ус ашиглах зөвшөөрөл</i>)
43	100%	Уурхай ормчын малчдын гар болон гүний худгийг түвшин хэмжих, усны PH, EC TDS үзүүлэлтээр хэмжих /тухайн хэмжилтийг орон нутгийн 2-р багийн хяналтын хорооны гишүүдтэй хамтран гүйцэтгэх/	Орон нутгийн малчин иргэдийн худгийн түвшин хэмжилтийг 8-р сард хийж гүйцэтгэсэн. Тухайн хэмжилтэд 2-р багийн Хяналтын хорооны гишүүд хамтран оролцсон бөгөөд нийт 102 худагт түвшин болон урвалын орчин, давсжилт, хуурай үлдэгдэл зэрэг хэмжилтийг бүрэн хийсэн (<i>Хавсралт 65. Орон нутгийн иргэдийн худгийн түвшинд хэмжилт хийсэн ажлын тайлан</i>).
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Ургамал			
44	100%	Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх	Засагт Хаан ХХК-ний усны машины зам талбайн усалгааны хуваарийг гаргаж, холбогдох ажилтнуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан. Тус төлөвлөгөөний дагуу тайлант он гарснаас хойш зам талбайн усалгаанд нийт 11,997 м ³ усыг ашиглаад байна. (<i>Хавсралт 8. Засагт Хаан ХХК-ний ус ашиглалтын бүртгэл</i>)
45	100%	Ургамлын мониторингийн цэгүүдэд зүйлийн бүрдэл, биомасс, ургамлын өндөр, тусгаг бүрхэц зэрэг үзүүлэлтээр бичиглэл хийх	ОХШХ-ийн дагуу ургамлын мониторингийн арга хэмжээг нийт 19 цэгт ургамлын зүйлийн бүрдэл, өндөр, тусгаг бүрхэц, биомассын дээжлэлт зэргийг 6 болон 8-р саруудад хэрэгжүүлээд байна. Дэлгэрэнгүй мэдээллийг (<i>Хавсралт 64 Ургамлын мониторингийн ажлын тайлан</i>)-аас харна уу.
46	100%	Хөрс хуулалтын өмнө нэн ховор, ховор ургамлын ажиглалт хийх, газар хөндөх зөвшөөрлийн хуудсыг бөглөх	Тайлант он гарсаар нийт 10 удаа шинээр газар хөндөгдсөн бөгөөд газар хөндөх бүрд байгаль орчны хэлтэс нэн ховор, ховор ургамлын ажиглалтыг хийсэн. Тайлант жилд газар хөндөх үйл ажиллагаанд нэн ховор болон ховор ургамалд байгаагүй болно. (<i>Хавсралт 25. Газар хөндөх зөвшөөрөл хүсэх хуудас</i>)
47	100%	Галын аюулаас урьдчилан сэргийлэх тэнхимийн болон практик сургалт зохион байгуулах, Аймгийн ОБГ, БОАЖГ, МХГ хамтран хийх	2022 оны 6-р сарын 9-ны өдөр Алтан Цагаан-Овоо уурхайн талбайд үүсэж болох аюул, эрсдэлийн үед авах арга хэмжээний практик сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Дорнод аймгийн ОБГ, МХГ, БОАЖГ, Цагаан-Овоо сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч болон Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг Шинь Шинь ХХК-ний төлөөллүүд оролцсон. (<i>Хавсралт 13. Онцгой байдлын сургалтын тайлан</i>)

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
48	100%	Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх	Аюулгүй ажиллагааны хэлтэс галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, галын аюулын үед ашиглах багаж, тоног төхөөрөмжийн үзлэгийг тогтмол хийж байна. (Хавсралт 27. Галын хор, утаа мэдрэгч шалгах хуудас)
49	100%	Төслийн хашаа болон кемпийг тойруулан галын зоон сэргээх	2022 оны 6-р сард төслийн хашаа болон ажилчдын кемпийг тойруулан галын зоон сэргээсэн (Хавсралт 77. Уурхайн хашаа тойрсон галын зоон сэргээсэн байдал). Бид Цагаан-Овоо сумын газар нутагт гарсан тал хээрийн түймрийн дуудлагаар нийт 2 удаа гал унтраах ажилд оролцсон.
50	100%	Шувуу үргээгч ультра соник хэт авианы төхөөрөмжийг шаардлагатай газарт байрлуулах	Тайлант онд нуруулдан уусгалтын талбай, уусмалын сангууд болон баяжуулах үйлдвэр дотор тус бүр 1 ширхэг, нийт 3 ширхэг шувуу үргээгч ультра соник хэт авианы төхөөрөмжийг байрлуулсан. Тухайн тоног төхөөрөмжийг байгаль орчны хэлтсийн ажилчид 7 хоног бүр шалгаж, үйл ажиллагааг хянаж байна (Хавсралт 28. Шувуу үргээгч багаж шалгах хуудас)
51	100%	Төслийн хашаа болон уусмалын сангийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх	Харуул хамгаалалтын алба уурхайн хашаа тойрч эргүүл, хяналтыг 3 цаг тутамд хийдэг. Тухайн эргүүлийн үед аливаа нүх, эвдрэл илэрсэн тохиолдолд тэр дор нь засах, нөхөх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. (Хавсралт 29. Хамгаалалтын албаны өдөр тутмын рапорт)
52	100%	Баяжуулах үйлдвэр дотор шувуу орохоос сэргийлж машин орж гардаг том хаалганаас өнгөгүй хулдаасыг хөшиг байдлаар хаалт хийж унжуулах	Баяжуулах үйлдвэрийн урд талын машин орох хаалганд хулдаасан хөшиг байрлуулсан (Хавсралт 78. Баяжуулах үйлдвэрийн машин орох хаалганд хулдаасан хөшиг байрлуулсан байдал).
53	100%	Үерийн усан санд амьтан орохоос сэргийлж хашаажуулах	Үерийн усан санг бутлуур, нуруулдан уусгалтын хэлтэс бүрэн хашаажуулсан (Хавсралт 30. Үерийн усан санг хашаажуулсан байдал)
54	100%	Газар хөндөхөөс өмнө амьдрах орчны ажиглалт хийх арга хэмжээ авах	Тайлант он гарсаар нийт 10 удаа шинээр газар хөндөх үйл ажиллагаа явагдсан бөгөөд тухай бүрд нь байгаль орчны хэлтсээс амьдрах орчны ажиглалт хийж байна. (Хавсралт 25. Газар хөндөх зөвшөөрөл хүсэх хуудас)
55	100%	Төслийн нийт ажилчдаас амьтан харагдах байдлыг мэдээлэл авах, зэрлэг амьтны мониторинг судалгаа хийх	Уурхайн талбайн нийт ажилчдаас амьтан харагдах байдлын мэдээллийг мэдээллийн хайрцаг болон аман байдлаар авч ажиллаж байна. Тайлант жилд зэрлэг амьтны мониторинг судалгааг 9-р сард хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт 66 “Зэрлэг амьтны мониторинг ажлын тайлан”) -аас харна уу.
56	0%	Зэрлэг амьтны хууль бус үйлдлийн эсрэг ажилчдад сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах /Сумын байгаль хамгаалагч БОХУБч/	АЦО уурхайн биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд жил бүр Цагаан-Овоо сумын нутагт тарвага сэргээн нутагшуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Тус сэргээн нутагшуулсан тарваганы шилжилт хөдөлгөөн, мэнд үлдэлтийн судалгааны ажлыг тарвага сэргээн нутагшуулсан амьтны мэргэжлийн байгууллага Авралын Эрэлд ХХК нь 9-р сард хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны ажлын тайланг мэргэжлийн байгууллага боловсруулж, нутгийн малчин иргэдэд танилцуулахаар төлөвлөж. Энэхүү ажлын хүрээнд 11-р сард зэрлэг амьтны хууль бус үйлдлийн эсрэг сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
57	100%	Ажилчдын тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх нэмж мод, сөөг, зүлэг тарих	Тайлант онд ажилчдын кемп, зочдын талбайн байгууламжийг сайжруулах зорилгоор нийт 1500 м2 талбайд зүлэгжүүлэлт болон цэцгийн мандал тарьсан.
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Газрын гадарга ба хэвлий			
58	100%	Аливаа газар шорооны үйл ажиллагаа явуулах, газар хөндөх ажил хийгдэх үед үржил шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолгыг стандартын дагуу овоолох	Тайлант жилд нийт 10 удаа газар хөндсөн бөгөөд 101,025.17 м2 буюу 10.1 га хөндөгдсөн байна. Үүнээс 38452.1 м3 шимт хөрс хуулж хадгалсан байна (<i>Хавсралт 25. Газар хөндөх зөвшөөрөл хүсэх хуудас</i>).
59	100%	Үүсгэсэн шимт хөрсний овоолгуудаас дээж авч хөрсний агрохимийн чанарын шинжилгээ хийлгэж нөхөн сэргээлтийн стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг үнэлэх	Тайлант жилд нийт шимт хөрсний 6 цэгээс 18 дээж авсан байна. Дээжүүдийг Улаанбаатар хотод байрлах магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг (<i>Хавсралт 61 "ОХШХ-ийн тайлан"</i>)-с харна уу.
60	100%	Шимт хөрсний овоолго, хөндөгдсөн талбай тус бүрд маркшейдэрийн хэмжилт хийж хэмжээг гаргах мэдээллийн санд оруулна	Шимт хөрсний овоолгуудад 10-р сарын 20-ны байдлаар уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш хуулсан нийт 397'566.8 м ³ үржил шимт хөрс овоолж MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна.

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт


Степ Голд ХХК нь хариуцлагатай уул уурхайг дэмжигч байгууллага бөгөөд уул уурхайн нөхөн сэргээлтийг Монгол улсын холбогдох хууль, эрх зүй, стандарт шаардлагуудад нийцүүлэхээс гадна тухайн бүс нутгийн цаг уурын онцлог, орчин нөхцөлд тохирсон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлага арга зүйд тулгуурлан гүйцэтгэхээр ажиллаж байна.

Бидний нөхөн сэргээлтийн ажлын үндсэн зорилго нь стандартын дагуу тухайн ордын геологийн тогтоц, бүс нутгийн байгаль цаг уурын онцлогт нийцүүлэн, уурхайн үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээгээд зогсохгүй байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхөн сэргээлтийн ажлуудыг цогц байдлаар гүйцэтгэхэд оршино. Дээрх зорилгын хүрээнд уурхай эхэлсэн 2018 оноос эхлэн нөхөн сэргээлт рүү чиглэсэн туршилт судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Тайлант жилд бид БОМТ-ний нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд доорх ажлыг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбай
- Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын туршилт судалгаа
- Эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт
- Цианидаар бохирдсон хүдрийн овоолгын нөхөн сэргээлтийн туршилт судалгааны ажил
- Уурхайн талбай, ажилчдын кемпийн ногоон байгууламж

5.2.1. Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбай

Алтан Цагаан-Овоо уурхайн Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайг 2018 онд ажилчдын кемпийн хойно 0.6 га талбайд байгуулж байсан. 2022 онд ажилчдын кемпийн өргөтгөл хийгдэх болсонтой холбоотойгоор тухайн талбайг уурхайн хамгаалалтын хашаа дотор 1 га талбайд шилжүүлсэн (Зураг 10). Тус талбайд чацаргана, далан хальс, тэхийн шээг, бургас, азийн монос, үхрийн нүд, улиас, өрөл зэрэг 8 зүйлийн модлог, сөөглөг ургамлыг хавар, намрын улиралд ялгаатай ургалтын орчинд тариалан туршиж байна. Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайн ерөнхий схем зургыг доорхоос харна уу.



Зураг 10. Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайн схем зураг

Тухайн талбайд бид мод тарихдаа MNS 6258-1:2011 “Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах Ерөнхий шаардлага”, MNS 6258-2:2011 “Мод, сөөгний суулгац арчлах” стандартуудыг баримтлан ажилласан. Тухайн мод үржүүлгийн талбайд нэг зүйл модыг тарихдаа мод хоорондын зайг 1.5 метр, мөр хоорондын зай 2.0 метр байхаар төлөвлөсөн. Мөн дэвсэг хоорондын зай 3.0 метр, нэг дэвсэгт нийт 64 ширхэг мод тарьсан.

5.2.2. Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайн өргөтгөл

Степ Голд ХХК нь Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум Мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн орсон байдаг. Тус хөдөлгөөний хүрээнд 2022-2024 оныг бэлтгэлийн үе шат болгон зарласан. Тухайн хугацаанд мод тарих амлалт авсан байгууллагууд мод үржүүлэг байгуулах, бэлтгэл ажлыг хийхээр төлөвлөсөн байдаг. Үүний хүрээнд Алтан Цагаан-Овоо уурхай нь мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайг өргөтгөх, тус хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудын туршилт судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн. Энэхүү ажлын хүрээнд хуучин мод үржүүлэг, бойжуулгын талбайн зүүн талд 0.5 га талбайд үрээр болон мөчрөөр мод үржүүлэх дэвсэг, шуудуунууд бэлдсэн. Тухайн бэлдсэн талбайнуудад бид бургас, улиасыг мөчрөөр, нарс, чацарганыг үрээр тариалсан. Мөн ухаж бэлдсэн шуудуунд Өрөл, Чацаргана, Монос, Үхрийн нүд зэрэг 4 зүйл жимсний мод, сөөглөг ургамлын 2-3 настай суулгацыг тарьсан.



Зураг 11. Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайн өргөтгөл шуудууг ухаж буй байдал



Зураг 12. Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайн өргөтгөл дэвсэг талбайнуудыг ухаж буй байдал

Тухайн бэлдсэн талбайд 2021 болон 2022 онд бэлдсэн модны тайрдас мөчир болон үр үйлдвэрлэгчээс худалдан авсан нарс, шинэс, байгалийн ургамлаас түүсэн хайлаас зэрэг модны үрүүдийг тарьсан.

Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайн өргөтгөлд тарьсан модны тайрдас мөчрийг Дорнод аймгийн Баяндун, Баян-Уул, Хэрлэн сумдын нутгаас байгалийн модноос тайрч бэлтгэсэн. Тайрдас мөчрийг бэлдэхдээ эх модноос 30 см орчим урттай бэлдэж, 100 ширхгээр багцалж тарилт хүртэл хөрсөнд булсан.



Зураг 13. Байгалийн ургамлаас хайлаас модны үр түүж, цайруулж буй байдал



Зураг 14. Байгалийн модноос тайрдас мөчир бэлдэж буй байдал, бэлдсэн тайрдас мөчрийг тарилт хүртэл газарт булж хадгалж буй байдал

Тайрдас мөчрөөр тарьсан мод:

- Бургас – 2200 ш
- Чацаргана – 900 ш
- Улиас – 1000 ш
- Улиангар – 6000 ш
- Монос – 900 ш

Үрээр тарьсан мод:

- Шинэс – 500 гр
- Нарс – 500 гр


Тухайн талбай, дэвсгүүдийг бэлдэхдээ жижиг экскаватор ашиглан ухсан бөгөөд бууц болон шимт хөрсийг хольж субстрат бэлдэж талбайг буцаан дүүргэсэн.

Бэлдсэн талбайнуудад тайрдас мөчрийг тарихаас өмнө 24 цагийн турш усанд хийж дэвтээсэн. Тарилт хийхдээ тайрдас мөчрийг 45 градус налуулж тарьсан бөгөөд усалгааг тарилтын дараа шууд хийсэн. Усалгааг Монгол улсын холбогдох стандарт MNS 6258-1:2011 дагуу хийсэн.

Шинэс, нарс зэрэг модны үрийг Дорнод аймгийн Баян-Уул сумын ойн мэргэжилтнээс худалдан авч, туршилт байдлаар 7-р сард тарьсан. Энэ нь цаг хугацааны хувьд оройтсон байсан тул ургалтад нөлөөлсөн байж болох юм.



Зураг 15. Бэлдсэн дэвсэгт тайрдас мөчир тарьж буй байдал



Зураг 16. Бэлдсэн дэвсэгт нарс модны үрсэлгээ тарьсан байдал




Зураг 17. тайрдас мөчрөөр тарьсан чацаргана, бургас, улиас ургасан байдал

Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайд тайрдас мөчир болон үрээр тарьсан модны мэнд үлдэлтийн мэдээллийг энэхүү тайлангийн 5.2.7-р бүлгээс харна уу.

5.2.3. Хамгаалалтын ойн зурвас

Степ Голд ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж орсонтой холбоотойгоор хамгаалалтын ойн зурвас байгуулах, доройтсон ойн нөхөн сэргээлт, мод үржүүлэх, бойжуулах гэсэн 3 чиглэлээр ойжуулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн. Энэхүү ажлын хүрээнд туршилт, судалгааны зорилгоор уурхайн талбайн хойд болон баруун талын хашаа дагуулан хамгаалалтын ойн зурвасыг байгуулах ажлыг хийсэн. Хамгаалалтын ойн зурвасын байрлалын зургийг доорх Зураг 18-аас харна уу.



Зураг 18. Хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайн зураг

Тухайн ажлын хүрээнд уурхайн хашааны хойд болон баруун талыг дагуулан нийт 900 метр урт 3 шуудуу бүхий талбайг экскаватор ашиглан ухаж бэлдсэн. Ухсан шуудууны том чулууг түүж, шимт хөрсөөр буцаан дүүргэсэн.



Зураг 19. Хамгаалалтын ойн зурвас хэлбэрийн шуудууг ухаж бэлдсэн байдал

Бидний байгуулсан хамгаалалтын ойн зурвас нь автомашины зорчих хэсгээс шалтгаалан 2 хэсэгт хуваагдсан байдаг. Үүнд:

- Хамгаалалтын пост #4-өөс мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайн баруун хойд булан хүртэл 650 м урт 3 шуудуу байх бөгөөд үүнд нийт 2700 ширхэг улиас модны тайрдас мөчрийг тарьсан.
- Мод үржүүлгийн баруун хойд булангаас урагш чиглэсэн галын зоон дагасан хэсэг 250 метр урт 3 шуудуу бөгөөд үүнд нийт 1000 ширхэг бургас модны тайрдас мөчрийг тарьсан.

Тарилт хийхдээ мод хооронд 70 см, шуудуу хооронд 3 метр зайтай тарьсан.



Зураг 20. Хамгаалалтын ойн зурвасын усалгааны 25 тонны ёмжмост



Зураг 21. Хамгаалалтын ойн зурвасын шуудуунд дуслын усалгааны систем холбосон байдал

Хамгаалалтын ойн зурвасын зүүн буланд 25 тонны цэвэр усны сав байрлуулсан бөгөөд тус саванд хаягдал иметр ашиглаж хийсэн дуслын усалгааны системийг холбосон. Дуслын усалгааны систем нь 3 метр тутамд нүхэлсэн тул тарьсан модны тайрдас мөчирт усалгаа хамгийн ашигтай байдлаар хүрнэ. Усалгааны саванд Засагт Хаан ХХК-ний зам, талбайн усалгааны усны машинаар усыг дүүргэн усалгааг хийж байна.



Зураг 22. Хамгаалалтын ойн зурваст тайрдас мөчрөөр улиас мод ургасан байдал

5.2.4. Эвдэрсэн газрын технологийн нөхөн сэргээлт

Алтан Цагаан-Овоо уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд бид барилгажилтын үйл ажиллагааны үед бий болсон хог хаягдлын түр цэгийг хааж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр тусгасан. Үүний хүрээнд бид 2022 оны 6-р сард хуучин барилгын хог хаягдлын цэгийн хогийг уурхайн шинэ хог хаягдлын түр цэгрүү зөөж, цэвэрлэсэн.



Зураг 23. Барилгын хог хаягдлын түр цэг доторх үлдэгдэл хог хаягдлыг цэвэрлэсэн байдал

Техникийн нөхөн сэргээлтийн арга хэмжээний хүрээнд хуучин барилгын хог хаягдлын түр цэгийг MNS 5916:2008 стандартын дагуу 20-30 см зузаантай шимт хөрсөөр хучиж, гадаргыг хэлбэржүүлсэн. Техникийн нөхөн сэргээлтийг хийхдээ уурхайн олборлолтод ашиглагддаг CAT D8 бульдозер ашиглан хуучин хог хаягдлын талбайд хөмсөг хэлбэрээр байрлуулсан байсан шимт хөрсөөр хучсан.



Зураг 24. Хөмсөг хэлбэрээр байрлуулсан байсан шимт хөрсийг түрж, эвдэрсэн талбайг хучиж буй байдал



Зураг 25. Хөмсөг хэлбэрээр байрлуулсан байсан шимт хөрсийг түрж, эвдэрсэн талбайг хучиж дууссан байдал

Тус нөхөн сэргээлт хийгдсэн барилгын хог хаягдлын түр цэг нь нийт 1956 м² буюу 0.2 га талбайтай бөгөөд ойролцоогоор 400 м³ газар шорооны ажил хийгдсэн.

Тухайн шимт хөрсөөр хучсан талбайг гараар тармуур ашиглан тэгшилж, хөрсийг сийрэгжүүлсэн. Сийрэгжүүлсэн шимт хөрсөн дээр үр үйлдвэрлэгчээс худалдаж авсан соргүй согоовор (*Bromus inermis*), саман ерхөг (*Agropyron cristatum*), царгас (*Medicago falcata*), зэрэг ургамлын үрийг MNS 5916:2008 стандартын дагуу 1 га-д 25 кг үр байхаар нормыг тооцож цацсан. Тухайн талбайд нийт 5-6 кг орчим олон наст ургамлын үрийг ашигласан.



Зураг 26. Хучсан шимт хөрсийг гараар тарааж, хэлбэржүүлэлт хийсэн байдал



Зураг 27. Олон наст ургамлын үр тарьж буй байдал



Зураг 28. Нөхөн сэргээлт хийсэн талбай 2 сарын дараа

5.2.5. Цианидаар бохирдсон хүдрийн овоолгын нөхөн сэргээлтийн туршилт судалгааны ажил

Алтан Цагаан-Овоо уурхайн Байгаль орчны хэлтэс нь 2021 оноос эхлэн Цианидаар уусгалт явуулсан хүдрийн овоолгын нөхөн сэргээлтийн туршилт судалгааны ажлыг эхлүүлсэн. Энэхүү судалгааны ажлын хүрээнд цианидын уусмал өгсөн хүдрийг шимт хөрсөөр хучин ургамалжуулах, хүдрийн овоолгыг усаар эргэлдүүлэн саармагжуулах зэрэг туршилтуудыг хийсэн.

Тайлант жилд бид тус судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийсэн. Энэ жилийн судалгаанд баяжуулах үйлдвэрийн баганаан уусгалтын туршилтаас гарсан 60 ррт орчим цианид концентрацитай хүдрийг авч, мод үржүүлгийн талбайд байрлуулсан. Хүдрийг байрлуулахдаа газрыг доош 50 см ухаж, хөрсөнд нэвчилт үүсгэхгүйн тулд гялгар уутаар битүү хучсан. Байрлуулсан хүдэр дээр 20, 30, 40 см гэсэн 3 төрлийн зузаантай шимт хөрсөөр хучиж, улаан ботууль ургамлыг үрээр тарьсан. Ингэснээр ижил концентрацитай хүдэр дээр 3 өөр зузаан бүхий шимт хөрсөн дээр тарьсан ургамлын ургалт, ургамал доторх химийн элементийн агуулгыг тодорхойлох юм.

Бид 3 өөр зузаан бүхий шимт хөрсөн дээр тарьсан олон наст ургамлаас дээж авч Гацуурт компанийн лабораторид хүнд металл, цианидын шинжилгээ хийлгэхээр өгсөн байгаа бөгөөд шинжилгээний хариу хараахан гараагүй байна. Тус шинжилгээний хариу дээр үндэслэн ургамал цианидыг өөртөө хэрхэн шингээж байгаа, ургасан ургамлын хүнд металлын агууламж, цаашлаад бэлчээрийн зориулалтаар тухайн зүйл ургамлыг ашиглаж болох эсэхийг тодорхойлох бөгөөд бусад модлог, сөөглөг, бэлчээрийн ургамлууд дээр энэхүү судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийнэ.



Зураг 29. Баяжуулах үйлдвэрийн баганаан уусгалтын туршилтаас гарсан 60 ррт орчим цианид концентрацитай хүдрийг байрлуулж, 3 янзаар шимт хөрсөөр хучсан байдал



Зураг 30. Цианидын концентраци бүхий овоолго дээр 10 см шимт хөрс дэвссэн талбайд тарьсан ургамал ургасан байдал



Зураг 31. Цианидын концентраци бүхий овоолго дээр 20 см шимт хөрс дэвссэн талбайд тарьсан ургамал ургасан байдал



Зураг 32. Цианидын концентраци бүхий овоолго дээр 30 см шимт хөрс дэвссэн талбайд тарьсан ургамал ургасан байдал

Дээрх туршилтын үр дүнгээс харахад шимт хөрсний зузаанаас хамааран ургасан ургамлын биомасс харилцан адилгүй өөр байсан. Тухайлбал шимт хөрсний зузаан ихсэх тусам ургамлын биомасс нэмэгдэж байсан.

Мөн тус 3 талбайд ургасан олон наст ургамлын дээжийг шинжлүүлэхээр лабораторид өгсөн. Лабораторийн шинжилгээний үр дүнгээр; ургамал нь шим тэжээлийн бодисыг үндсээр авахдаа хөрсөн дэх цианидын агууламжийг саармагжуулж байгаа эсэх, ургамалд үлдэгдэл цианид байгаа эсэх, ургамалд хүнд металлын агууламж хуримтлагдаж байгаа эсэхийг лабораторийн үр дүнгээр тодорхойлох боломжтой гэж үзэж байна.

Бид дээрх туршилт, судалгааны ажлыг *Heap Leach Solutions* 2022 олон улсын хуралд танилцуулж, хэлэлцүүлэх зорилгоор 2022 оны 8-р сард туршилт судалгааны ажлын өгүүллийг хүргүүлж, хуралд оролцох урилга авсан. Гэвч, компанийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан тухайн хуралд оролцох боломжгүй болсон.

5.2.6. Шимт хөрсний овоолго #1-ийн 1/3-ийг хэлбэржүүлэх

АЦО уурхай нь аливаа зориулалтаар шинээр газар хөндөх тохиолдол бүрд шимт хөрсийг хуулж, шимт хөрсний овоолгод буулган хадгалж байна. Шимт хөрсийг хуулахдаа АЦО уурхайн Техник эдийн засгийн үндэслэл, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд заасны дагуу 20-70 см зузаантай хуулахаар заасан байдаг бөгөөд байгаль орчны хэлтсийн ажилчид тухай бүрд нь хуулах шимт хөрсний зузааныг тодорхойлж байна. Шимт хөрсийг хадгалахдаа MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед

үржил шимт хөрс хуулалт, хадгалалт" стандартын дагуу 5 метрээс дээшгүй өндөртэй овоолго үүсгэн хадгалж байна. Тус стандартын 7.3-д заасны дагуу 2 жилээс дээш хугацаагаар дахин ашиглагдахгүй шимт хөрсний овоолго #1-н тэлэлт хийгдэхгүй хэсгүүд болох нийт 2 га талбайд ургамалжуулалт хийхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан.



Зураг 33. Шимт хөрсний овоолго #1-ийг хэлбэржүүлэх ажил

Тухайн шимт хөрсний овоолго нь 5 метр өндөртэй, 35 градус налуутай байсан бөгөөд налууг 16 градус болгон хэлбэржүүлсэн. Хэлбэржүүлэлтийг уулын олборлолтод ашиглагддаг Caterpillar D8 бульдозер ашиглан хийсэн. Хэлбэржүүлэлтийн арга хэмжээ дууссаны дараа Соргүй согоовор, саман ерхөг, шеллийн бутнуур, хялгана зэрэг байгалийн ургамлаас түүсэн болон үр үйлдвэрлэгчээс худалдан авсан 4 зүйл үрийг хольж 1 га-д 25 кг үрийн нормоор тооцож тарьсан. Үрийн хольцийг тарихдаа гар багаж ашиглан шан татаж, татсан шанд ургамлын үрийг хийсэн. Үүний дараа тармуур ашиглан үрийг хөрсөөр булсан.



Зураг 34. Хэлбэржүүлсэн шимт хөрсний овоолго #1 дээр гар багажаар шан татаж буй байдал

5.2.7. Модны мэнд үлдэлтийн тооллого

“Алтан Цагаан Овоо” алт холимог металлын орд ашиглах төсөл хэрэгжүүлэгч бөгөөд тус уурхайн ирээдүйн нөхөн сэргээлтэд ашиглахад тохиромжтой, бүс нутагт дасан зохицож ургах чадвартай модлог, сөөглөг ургамлыг сонгох, тарих орчин, хугацаа, усалгааны ялгаатай орчинд хэрхэн ургаж байгааг судлах зорилгоор хаалтын нөхөн сэргээлтэд чиглэгдсэн ажлуудыг ашиглалтын үе шатанд эхлүүлэхээр зорин ажиллаж байна. Үүний хүрээнд хэд хэдэн ажлуудыг хэрэгжүүлж байгаа ба

түүний нэг нь мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбай юм. Тухайн мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайд үйл ажиллагаа явуулж буй бүс нутагт ургах боломжтой модлог болон сөөглөг ургамлын зүйлүүдийг орчинд нь ургуулж, харьцуулалт хийснээр ирээдүйн нөхөн сэргээлт болон хаалтын нөхөн сэргээлтэд ашиглахад тохиромжтой, үйл ажиллагааны орчинд ургах чадвартай ургамлыг сонгох боломжтой юм.

Мод үржүүлгийн туршилтын талбай болон салхины хамгаалалтын зурвас байгуулахад шаардлагатай модны тайрдас мөчрийг Дорнод аймгийн Баяндун, Баян-Уул, Хэрлэн сумдын нутгаас байгалийн модноос бэлтгэсэн. Мөн үр үйлдвэрлэгчээс худалдан авсан нарс, шинэс болон байгалийн модноос түүж бэлтгэсэн хайлаас зэрэг модны үрүүдийг тарьсан.

Дараах хүснэгтэд энэ жилийн мод үржүүлгийн талбайд тарьсан модны төрөл, тоо, хэмжээ, тарьсан хэлбэр, амьдралтын хувь зэрэг мэдээллийг тусгасан.

Хүснэгт 4. Мод үржүүлгийн талбайн мэдээлэл

Модны нэр, төрөл	Тарьсан хэлбэр	Тарьсан нөхцөл	Тарьсан тоо, хэмжээ	Амьд модны тоо намар-2022	Амьдралтын хувь
Нарс	2 настай тарьц	Гадаа талбайд Гялгар уугаар хучсан	1900 ширхэг	316	16.6%
Нарс	Үрээр	Гадаа талбайд Гялгар уугаар хучсан	250 гр	0	0%
Нарс	Үрээр	Гадаа талбайд	250 гр	15	0%
Шинэс	Үрээр	Гадаа талбайд Гялгар уугаар хучсан	250 гр	0	0%
Шинэс	Үрээр	Гадаа талбайд	250 гр	15	0%
Хайлаас	Үрээр	Хүлэмжид	400 гр	3000	100%
Хайлаас	Үрээр	Гадаа талбайд	400 гр	1000	33%
Бургас	Тайрдас мөчир	Гадаа талбайд	2200 ширхэг	2200	100%
Чацаргана	Тайрдас мөчир	Гадаа талбайд	900 ширхэг	172	19.1%
Монос	Тайрдас мөчир	Гадаа талбайд	900 ширхэг	72	8%
Улиас	Тайрдас мөчир	Гадаа талбайд	1000 ширхэг	695	69.5%
Улиангар	Тайрдас мөчир	Гадаа талбайд	6000 ширхэг	0	0%


Дээрх хүснэгтэд тусгасан уурхайн талбай дах мод үржүүлгийн талбайн мэдээллүүдээс харахад дараах үр дүн, дүгнэлт гарч байна. Үүнд:

- Шилмүүст модыг үрээр болон 2 настай тарьцаар тарьсан ажлын үр дүн муу байгаа нь тарих арга аргачлалаас шалтгаалсан байх талтай тул цаашид шилмүүст модыг үрээр үржүүлэхэд арга зүйн зөвлөгөө авах үүднээс мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай.
- Навчит модны амьдралтын хувиас харахад тайрдас, мөчрөөр үржүүлэхэд улиас, бургас нь илүү тохиромжтой байна. Жимсний мод болон улиангарыг мөчрөөр тарих нь үр дүн муутай нь харагдаж байна.
- Хайлаасыг үрээр хүлэмжид ургасан хэмжээ нь гадаа талбайд тарьснаас 3 дахин илүү амьдралтын хувьтай байгаа тул цаашид үрээр мод үржүүлэхэд хүлэмжид тарьж ургуулах нь үр дүн сайтай байна.
- Одоогоор мод үржүүлгийн талбайд 4000 ширхэг хайлаасны суулгац, 2200 ширхэг бургасны суулгац, 700 орчим улиасны суулгац хэвийн ургалттай байна.

2021 оны намар нүүлгэн шилжүүлэлтээс үүдэн үхсэн модны суулгацыг нөхөн тарилт хийж суулгацаар тарьсан талбай бүрэн буюу нийт 1,024 модтой болсон. Бид 2022 оны намрын модны мэнд үлдэлтийн тооллогыг 2022 оны 8-р сарын 25-ны өдөр хийсэн. 2021 оны намар үхсэн модны нөхөн тарилтыг бүрэн хийж гүйцэтгэсэн тул энэхүү тооллогоор тухайн нөхөн тарьсан модны мэнд үлдэлтийг тооцсон болно.

Мэнд үлдэлтийн тооллогоор суулгацаар тарьсан нийт 1,024 ширхэг модны 106 ширхэг нь үхсэн буюу мэнд үлдэлт дунджаар 89.6 хувь байна. Суулгацаар тарьсан 8 зүйл модлог, сөөглөг ургамлаас хамгийн их үхэл хорогдолтой байсан зүйл нь үхрийн нүд байна. Энэ нь өмнөх жилүүдтэй ижил, туулай болон жижиг мэргэгчид идсэнээс шалтгаалсан байж болох юм. Суулгацаар тарьсан модны мэнд үлдэлтийг доорх графикаас харна уу.


График 1. 2022 оны намрын мэнд үлдэлтийн тооллого



Харин тайрдас мөчир болон үрээр тарьсан нийт 6,000 модлог болон сөөглөг ургамлын 1984 нь үхсэн буюу мэнд үлдэлт 74.8 хувьтай байна. Тайрдас мөчир болон үрээр тарьсан талбайгаас хамгийн их үхэл хорогдолтой байсан зүйл нь нарс юм. Тухайн нарсyг Дорнод аймгийн Ойн анги Алтан Цагаан-Овоо уурхайн байгаль орчны хэлтэст өгч байсан бөгөөд 1 настай, дунджаар 2 см өндөр бүхий үрээр үржүүлсэн үрсэлгээ байсан. Нийт 1,900 ширхэг үрсэлгээ тарьснаас ердөө 316 ширхэг амьд байсан буюу мэнд үлдэлт 16.6 хувь болно. Тайрдас мөчир болон үрээр тарьсан модлог, сөөглөг ургамлын мэнд үлдэлтийг доорх графикаас харна уу.

Тухайн мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбай нь ирээдүйн нөхөн сэргээлтэд ашиглах модны төрөл, зүйлийг сонгох, Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ирээдүйд тарих модны төрөл зүйл, тарих аргачлалыг тодорхойлох зорилготой хийгдэж буй ажил тул бид жил болгон модны мэнд үлдэлтийн тооллогыг хийж байна.

График 2. Тайрдас мөчир болон үрээр тарьсан модны мэнд үлдэлт



Салхины хамгаалалтын зурвас

- Тус бүр нь 650 метр урттай 3 сувагт нийт 2700 ширхэг улиас модны мөчрөөр бэлтгэсэн тарьцыг тарьж, усалгааг дуслын усалгааны системээр шийдсэн.
- Тус бүр нь 250 метрийн урттай 3 сувагт нийт 1000 ширхэг бургас модны мөчрөөр бэлтгэсэн тарьцыг тарьж, усалгааг зөөврийн байдлаар шийдсэн.
- Нийт 450 метр урттай сувагт модны талбайн хашааг дагуулж хайлаасыг 0.5 метрийн зайтайгаар үрээр усалгаагүй нөхцөлөөр тарьсан.

Уг салхины хамгаалалтын зурвасуудын хувилбаруудаар тарьсан моднууд нь 0.7-1.2 метр хүртэл өсөлт өгч, амьдралтын хувь нь одоогоор улиас 85%, бургас 80% байна. Хашлага байдлаар тарьсан хайлаасны үр нь 100% хувь ургаж соёолсон хэдий ч усалгаагүй нөхцөлөөр тарьсан тул энэ намрын тооллогоор амьдралтын хувь 60% үндэснээс үзүүр хүртэлх өсөлт өгсөн хэмжээ нь дунджаар 8 см байна. Мөн хамгаалалтын зурвасуудын усалгааны шийдэл болон модны төрөл зүйлүүд нь ялгаатай байгаа хэдий ч амьдралтын хувь нь ойролцоо байгаа нь энэ жилийн хур тунадасны хэмжээ өндөр байсан, тухайн бүс нутгаас мөчрөөр тарьцуудыг бэлтгэсэнтэй холбоотой нь ажиглагдаж байна.

Хүснэгт 5. Салхины хамгаалалтын зурвасын туршилтын ажлын мэдээлэл

№	Тарьсан хувилбар	Модны төрөл	Тоо хэмжээ /ш/	Амьдралтын хувь
1	Дуслын усалгааны системтэй тус бүр нь 650 метр урттай 3 суваг	Улиас мөчрөөр	2700	85%
2	Зөөврийн усалгаатай тус бүр нь 250 метр урттай 3 суваг	Бургас мөчрөөр	1000	80%
3	Хашлага байдлаар 450 метр урттай суваг	Хайлаас үрээр	1000	85.7%

5.2.8. Ажилчдын кемпийн ногоон байгууламж

Бид тайлант жилд ажилчдын кемп болон уурхайн зочдын талбайд ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор нийт 2500 м2 орчим талбайд зүлэгжүүлэлт хийсэн. Мөн ажилчдын кемпийн төв оффис, шалган нэвтрүүлэх байрны урд талбайд цэцгийн мандал тарих ажлыг хэрэгжүүлсэн.



Зураг 35. Уурхайн зочдын талбайд зүлэгний үр тарьсан байдал



Зураг 36. Уурхайн зочдын талбайд тарьсан зүлэгний үр ургасан байдал

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Барилгын хог хаягдлын түр цэгт техникийн нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлтийн арга хэмжээний хүрээнд хуучин барилгын хог хаягдлын түр цэгийг MNS 5916:2008 стандартын дагуу 20-30 см зузаантай шимт хөрсөөр хучиж, гадаргыг хэлбэржүүлсэн. Хэлбэржүүлсэн талбайд олон наст ургамлын үрийн хольцыг тарьсан.
2	100%	Шимт хөрсний овоолго #1-н 1/3-г хэлбэржүүлэх	Шимт хөрсний овоолго #1-н 1/3-г хэлбэржүүлж, нийт 2 га талбайд 4 зүйл олон наст ургамлын үрийн хольцыг 1 га-д 25 кг нормтой байхаар тооцож тарьсан.
3	100%	Уурхайн хашаан доторх ашиглахгүй байгаа шороон замд техникийн нөхөн сэргээлт хийх	Уурхайн зочдын талбай руу явсан хуучин замыг хааж, бульдозерын шүдээр сийрэгжүүлж техникийн нөхөн сэргээлт хийсэн. Шаардлагагүй замуудыг хааж тогтсон нэг замаар зорчиж байна.
4	100%	Ашиглалтын болон хайгуулын талбайд өрөмдлөг хийх тохиолдолд тухайн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Геологийн хайгуулын өрөмдлөгийг хийсэн Эрдэнийн Эрэл ХХК нь 2022 оны 9-р сарын 24-ны өдөр өрөмдсөн нийт цооногийг бүрэн нөхөн сэргээж Цагаан-Овоо сумын холбогдох ЗДТГ, байгаль орчны байцаагч, хамгаалагчид хүлээлгэн өгсөн.
5	100%	Шимт хөрсний овоолго #1-н 1/3-г хэлбэржүүлэх түүнд нутгийн ургамал болон үр үйлдвэрлэгчээ худалдан авсан үрээр тариалалт хийх	4 зүйл ургамлын үрийн хольцыг 1 га-д 25 кг нормтойгоор тарьсан.
6	100%	Ашиглалтын болон хайгуулын талбайд өрөмдлөг хийх тохиолдолд тухайн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх	Геологийн хайгуулын өрөмдлөгийг хийсэн Эрдэнийн Эрэл ХХК нь 2022 оны 9-р сарын 24-ны өдөр өрөмдсөн нийт цооногийг бүрэн нөхөн сэргээж Цагаан-Овоо сумын холбогдох ЗДТГ, байгаль орчны байцаагч, хамгаалагчид хүлээлгэн өгсөн.
7	100%	Тэрбум үндэсний хөдөлгөөнд нэгдэн орсонтой холбоотойгоор туршилт судалгааны ажил хийх, ажлын төлөвлөгөө боловсруулах	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум Мод үндэсний хөдөлгөөний төлөвлөгөөнд 2022-2023 оныг бэлтгэл үе шат байхаар тогтсон байдаг. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд бид бэлтгэл ажлыг хангах, туршилт судалгааны ажлыг хийсэн. Тухайлбал мод үржүүлэг, бойжуулгын талбайн зүүн талд 0.5 га талбайд үрээр болон мөчрөөр мод үржүүлэх дэвсгэг, шуудуунууд бэлдсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт 79. АЦО уурхайн Модны тайлан – 2022)-с харна уу.
8	100%	Уурхайн хашааны дагуу 1.6 км урттай ойн хамгаалалтын зурвас байгуулах зорилгоор 3 зүйл ургамлыг туршилт байдлаар тариалах	Уурхайн хашааны хойд болон баруун талыг дагуулан нийт 0.9 км урт 3 шуудуу бүхий талбайг экскаватор ашиглан ухааж бэлдсэн. Бэлдсэн шуудуунуудад улиас модны тайрдас мөчрийг тарьсан. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт 79. АЦО уурхайн Модны тайлан – 2022)-с харна уу.
9	100%	Мод үржүүлгийн талбайд 3 зүйл модлог ургамлыг модлог мөчрөөр үржүүлэх, шилжүүлэн суулгах туршилт хийх	Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайд 2021 болон 2022 онд бэлдсэн модны тайрдас мөчир болон үр үйлдвэрлэгчээс худалдан авсан нарс, шинэс, хайлаас зэрэг модны үрүүдийг тарьсан. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт 79. АЦО уурхайн Модны тайлан – 2022)-с харна уу.
10	100%	Барилгын хог хаягдлын түр цэгийг бүтэн хаах	Хуучин барилгын хог хаягдлын түр цэгийг хааж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.

5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Степ Голд ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Төслийн БОННУ тодотгол тайланг “Мейк Грийн” ХХК 2019 онд хийж гүйцэтгэсэн ба үүнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардал, боломжит хувилбарууд зэргийг тооцсон байдаг. Энэхүү тооцооллын хүрээнд “Алтан Цагаан-Овоо” Алт-холимог металлын үндсэн ордыг ил аргаар ашиглах төсөл нь нийт 11 жилийн хугацаанд олборлолт явуулах ба ашиглалтын 97.5 га талбайгаас үлдэгдэл нөлөөлөл үүснэ гэж тооцсон. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх газрын эвдрэлийн хэмжээ, үлдэгдэл нөлөөллийг тооцоолон дүйцүүлэн хамгаалах газар болон зардлыг The Nature Conservancy, БОНХАЖЯ-ны (хуучин нэрээр) хамтран бүтээсэн Mitigation Design Tool (MDT)-ээр урьдчилсан байдлаар тооцоолсон.


Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд бид байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “Өлзий Энвайронментал” ХХК-тай “Дүйцүүлэн хамгааллын суурь судалгаа гүйцэтгэх”, тус судалгаанд суурилсан “5-н жилийн менежментийн төлөвлөгөө боловсруулах” гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүний хүрээнд “Өлзий Энвайронментал” ХХК нь оролцогч талуудтай Алтан Цагаан-Овоо уурхайн Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээлэл боловсруулах арга зүй боловсруулах, суурин судалгааны ажлуудыг 2020 онд гүйцэтгэсэн. Мөн 2021 онд үргэлжлүүлэн хээрийн судалгаа, хэмжилт зэргийг гүйцэтгэж оролцогч талуудын оролцоог бүрэн хангаж, дүйцүүлэн хамгааллын байршил сонгох зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэний үндсэн дээр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссан.



Зураг 37. Өлзий Энвайронментал ХХК-ийн боловсруулсан Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө болон зорилтот судалгааны ажлын тайлан

5.3.1. Сэргээн нутагшуулсан тарваганы мониторинг

Бид 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Тосон Хулстайн БНГ-т хамаарагдах Цагаан-Овоо болон Хөлөнбуйр сумдын нутагт нийт 100 толгой тарвага нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тус арга хэмжээ нь 2021 оны 6-р сарын 29-өөс 7-р сарын 5-ны өдрийн хооронд хэрэгжсэн. Тус 2021 онд сэргээн нутагшуулсан тарваганы мэнд үлдэлт, нүүдэл, үржлийг тодорхойлох зорилгоор 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд мониторингийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.




Зураг 38. Тосон Хулстайн БНГ, түүний орчимд монгол тарвага сэргээн нутагшуулсан байршил

Тайлант жилд сэргээн нутагшуулсан тарваганы мониторингийн арга хэмжээг 2022 оны 5-р сарын 10-аас 12-ны хооронд амьтны мэргэжлийн байгууллага Авралын Эрэлд ХХК хэрэгжүүлсэн. Энэхүү мониторинг, тооллогын хүрээнд нийт 32 бүлийн 84 монгол тарвага тоологдсон. Мөн тус судалгааны үеэр тарваганы бүлд мөндлийн эзлэх хувийг тодорхойлсон бөгөөд нийт үр дүнгийн хувьд 30%-иас бага гарсан. Энэ нь Тосон Хулстайн байгалийн нөөц газар нутаг дахь Монгол тарваганы популяци эрчимтэй буурсан буюу хэвийн бус, нөхөн үржихүйн тэнцвэрт байдал алдагдсан байна гэж үзэж болохоор байна. (Хавсралт 33. Сэргээн нутагшуулсан монгол тарваганы тооллогын тайлан)

Хүснэгт 7. Монгол тарваганы тооллогын мэдээ

Аймаг	Сумын нэр	Газрын нэр	Нийт бүлийн тоо	Идэвхтэй дошны тоо	Мөндөлтэй бүлийн тоо	Тоологдсон бүх тарваганы тоо	Нэг бүл дэх мөндлийн тоо
Дорнод	Цагаан-Овоо	Тогоруун булаг	24	47	11	64	1.1
	Хөлөнбуйр	Батхаан уул	5	14	5	14	1
		Хавцгайт	3	3	0	6	0

График 3. Тосон Хулстайн БНГ-н нутаг дахь монгол тарвага



5.3.2. Тосон Хулстайн БНГ, түүний орчимд тарвага нутагшуулах ажил - 2022 он

Бид 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тайлант жилд 100 толгой тарвага Тосон Хулстайн БНГ-т нутагшуулах төлөвлөсөн. Тус ажлын хүрээнд бид амьтны мэргэжлийн байгууллага болох Авралын Эрэлд ХХК-тай гэрээ байгуулан, хамтран ажиллалаа.

Тарвага сэргээн нутагшуулах газрыг сонгохдоо амьтны мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүд тарвага өсөж үржих боломжтой, хууль бус хулгайн анд өртөхөөргүй газар нутгийг сонгосон. Сэргээн нутагшуулах газрыг сонгохдоо Цагаан-Овоо сумын засаг даргатай хэрийн уулзалт хийж сонгосон.



Зураг 39. Тарвага сэргээн нутагшуулах газрыг Цагаан-Овоо сумын засаг даргатай хамтран сонгож буй байдал

2022 оны 06-р сарын 28-ны өдөр Тосон Хулстайн БНГ-н газар нутагт хамаарах Цагаан-Овоо сумын Эрээн Толгой нэртэй газарт 80 толгой тарвагыг нутагшуулав. Үүнээс 44 эрэгчин, 36 эмэгчин тарвага байсан. Үлдсэн 20 толгой тарвагыг 07-р сарын 02-ны өдөр мөн Эрээн Толгой нэртэй газарт нутагшуулав. Үүнээс 12 эрэгчин, 8 эмэгчин тарвага байсан. Тарвага нутагшуулах арга хэмжээнд Авралын Эрэлд ХХК, Степ Голд ХХК-ний төлөөлөл, Дорнод аймгийн Цагаан-Овоо сум, Тосон Хулстайн БНГ зэрэг байгууллагуудын төлөөллүүд оролцсон. (Хавсралт 31. Амьтан хүлээлцэх баримт)



Зураг 40. Эрээн Толгой-д тарвага нутагшуулж буй байдал

5.3.3. Цагаан-Овоо сумын 2-р багын Бэлчээрийн мониторинг судалгаа

Дээр дурдсан биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө болон уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд Цагаан Овоо сумын 2-р багт Бэлчээрийн мониторингийн судалгаа хийх, Байгаль хамгаалах нөхөрлөлд бэлчээрийн төлөвлөлтийг сайжруулах сургалт зохион байгуулах ажил тусгагдсан болно.

Тус ажлыг гүйцэтгэх гэрээг Уудам Хангай Сүрэг ТББ-тай байгуулсан. Энэхүү судалгааны ажлын хүрээнд Цагаан-Овоо сумын 2-р багийн газар нутагт зайнаас тандан судлах аргыг ашиглаж бэлчээрийг үнэлэх, бэлчээр ашиглалтын талаар талуудын оролцоог хангаж, хамтран үнэлэх /асуулга, уулзалт/, мөн шаардлагатай газруудад бэлчээрийн хээрийн судалгаа хийх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Бэлчээрийн мониторинг судалгааны үр дүнгээр дараах зүйлсийг тодорхойлох болно. Үүнд:

1. Тухайн бүс нутгийн бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох
2. Бэлчээрт нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, шинжлэх ухааны үндэслэлтэй судлах
3. Бэлчээрийн даац, сэргэх чадавхыг тодорхойлох
4. Бүс нутгийн бэлчээр ашиглалтыг сайжруулах зөвлөмж боловсруулах
5. Үр дүнд тулгуурлан бүс нутгийн байгаль хамгаалах нөхөрлөлд сургалт зохион байгуулах зэрэг болно.

Бэлчээрийн мониторинг судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр 2022 оны 9-р сарын 29-ний өдөр тус байгууллагын 2 ургамал судлаач уурхайн талбайд ирсэн. АЦО уурхайн байгаль орчны хэлтсийн ажилчидтай ярилцсаны үндсэн дээр уурхайн байгаль орчны хэлтсээс 1 хүн хамтран, дагалдан явж орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулах, асуулга, санал авах мөн шаардлагатай газруудад хээрийн судалгаа хийж ажилласан.



Зураг 41. Бэлчээрийн судалгааны хүрээнд орон нутгийн иргэнтэй уулзалт хийж буй байдал

Судалгааны ажлын тайлан одоогийн байдлаар гараагүй боловсруулагдаж байгаа бөгөөд тайлан гарсны дараа холбогдох сургалтыг орно. Холбогдох талуудад тус судалгааны мэдээллийг хүргүүлж, танилцуулан ажиллана. Тус сургалтыг энэ оны 12 сард болох 2-р багийн ИНХ-р зохион байгуулна.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Тосон Хулстайн БНГ болон Цагаан овоо сумын 2-р багийн нутаг дэвсгэрт тарвага сэргээн нутагшуулах	2022 оны 06-р сарын 28-ны өдөр, 07-р сарын 02-ны өдөр нийт 100 тоо толгой тарвага нутагшуулсан.
2	100%	2021 онд тарвага сэргээн нутагшуулсан газарт, байгаль хамгаалах нөхөрлөлийн хамт мониторинг хийх	2022 оны 05-р сарын 10-аас 12-ны өдрийн хооронд 2021 онд сэргээн нутагшуулсан тарваганы тооллого хийж гүйцэтгэсэн. (Хавсралт 33. Сэргээн нутагшуулсан монгол тарваганы тооллогын тайлан)
3	80%	Цагаан-Овоо сумын Ар Хөндлөн эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх	Нөхөн сэргээлтийн байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Тайлант эсвэл дараа жилд багтан тухайн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэнэ.
4	80%	"Бидэр"-ийн булгийн эхийг хашиж хамгаалах	Холбогдох компанитай гэрээ байгуулсан. Тайлант жилд багтаан тухайн ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгана.
5	80%	Шувууны хиймэл үүр, суудал суурилуулах	Холбогдох компанитай гэрээ байгуулсан. Тайлант жилд багтаан тухайн ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгана.
6	80%	2020 онд Тосон Хулстайн БНГ газарт байрлуулсан шувууны суудал, үүрэнд мониторинг хийх, шаардлагатай засварыг хийж холбогдох байгууллагад цаашдын засвар үйлчилгээг хариуцах акт үйлдэн хүлээлгэж өгөх	Холбогдох компанитай гэрээ байгуулсан. Тайлант жилд багтаан тухайн ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгана.
7	100%	Цагаан Овоо сумын 2-р багт Бэлчээрийн мониторингийн судалгаа хийх, Байгаль хамгаалах нөхөрлөлд Бэлчээрийн төлөвлөлтийг сайжруулах сургалт зохион байгуулах	Тус ажлыг гүйцэтгэх гэрээг Уудам Хангай Сүрэг ТББ-тай байгуулсан бөгөөд 2022 оны 9-р сарын 29-ний өдөр Цагаан-Овоо сумын 2-р багийн бэлчээрийн судалгааг хийсэн. Судалгааны ажлын тайлан одоогийн байдлаар гараагүй байгаа бөгөөд тайлан гарсны дараа холбогдох сургалтыг орно.
8	100%	Тосон-Хулстайн БНГ-ийн байгаль хамгаалагчдын эргүүл хяналтын ажилд дэмжлэг үзүүлэх	Тосон Хулстайн БНГ-с 2022 оны 9-р сарын 14-ны 30 дугаар хамтран ажиллах хүсэлт гаргасан. Тухайн хамтран ажиллах хүсэлтэд "Тосон Хулстайн байгалийн нөөц газарт эргүүл хяналт хийх ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх" тухай хүссэн. Бид хүсэлтийн дагуу холбогдох төлбөрийг шилжүүлсэн.
9	80%	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр урд жилүүдэд хийгдсэн ажлуудын бүрэн бүтэн байдал, ашиглалт, үр дүнд хөндлөнгийн хяналт хийлгэж цаашдын ажлыг төлөвлөх	Тус арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагатай гэрээ байгуулсан. Тайлант жилд багтаан хэрэгжүүлнэ.

5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

БОМТ-нд тусгагдсаны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийн 5463 га талбайд өвөлжөө, хаваржааны газар нь давхцалтай айл өрхүүдийн судалгаа 2018-2020 онд хийж “Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох хөтөлбөр”-г хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн айлуудтай хамтран ажиллах гэрээ хийж, нөхөн олговрыг олгосон болно.

Лицензийн талбайд давхцал бүхий 13 айлтай нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг гэрээний дагуу 2017-2020 онуудад бүрэн хэрэгжүүлсэн. 2022 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Төлөвлөгдөөгүй	Лицензийн талбайд давхцал бүхий 13 айлтай нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг гэрээний дагуу 2017-2020 онуудад бүрэн хэрэгжүүлсэн. 2022 онд Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөт ажил төлөвлөөгүй болно

5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус төслийн талбай болон түүний орчимд Сентерра Гоулд Монголиа ХХК-ний захиалгаар улсын хэмжээнд археологийн судалгааг дагнан эрхлэн явуулдаг, зөвшөөрөл олгож, хяналт тавьдаг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага болох Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн “Археологийн нарийвчилсан хайгуулын ажил”-ыг 2010, 2011 онуудад гүйцэтгэж тайлан гаргасан байдаг. Тухайн үед хайгуулын 6727Х дугаартай нийт 11 мянга гаруй талбайд судалгааны ажлыг гүйцэтгэн дүгнэлт гаргаж байсан бол 2018 онд тус хүрээлэнгээр MV-017111 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн 5492,63 га талбайд Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг дахин нарийвчлан хийлгэж дүгнэлт гаргуулсан болно. Тус судалгааны ажлын хүрээнд дээрх талбайнуудад үйл ажиллагаа явуулахад түүх, соёлын биет өвд нөлөөлөхгүй гэсэн дүгнэлт гаргасан байдаг. Бид 2021 оны БОМТ-ний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд Цагаан-Овоо сумын биет болон биет бус өвийг хамгаалах 2 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Алтан Цагаан-Овоо уурхай нь Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг. Цагаан-Овоо сум нь Буриад зон олны оршин суудаг олон сумдын нэг юм. Иймээс бид Буриад зон олны уламжлалт ёс заншил, ахуй амьдрал, эдлэл хэрэглэлийн онцлог, түүнийг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх, сурталчлан таниулах зорилготой “Угай Соёл” төслийг 2021 онд эхлүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төсөл нь Буриад зон олны өвөрмөц болон уламжлалт ёс заншлын талаар баримтат кино, бичлэг хэлбэрээр нэвтрүүлэг бэлдэж, түүнийг ирээдүй хойч үедээ үлдээх зорилготой юм.



Зураг 42. Угай соёл төслийн зураг авалт

Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Биет бус өв рүү чиглэсэн арга хэмжээг сум орон нутагтай ярилцаж хэрэгжүүлэх	Цагаан-Овоо сумын Засаг даргаас Цагаан-Овоо сумын нутаг дэвсгэрт түүх соёлын хүрээлэнтэй хамтарсан судалгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргасан. Тус хүсэлтээр биет бус өврүү чиглэсэн арга хэмжээний төсвийг шилжүүлэн, дээрх судалгааны ажилд санхүүгийн дэмжлэгийн хүсэлт гаргасан байдаг. Бид хүсэлтийн дагуу биет бус өврүү чиглэсэн арга хэмжээний төсвийг шилжүүлж тус ажлын биелэлтийг ханган ажиллалаа (<i>Хавсралт 53. Цагаан-Овоо сумын ЗДТГ-с гаргасан хүсэлт</i>).
2	100%	Буриад зон олны уламжлалт ёс заншил, ахуй амьдрал, эдлэл хэрэглэлийн онцлог түүнийг хадгалах ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх, сурталчлан таниулах “Угай соёл” төслийг үргэлжлүүлэх	“Угай соёл төслийн зураг авалтууд хийгдэж байгаа бөгөөд тайлант жилд багтаан дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

5.6.1. Химийн бодисын эрсдлийн менежмент

Бид Алтан Цагаан-Овоо уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэнэ. Байгаль орчин болон баяжуулах үйлдвэрийн хэлтэс нь уурхайд ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт ашиглалт, түүний хаягдал сав баглаа боодлын устгалд хяналт тавьж аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөг боловсруулан ажиллаж түүний дагуу тавигдах шаардлагуудыг биелүүлэн ажиллаж байна.

Бид Байгаль орчин, Аялал Жуулчлалын яамнаас Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Мөн уурхайн баяжуулах үйлдвэрт ашиглах 11 нэр төрлийн бодист Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах 0001736, 0001737 тоот тусгай зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2020 онд 3 жилийн хугацаатай авсан. Дээрх бодист Монгол улсад ашиглахыг хязгаарласан натрийн цианид багтаж байгаа бөгөөд тухай бодисын зөвшөөрлийг олгохдоо Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн 2019 оны 11-р сарын 29-ны өдрийн №01 тоот зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн олгосон болно.

Химийн бодисын төрөл, хэмжээ

2022 онд дараах төрлийн химийн бодис, урвалжийг ашиглахаар төлөвлөсөн бөгөөд доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 11. 2022 оны химийн бодис, урвалжийн ашиглалтын тооцоо

№	Химийн бодисын нэр	Томьёо	Зөвшөөрөлтэй хэмжээ \тн\	Бодисын үүрэг
1	Натрийн цианид	NaCN	5000	Хүдрээс алт мөнгийг уусгах
2	Натрийн карбонат	Na ₂ CO ₃	20	Хайлуулах процесст шлаг зайлуулах
3	Натрийн хлорид	NaCl	150	Мөнгийг тунадасжуулах
4	Давсны хүчил	HCl	60	Бусад хольцийг салгах
5	Азотын хүчил	HNO ₃	600	Мөнгийг салгах
6	Натрийн гидроксид	NaOH	100	Орчинг тохируулах
7	Кальцийн оксид	CaO	Зөвшөөрөл авах шаардлагагүй	Орчинг тохируулах
8	Сульфаминий хүчил	NH ₂ SO ₃ H	40	
9	Антискалант	-	100	Үйлдвэрийн шугам хоолойг цэвэрлэх
10	Идэвхжүүлсэн нүүрс	C	150	Уусмалаас алтыг шингээх
11	Натрийн тетраборат	Na ₂ B ₄ O ₇	30	Хайлах температурыг буруулах

Мөн засварын цехийн үйл ажиллагаанд зориулж дараах даралтат савласан хийг ашиглана.

№	Даралтат савласан хий	Химийн томьёо	Зориулалт
1	Хүчилтөрөгч	O ₂	Гагнуурын үйл ажиллагаанд
2	Нүүрсхүчлийн хий	CO ₂	Гагнуурын үйл ажиллагаанд
3	Ацетилен	C ₂ H ₄	Гагнуурын үйл ажиллагаанд
4	Пропан	C ₃ H ₈	Гагнуурын үйл ажиллагаанд

Байгаль орчин болон Боловсруулах үйлдвэр нь уурхайд ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт түүний хаягдал болон сав баглаа боодлын устгалд хяналт

тавьж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэн зорилгоор Химийн бодисын агуулах төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан түүнд агуулга нь болон орсон химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг “Эх Монголын Байгаль” ХХК-р гүйцэтгүүлсэний дагуу мөрдөн ажиллаж байна.

Химийн бодисын агуулах, хадгалалт

Химийн бодисын агуулах нь MNS 6458:2014 “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” стандартын дагуу баригдсан бөгөөд тухайн барилга байгууламжид Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2019.08.22-ны №01-06-079/346 тоот дүгнэлт авсан байдаг.

Алтан цагаан овоо төслийн баяжуулах үйлдвэрт 11 нэр төрлийн химийн бодис ашиглаж байна. Үүнээс 10 нэр төрлийн химийн бодисыг тухайн агуулахад хадгалж байна. Тэдгээрийн 3 нь шингэн, 7 нь хатуу төлөвтэй байх, ба бусад нэг химийн бодис болох кальцийн оксид (шатаасан шохой) /CaO/ агуулахад хадгалах шаардлагагүй. Бид химийн бодисын зөвшөөрлийн асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас хуулийн дагуу авсан. Нийт 400 тонны даацтай химийн бодисын агуулах нь тус бүр 40 тонны даацтай 10 ширхэг контейнер агуулахыг ашиглаж байна.

Химийн бодисын агуулахад хадгалан ашиглаж буй химийн бодисын ашиглалтын тоо хэмжээнээс хамааран агуулахын нийт багтаамжийн 60%-ийг ашиглаж байна. Химийн бодисын агуулахад тавигдах стандарт MNS 6458:2014-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулж холбогдох үзлэг шалгалтуудыг химийн бодисын шинж чанараас хамаарч өдөр болгон эсвэл долоо хоногт нэг удаа гэсэн давтамжтайгаар явуулж байна.

Бид уурхайн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, химийн бодисын нөөцийг хангалттай байлгах зорилгын дагуу химийн бодисын агуулахыг өргөтгөх ажлыг тайлант жилд хийж эхэлсэн. 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа бүрэн дууссан. Улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлтийг холбогдох байгууллагуудад өгсөн, мөн БОННУ-ний нэмэлт тодотгол тайланг батлуулсан. Тухайн ажлын хүрээнд дахин 10 ширхэг 40 тонны контейнер байрлуулсан бөгөөд тус талбай нь мөн адил MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангасан асгаралт, гал болон байгалийн гамшгаас сэргийлсэн шийдэл, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.



Зураг 43. Химийн бодисын агуулахын өргөтгөл

Химийн бодисын ашиглалт

Бид баяжуулах үйлдвэрт 2022 оны 10-р сарын байдлаар дараах нэр төрлийн бодисыг ашигласан байна. Доорхоос харна уу.

Хүснэгт 12. 2022 оны 6-р сарын байдлаарх баяжуулах үйлдвэрт ашигласан химийн бодисын хэмжээ

№	Химийн бодисын нэр	Томьёо	Зөвшөөрөлтэй хэмжээ \тн\	10-р сарын байдлаарх хэрэглээ \тн\
1	Натрийн цианид	NaCN	5000	187.6
2	Натрийн карбонат	Na ₂ CO ₃	20	0.36
3	Натрийн хлорид	NaCl	150	0.65
4	Давсны хүчил	HCl	60	17.8
5	Азотын хүчил	HNO ₃	600	14.36
6	Натрийн гидроксид	NaOH	100	21.9
7	Кальцийн оксид	CaO	Зөвшөөрөл авах шаардлагагүй	1931.6
8	Сульфаминий хүчил	NH ₂ SO ₃ H	40	0.13
9	Антискалант	-	100	4.23
10	Идэвхжүүлсэн нүүрс	C	150	25
11	Натрийн тетраборат	Na ₂ B ₄ O ₇	30	0.07
12	Цахиурын исэл	SiO ₂	15	0.046

Химийн бодисын сав, баглаа, боодлын хог хаягдал

Бид тайлант жилд химийн бодисын сав, баглаа, боодлыг холбогдох журмын дагуу ангилан ялгаж, тусгай контейнерт цуглуулж, аюултай хог хаягдал тээвэрлэх, шилжүүлэх гэрээний дагуу Түмэн Эгшиг ХХК-д нийлүүлж байна (Хавсралт 34. Түмэн Эгшиг ХХК-тай байгуулсан гэрээ).

Тус байгууламж нь 40 тонн багтаамжтай, 2.5 х 12 м харьцаатай, 2.7 метрийн өндөртэй, химийн бодисын агуулахын хойд талд байрлаж байна. Аюултай хог хаягдлыг ямар бодис агуулж байсан шинж чанараас хамаарч материалын аюулгүй байдлыг мэдээлэх хуудсанд заасны дагуу ус болон нэмэлтээр шаардлагатай саармагжуулах бодис хийж саармагжуулсан.

Тайлант хугацаанд 12 нэр төрлийн химийн бодис ашигласнаас түүний сав баглаа боодлын хаягдал нийт 3251.5 кг, натрийн цианидийн гаднах төмөр торх 5333 ш, 23731 кг хүчлийн үлдэгдэл гарсан байна. Химийн бодисын хог хаягдлыг Түмэн эгшиг ХХК-д нийлүүлж байна (Хавсралт 35. Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлын бүртгэл).

Саармагжуулах үйл ажиллагааг химийн бодисыг агуулахаас баяжуулах үйлдвэрлүү тээвэрлэлт хийж байгаа баяжуулах үйлдвэрийн оператор болон химийн бодисын мэргэжилтэн нар хамтран гүйцэтгэж байна. Жишээлбэл: химийн аюултай болон хортой бодисын сав баглаа боодлыг дараах аргуудаар хоргүйжүүлнэ. Үүнд:

- Натрийн цианидын сав баглаа боодлыг үлдэгдэл бодисыг сайтар цэвэрлэн, зориулалтын контейнерт хадгалж байна.
- Хүчил агуулсан химийн бодисын сав баглаа боодлыг усаар 3 удаа зайлж, харин их хэмжээний үлдэгдэлтэй байвал саармагжуулан хоргүйжүүлэн хадгална.

Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, сав, баглаа, боодлын хадгалалт зэргээс үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Химийн бодисын менежментийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх хүснэгтээс харна уу.

5.6.2. Бусад осол эрсдэлийн менежмент

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.6, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйл, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд болон Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/231, А/368 дугаартай хамтарсан тушаалаар

батлагдсан “ИЛ УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ”-ийн 5 дахь заалт болон СТЕП ГОЛД ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 7.9, 7.18 дахь заалт, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны сайдын 2019 оны 12-р сарын 13-ны өдрийн А-370 тоот тушаал, “СТЕП ГОЛД ХХК”-ийн Алтан Цагаан-Овоо уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Осол эрсдэлийн менежментийн “Уурхайн талбайд тохиолдож болох болзошгүй ослын үед авч хэрэгжүүлэх практик, Дадлага сургуулийг Дорнод аймгийн Зүүн бүсийн төв Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Шинь Шинь ХХК-ийн 2 мэргэжилтэн, Цагаан-Овоо сумын төлөөллүүдийг оролцуулж хамтран зохион байгуулж ажилласан (Хавсралт 13. Онцгой байдлын дадлага сургалтын тайлан).



Зураг 44. Сургалтыг оролцсон орон нутгийн байгууллагын төлөөллүүд

Сургалтын хүрээнд хэрэгжсэн онцгой байдлын үеийн практик үзүүлбэрүүдийг доороос харна уу. Үүнд:

- Өндөрт дүүжлэгдсэн хүнийг аврах
- Ковидын хяналт, ариутгал
- Цианидтай уусмалын санд унасан хүн аврах
- Хязгаарлагдмал орчноос хүн аврах
- Хяналттай орчинд цианидын уусмалын хоолой задрах, хариу арга хэмжээ
- Химийн бодисын тээвэрлэлтийн үе дэх асгаралт, түүний хариу арга хэмжээ
- Байгууламжийн гал унтраах

Энэхүү сургалт нь бүрэн хяналттай орчинд, аюулгүй ажиллагааны хэлтсийн ажилчдын хяналтын дор явагдсан бөгөөд сургалтын практик үзүүлбэрүүдэд цианидтай уусмалын оронд цэвэр ус, цианид асгаралтан дээр шохой ашиглах, өндөр болон уусмалд хүн унаж буй үзүүлбэрт манекен буюу хиймэл хүн ашигласан болно.



Зураг 45. Сургалтын уусмалын санд унасан хүнийг аврах болон анхны тусламж



Зураг 46. Уусмалын хоолой задрах болон цианидын асгаралтын үеийн сургалтын арга хэмжээ



Зураг 47. Байгууламжийн гал унтраах сургалтын арга хэмжээ

5.6.3. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Бид химийн бодис, материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглах мөн хаягдал сав баглаа, боодлыг зайлуулахдаа Хор аюулын лавлах мэдээлэл (MSDS) хуудсанд зайлуулахдаа материалын аюулгүй ажиллагааны хуудсанд тусгагдсаны дагуу гүйцэтгэнэ.

Төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчны бүрдэл хэсэг болох хөрс, ус, ургамлын нөмрөг, амьтны аймагт химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, сав баглаа бодлын устгалаас үүдэлтэй болзошгүй нөлөөлөл нь ихэнхдээ аюулгүй ажиллагааны заавар, журам, технологийн ашиглалтын горим алдагдах, гэнэтийн осол аваар, байгалийн гамшигт үзэгдэл тохиолдох зэргээс

шалтгаалан шууд болон дам байдлаар нөлөөлөх магадлалтай юм. Бид энэхүү эрсдэлээс сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Тайлант жилд 5 удаагийн сургалтаар 66 хүнд журмын зааварчилгаа (Хавсралт 16. Байгаль орчны журмын сургалтын бүртгэл), 123 удаагийн сургалтаар 647 хүнд ерөнхий зааварчилгаа өгсөн байна (Хавсралт 36. Байгаль орчны сургалтын бүртгэл).
- Баяжуулах үйлдвэрт, химийн бодистой харьцаж ажиллаж буй ажилчдад химийн бодис асгарахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон өөрийн аюулгүй байдлын тухай сургалтыг зохион байгуулсан (Хавсралт 37. Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчдын сургалтын бүртгэл).
- Химийн бодисын хаягдал, сав баглаа боодлыг ангилан ялгаж, баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулах дотор тусгай 2 ширхэг контейнерт хадгалж байна. Тухайн аюултай хог хаягдлыг Түмэн Эгшиг ХХК-тай гэрээ байгуулан (Хавсралт 34. Түмэн Эгшиг ХХК-тай байгуулсан гэрээ) 2022 оны 10-р сарын 20-ны байдлаар сав баглаа боодлын хаягдал нийт 3251.5 кг, натрийн цианидийн гаднах төмөр торх 5333 ш, 23731 кг хүчлийн үлдэгдэл, 10 ширхэг принтерийн хор устгуулаад байна (Хавсралт 17. Түмэн Эгшиг ХХК-д хүлээлгэн өгсөн аюултай хог хаягдлын дагалдах бичиг)
- Тайлант жилд уурхайн анхны тусламжийн цэгээс нийт 62 кг эмнэлгийн аюултай хог хаягдал гарсан. Тухайн аюултай хог хаягдлыг Цагаан-Овоо сумын эмнэлэгтэй байгуулсан эмнэлгийн аюултай хог хаягдал устгуулах гэрээний хүрээнд хүлээлгэн өгч устгуулсан байдаг (Хавсралт 38. Эмнэлгийн аюултай хог хаягдал устгах гэрээ).
- Уурхайн талбайд байрлаж буй дизель генераторуудад зориулсан 5 асгаралттай тэмцэх цэг, нуруулдан уусгах байгууламжид зориулсан 1 цэг, уусмалын сангуудад зориулсан 1 цэг, шатахуун түгээх станцад зориулсан 2 цэг, явуулын байдлаар ашиглах чиргүүлтэй асгаралттай тэмцэх иж бүрдэл 1-ийг байгуулсан.

Хүснэгт 13. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Уурхайн аваар устгах төлөвлөгөө боловсруулж, холбогдох газраар батлуулж, нийт ажилчдад сургалт орох	Алтан Цагаан-Овоо уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. (Хавсралт 39. Гамшигаас хамгаалах төлөвлөгөө)
2	100%	Уурхайн талбайд тохиолдож болох болзошгүй ослын үед авч хэрэгжүүлэх практик сургалтыг Дорнод аймгийн ОБГ, БОАЖГ, МХГ, Цагаан-Овоо сумын төлөөллүүдийг оролцуулж хамтран зохион байгуулах	Уурхайн талбайд тохиолдож болох болзошгүй ослын үед авч хэрэгжүүлэх практик сургалтыг Дорнод аймгийн Зүүн бүсийн төв Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Шинь Шинь ХХК-ийн 2 мэргэжилтэн, Цагаан-Овоо сумын төлөөллүүдийг оролцуулж хамтран зохион байгуулж ажилласан (Хавсралт 13. Онцгой байдлын дадлага сургалтын тайлан).
3	100%	Химийн бодисын эрсдэлийн төлөвлөгөө боловсруулж, аймгийн ОБГ батлуулах, нийт ажилчдад танилцуулж сургалт орох	Алтан Цагаан-Овоо уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ОБЕГ-ын дэргэдэх Уул уурхайн аврах ангийн захирагчаар батлуулсан (Хавсралт 40. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө).
4	100%	Натрийн цианидыг Улаанбаатар хотын гаалийн баталгаат агуулахаас уурхай руу тээвэрлэхтэй холбогдох төрийн байгууллагаар маршрутыг батлуулж, тээвэрлэлтийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэх	Тайлант жилд уурхайн талбай руу нийт 13 удаагийн натрийн цианидын татан авалт хийгдсэн байдаг. Тээвэрлэлт тус бүрд маршрутыг Цагдаагийн Ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвөөр батлуулж, тээвэрлэлтийг тусгай зөвшөөрөлтэй компани болох “Брайт транс” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн (Хавсралт 41. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьсан илтгэх хуудас).
5	100%	Натрийн цианидын тээвэрлэлт оролцох багийн гишүүдэд аюулгүй ажиллагааны сургалт орох	Натрийн цианидын тээвэрлэлт бүрд багийн гишүүдэд сургалт орсон. (Хавсралт 42. Сургалт орсон бүртгэлийн хуудас)

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
6	100%	Натрийн цианид тээвэрлэх явцад үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлж онц байдлын үед ашиглах багц иж бүрдэлтэй болох түүнийг тээвэрлэлтийг явцад байнга авч явах	Натрийн цианидын тээвэрлэлтэд онцгой байдлын иж бүрдлийг тогтмол авч явдаг. (Хавсралт 43. Тээвэрт ашиглах бараа материалын жагсаалт)
7	100%	Тээвэрлэлтийн явцад тухай бүрд ачааны бэхлэгээг шалгаж тэмдэглэл хөтлөх	Тээвэр эхлэхээс өмнө ачаа ачсан чингэлэгт ХАБЭА-н хэлтсийн ажилтан цоож пайзыг зүүж лац тавьдаг (Хавсралт 44. Ачаа бэхлэгээг шалгах хуудас).
8	100%	Химийн бодисын агуулахаас бодис үйлдвэрлүү тээвэрлэхдээ асгаралтаас урьдчилан сэргийлж ажиллах, операторг сургалт орох, заварчилгаа өгөх	Баяжуулах үйлдвэрт ажилладаг операторуудад өдөр тутмын зааварчилгаа болон химийн бодисын сургалт орсон. (Хавсралт 37. Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчдын сургалтын бүртгэл)
9	100%	Химийн бодисын татан буулгалтын үед сумын байгаль хамгаалагчийг байлцуулах хамтран ажиллах	Химийн бодисын татан буулгалтын үед сумын байгаль хамгаалагч эсвэл байгаль орчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан хяналт тавьсан (Хавсралт 41. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьсан илтгэх хуудас).
10	100%	Химийн бодисын агуулахад химийн бодисыг байршуулах, хадгалахад хамт хадгалах дүрмийг баримтлах	Химийн бодисын агуулахад химийн бодис хадгалах журмын дагуу химийн бодис хариуцсан мэргэжилтэн өдөр бүр агуулахад үзлэг хийдэг. (Хавсралт 45. Химийн бодисын агуулахад хийгдэх үзлэгийн хуудас)
11	100%	Баяжуулах үйлдвэрийн операторуудыг сэрээт өргөгчийн онол болон дадлагын сургалт, мөн гүүрэн краны давтан сургалтад хамруулах үнэмлэхийг сунгах	Баяжуулах үйлдвэрийн операторууд гүүрэн краны сургалтад 2021 оны 10-р сард мэргэжлийн сургалтын төвтэй хамтран сургалтад хамруулж үнэмлэхийг сунгасан (Хавсралт 46. Гүүрэн краны үнэмлэх). Сэрээт өргөгчийн сургалтад 2022 оны 03-р сарын 14-ны өдөр сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан (Хавсралт 47. Сэрээт өргөгчийн мэргэжлийн үнэмлэх).
12	100%	Химийн бодисын хадгалалтын үеийн горимыг хянах зорилгоор төлөвлөгөөт агуулахын үзлэг шалгалтыг байнга явуулж байх	Химийн бодисын агуулахад химийн бодис хадгалах журмын дагуу химийн бодис хариуцсан мэргэжилтэн өдөр бүр агуулахад үзлэг хийдэг. (Хавсралт 45. Химийн бодисын агуулахад хийгдэх үзлэгийн хуудас)
13	100%	Даралтат савласан хийг хүлээж авах шаардлагын дагуу хүлээн авч, ашиглах нөхцөлүүдийн дагуу ашиглах	Засварын хэлтэст гагнуурын үйл ажиллагаанд ашиглаж буй даралтат савласан хийг хүлээн авч, зориулалтын саванд хадгалж ашиглаж байна.
14	100%	Химийн бодисын тэмдэг тэмдэглэгээг гэмтсэн салсан тохиолдолд яаралтай дахин шинэчлэн наах	Тайлант жилд энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага үүсээгүй болно.
15	100%	Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх, зарцуулалтын тайланг холбогдох байгууллага руу илгээх	Химийн бодисын ашиглалтын тайланг улирал бүр Дорнод аймгийн БОАЖГ-ын орчны бохирдол, химийн бодис, байгаль орчны үнэлгээ хариуцсан мэргэжилтэн рүү цахимаар илгээж байна (Хавсралт 48. Химийн бодисын ашиглалтын 2-р улирлын тайлан).
16	100%	Дүүжин кран аюулгүй ажиллагааны хүрээнд баталгаажуулалт хийх	2021 оны 08-р сарын 02-ны өдөр Монкран консалтинг ХХК-иар баталгаажуулалт хийлгэсэн байдаг. Уг баталгаажуулалтын хугацаа дуусах үед дараагийн баталгаажуулалтыг хийлгэнэ (Хавсралт 49. Гүүрэн краны баталгаажилтын дэвтэр).
17	100%	Химийн бодистой харьцаж ажиллагсдын давтан сургалтыг зохион байгуулах	2022 оны 06-р сарын 18-ны өдрөөс 07-р сарын 03-ны өдрийг хүртэл Монголын химич, химийн инженер, технологичдын холбоотой хамтран химийн бодисын сургалтыг зохион байгуулсан. (Хавсралт 50. Химийн бодисын сургалтын бүртгэл)
18	100%	Химийн бодисын урвалж бэлтгэх, найруулах давтан сургалт баяжуулах үйлдвэрийн операторуудад орох	Баяжуулах үйлдвэрт ажилладаг операторуудад химийн бодисын давтан сургалт орсон. (Хавсралт 37. Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчдын сургалтын бүртгэл)

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
19	100%	Баяжуулах үйлдвэрийн операторуудад асгаралтын үеийн иж бүрдлийг ашиглах болон асгаралттай тэмцэх дадлага сургалтыг зохион байгуулах	“Уурхайн талбайд тохиолдож болох болзошгүй ослын үед авч хэрэгжүүлэх практик, Дадлага сургуулийн нэг хэсэг болж зохион байгуулсан. (Хавсралт 13. Онцгой байдлын дадлага сургалтын тайлан).
20	100%	Химийн бодисын сав баглаа боодлыг хадгалах, хоргүйжүүлэх, устгах журмын дагуу аюулгүй хадгалах	Химийн бодисын агуулахын дэргэдэх зориулалтын 40 тонны 2 ширхэг контейнрт түр хадгалж байна.
21	100%	Химийн бодисын сав баглаа боодлын үүсгэсэн хугацаа, тоо хэмжээ, жинг нэг бүрчлэн бүртгэх	Баяжуулах үйлдвэрийн химич мэргэжилтэн 7 хоног бүр химийн бодисын сав баглаа боодлын бүртгэлийг хийж ажиллаж байна. (Хавсралт 35. Химийн бодисын сав баглаа боодлын бүртгэл)
22	100%	Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай ачаа хүлээн авагч буюу аюултай хог хаягдал устгуулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх	2022 оны 10-р сарын 20-ны байдлаар сав баглаа боодлын хаягдал нийт 3251.5 кг, натрийн цианидийн гаднах төмөр торх 5333 ш, 23731 кг хүчлийн үлдэгдэл, 10 ширхэг принтерийн хор устгуулаад байна (Хавсралт 17. Түмэн Эгшиг ХХК-д хүлээлгэн өгсөн аюултай хог хаягдлын дагалдах бичиг)
23	100%	Химийн бодис материалтай харьцдаг операторуудыг Химийн бодисын асгаралтын сургалтад хамруулах.	“Уурхайн талбайд тохиолдож болох болзошгүй ослын үед авч хэрэгжүүлэх практик, Дадлага сургуулийн нэг хэсэг болж зохион байгуулсан. (Хавсралт 13. Онцгой байдлын дадлага сургалтын тайлан).
24	100%	Асгаралттай тэмцэх иж бүрдэл бүхий цэгүүдийн бүрэн бүтэн, бэлэн байдлын үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд цэнэглэх, сайжруулах	Аюулгүй ажиллагааны хэлтэс болон Байгаль орчны хэлтэс хамтран сар бүр үзлэг хийж байна. (Хавсралт 14. Асгаралттай тэмцэх иж бүрдэл шалгасан хуудас)
25	100%	Аврах багийн сайн дурын гишүүдэд болон зарим галын эрсдэлтэй ажлын байрны ажилчдад галын онолын болон практик давтан сургалт орох	“Уурхайн талбайд тохиолдож болох болзошгүй ослын үед авч хэрэгжүүлэх практик, Дадлага сургуулийн нэг хэсэг болж зохион байгуулсан. (Хавсралт 13. Онцгой байдлын дадлага сургалтын тайлан).
26	100%	Уурхай орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох	Тайлант жилд Степ Голд ХХК-ийн ажилчид 4 удаа хээрийн гал түймэр унтраах ажилд оролцсон. Уурхайн талбайд галын аюулын үед ашиглах тоног төхөөрөмж, материалын бэлэн байдлыг ханган ажилласан (Хавсралт 27. Галын хор, утаа мэдрэгч шалгах хуудас).
27	100%	Тал хээрийн түймэр ашиглах үлээгч аппаратын бэлэн байдлыг хангах, ажилчдад сургалт орох, нэмж 5 үлээгч аппарат худалдаж авах	Ажилчдад практик сургалтыг орсон, үлээгч аппарат нэмж худалдан авч уурхайн талбайд нийт 5 үлээгчийн бэлэн байдлыг ханган ажилласан
28	100%	Галын аюулаас урьдчилан сэргийлж шаардлагатай газрын галын зоон жил бүр сэргээх, шинээр хийх.	Уурхайн хашаа, ажилчдын хотхоныг тойрсон галын зоонуудыг шинэчилж сэргээсэн.

5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бид 2022 оны БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд Алтан Цагаан-Овоо уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллахаар тусгасан байдаг.

Степ Голд ХХК нь холбогдох хууль дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журмыг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна. Уг журмын дагуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал гэж ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, дахивар хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг тусгайлан бэлдсэн контейнерт цуглуулж устгалд оруулах үйл ажиллагааг 2022 оны төлөвлөгөөнд оруулсан. Үүнд:


- Хуванцар сав буюу PET сав, Бохир усны хуванцар сав (техникийн тос, тосолгооны хуванцар сав), Гялгар уут, геомембран HDPE хулдаасыг “TML” ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлэх
- Ажилчдын тосгоноос гарсан ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж дахивар бус хог хаягдлыг Цагаан Овоо сумын Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан 14 хоногт 1-2 удаа ачилт хийлгэж, хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх
- Химийн бодисын сав, баглаа, боодлыг холбогдох журмын дагуу ангилан ялгаж, тусгай контейнерт цуглуулж, аюултай хог хаягдал тээвэрлэх, шилжүүлэх гэрээний дагуу Түмэн Эгшиг ХХК-д нийлүүлэх
- Хог хаягдлын ангилан ялгалтаар үүссэн дахивар хог хаягдлыг цуглуулж, боловсруулах үйлдвэр дахин ашиглах газруудад нийлүүлэх ажлыг зохион байгуулна.
- Уурхайн хоол үйлдвэрлэлээс гарсан ногооны хаягдал болон хоолны үлдэгдлийг бордоожуулах компост сило байгуулах
- Хог хаягдлын овор хэмжээг багасгах, хог хаягдлын тээвэрлэлтэд ашиглах зорилго бүхий гидро-пресс, бутлагч, шатаах зуух зэрэг тоног төхөөрөмж худалдаж аван, уурхайн хог хаягдлын түр цэгт байрлуулан, ашиглах

Дээрх ажлуудын биелүүлэлтийг бид дараах байдлаар ханган ажилласан болно.

Бид уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайгаас байгаль орчинд нийлүүлэх хог хаягдлыг хамгийн бага байлгах зорилго тавин дахивар хог хаягдлыг дараах байдлаар дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, устгах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал хуванцар сав буюу PET сав, гялгар уут, геомембран HDPE хулдаасыг "TML" ХХК-д (*Хавсралт 51. "TML" ХХК-тай байгуулсан гэрээ*), ахуйн хог хаягдлыг Цагаан-Овоо сумын Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-д (*Хавсралт 52. Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээ*), химийн бодисын сав баглаа боодол, химийн бодисын үлдэгдлийг Түмэн Эгшиг ХХК-д (*Хавсралт 34. Түмэн Эгшиг ХХК-тай байгуулсан гэрээ*) нийлүүлэн ажилласан.

Бид уурхайн талбайгаас гарч буй хог хаягдлыг 3R зарчмын дагуу багасгах, дахин ашиглах зорилгоор хоол үйлдвэрлэлээс гарч буй хүнсний ногооны хальс, хоолны үлдэгдлийг дахин боловсруулж, компост бордоо үүсгэхээр төлөвлөн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд тайлант жилд бид 13м x 4м харьцаа бүхий 2 сило байгуулахаар төлөвлөсөн. Тухайн сило-ны зураг төсөл, төсөв зэрэг боловсруулагдаж, компанийн удирдлагаар батлагдсан. Тухайн бүтээн байгуулалтын ажлыг компанийн удирдлагатай ярилцаж, тохиролцсоны үндсэн дээр 2023 онд хийхээр болсон. Тайлант жилд уурхайн үндсэн бутлуурын бүтээн байгуулалтын ажил хийгдсэн учир компост бордоо хийх сило байгуулах боломжгүй байсан болно.

Компост бордоо хийх сило талбай нь хүнсний ногооны хальс болон хоолны үлдэгдлийг хөрс, бүтцийн материал болох модны унанги мөчир, өвс зэрэгтэй хольж хагас нэвчилттэй хучлагаар хучих зориулалт бүхий 2 талаараа 1.4 м өндөр хана бүхий бүрэн бетондсон талбай байх юм. Тухайн талбай нь өөрөөсөө гарч буй шүүрлийн усыг хуримтлуулах талбайтай бөгөөд 3 хувийн уналттай хийгдэх юм. Мөн компост бордооны хамгийн чухал зүйлүүдийн нэг болох албадан агааржуулалтын центрифуг агаарын насос байрлах болно.



Зураг 48. Компост байгууламжийн бүтээн байгуулалтын зураг

Бид дээрх бордоо хийх байгууламж байгуулаагүй хэдий ч өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хоол үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлыг малын өтөг, бууцтай холих байдлаар бордоо хийх туршилтыг хийж байна. Бид дээрх бордоо хийх байгууламж байгуулаагүй хэдий ч өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хоол үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлыг малын өтөг, бууцтай холих байдлаар бордоо хийх туршилтыг хийж байна.



Зураг 49. Хоол үйлдвэрлэлээс гарсан хоолны хаягдлыг малын өтөг бууцтай хольж компост бордоо хийж буй байдал

Уурхайн хог хаягдлын менежментийн хүрээнд уурхайн хог хаягдлын цэгт техникийн ашигласан тос, тосолгооны материал хадгалах бүрэн бетондсон, гадагш болон хөрсөнд урсацгүй талбай байгуулж

түүн дээр 25 тонны ёмкост байрлуулж, насос холбосон. Тухайн ёмкостод уурхайн машин, механизмаас гарсан тос, тосолгооны материалыг түр хадгалж, дахин боловсруулах үйлдвэр Хай Би Ойл ХХК-д нийлүүлнэ. Тайлант жилд 20 тонн техникийн хаягдал тос, тосолгооны материалыг Хай Би Ойл ХХК-д нийлүүлээд байна.

Мөн тус ёмкостын дэргэд 20 тонны контейнер байрлуулж түүнд техникийн хаягдал тосны шүүр, тостой арчих материал зэрэг аюултай хог хаягдлыг түр хадгалж, зохих дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэхээр цуглуулан ажиллаж байна.



Зураг 50. Ашигласан тос, тосолгооны материал түр хадгалах ёмкост байрлуулж, насос холбож буй байдал



Зураг 51. Уурхайн хог хаягдлын цэгт байрлуулсан 20 тонны контейнер

Бид уурхайн талбайд ажиллаж буй нийт ажилчдын байгаль орчны талаарх мэдлэг, мөрдөгдөж буй журам, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэгийг сайжруулах зорилгоор SG-ENV-SOP-19-02 “Байгаль орчны зааварчилгаа, сургалтын журам”-ын хүрээнд уурхайн талбайд ажиллаж буй үндсэн болон гэрээт байгууллагуудын нийт ажилчдад байгаль орчны ерөнхий зааварчилгаа болон давтан сургалтуудыг орсон. 2022 оны 10-р сарын байдлаар бид 123 удаагийн сургалтаар нийт 647 ажилтанд байгаль орчны ерөнхий зааварчилгаа орсон, мөн 5 удаагийн сургалтаар нийт 66 хүнд байгаль орчны тухайлсан (асгаралт, хог хаягдал гэх мэт журам) журмын сургалтыг ороод байна (Хавсралт 36. Байгаль орчны сургалтын бүртгэл).

5.7.1. Ахуйн хог хаягдал

Бид Монгол улсын “Энгийн хог хаягдлын ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дагуу кемпийн хог хаягдлын цэгийг байгуулсан. Энэ цэг нь шаардлагын дагуу хөрсөнд ус шингээхгүй зорилготой HDPE мембран хулдаастай, мөн хулдаасны дээр 20 см орчим зузаантай хайрга дэвсэж өгсөн, хурын ус хуримтлуулах 200 л-ийн багтаамжтай 4 ширхэг савтай, хог хаягдал хийсэхээс сэргийлсэн хашаатай юм. Мөн энэхүү талбай нь газрын гадаргаас доош 3м гүн ба ёроолын хөрсийг компактларлаж нягтаршуулсан байдаг.



Зураг 52. Ажилчдын кемпийн хог хаягдлын цэгийн харагдах байдал

Ахуйн хог хаягдлын хэмжээ тухайн уурхайд ажиллаж байгаа ажилчдын тооноос шууд хамааралтай байдаг. Тайлант жилийн хугацаанд уурхайн талбайд дунжаар 250 гаруй ажилтан ажилласан бөгөөд 340 м³ ахуйн хог хаягдал гаргасан байна. Тус хаягдлын ангилан ялгалтаар гарсан хуванцар сав, бохир хуванцар сав, уут зэргийг TML ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлж (Хавсралт 54. Хуванцарын хог хаягдал зайлуулсан бүртгэл) байна. Мөн ахуйн хуурай хог хаягдлыг Цагаан-Овоо сумын Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан нийлүүлж байна (Хавсралт 55. Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-т нийлүүлсэн хог хаягдлын бүртгэл). Хоолны үлдэгдэл, төмс хүнсний хаягдлыг бордоо болгох мөн орон нутгийн иргэд гахайн фермийн аж ахуйд нийлүүлж байна.



Зураг 53. Хуванцар сав дахин боловсруулах үйлдвэр рүү нийлүүлэхээр ачиж буй байдал

Уурхайн талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт туслан гүйцэтгэгч компаниудад “Хог хаягдал ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах” стандарт журмыг танилцуулж, сургалт зохион байгуулж, үйл ажиллагаанд нь ажлын байрны үзлэг шалгалт /SG-ENV-FR-016/ маягтын дагуу хийсэн. Үзлэгээр илэрсэн зөрчилд хариу арга хэмжээ авч ажилласан (*Хавсралт 56. Ажлын байрны үзлэг шалгалтын маягт*).

Тайлант жилд уурхайн үйл ажиллагаанаас гарсан хуванцар сав буюу PET сав, гялгар уут зэргийг TML ХХК-тай гэрээ байгуулан 2022 оны 10-р сарын 20-ны байдлаар 2750 кг хуванцар сав нийлүүлээд байна (*Хавсралт 54. Хуванцарын хог хаягдал зайлуулсан бүртгэл*).

Ахуйн хуурай хог хаягдлыг Цагаан Овоо сумын Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан сард 2 - 3 удаа ачилт хийлгэн 2022 оны 10-р сарын байдлаар 340 м³ хог хаягдлыг сумын төвлөрсөн цэг нийлүүлээд байна (*Хавсралт 55. Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-т нийлүүлсэн хог хаягдлын бүртгэл*).

Химийн бодисын хаягдал, сав баглаа боодлыг ангилан ялгаж, баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулах дотор тусгай 2 ширхэг контейнерт хадгалж байна. Тухайн аюултай хог хаягдлыг Түмэн Эгшиг ХХК-тай гэрээ байгуулан 2022 оны 10-р сарын 20-ны байдлаар сав баглаа боодлын хаягдал нийт 3251.5 кг, натрийн цианидийн гаднах төмөр торх 5333 ш, 23731 кг хүчлийн үлдэгдэл, 10 ширхэг принтерийн хор устгуулаад байна (*Хавсралт 17. Түмэн Эгшиг ХХК-д хүлээлгэн өгсөн аюултай хог хаягдлын дагалдах бичиг*).


5.7.2. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж

Алтан Цагаан-Овоо уурхай нь 2021 оноос эхлэн уурхайлалтын 2-р үе шатны барилга байгууламжийн угсралт, барилгажилтын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүний хүрээнд шинэ бутлуур, флотаци-уусгалтын үйлдвэр, усан халаалтын байгууламж зэрэг хэд хэдэн байгууламж нэмэгдэнэ. Үүнийг даган ажилчдын кемпэд байрлах ажилчдын тоо эрс нэмэгдэх тул бид ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчилж, өргөтгөх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэхүү ажлыг Дорнод аймгийн Чимэрүү ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан (*Хавсралт 57. Чимэрүү ХХК-тай байгуулсан гэрээ*).

Чимэрүү ХХК нь шинэ бохир ус цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын арга хэмжээг 2021 онд бүрэн хэрэгжүүлж дууссан бөгөөд 10-р сарын 7-нд тухайн цэвэрлэх байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авах аймгийн комисс уурхайн талбайд ажиллаж хүлээж авсан байдаг. Бид ОХШХ-ийн хүрээнд ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжаас улирал тутам дээж авч ажиллаж байна. Шинжилгээний үр дүнгээс харахад MNS4943:2015 стандартын шаардлагыг хангаагүй бөгөөд цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангуулахын тулд гэрээт байгуулагатай холбогдож сайжруулах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

5.7.3. Хог хаягдлын менежментийн чиглэлээр хийгдсэн бусад ажил

Степ Голд ХХК нь орон нутгийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж, ЕБС-ийн сурагчдад байгаль орчны мэдлэг боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорьж ажилладаг. Үүний хүрээнд Цагаан-Овоо сумын ЕБС-н байгаль хамгаалах Эко Клуб-н сурагчдаас гаргасан хүсэлтийн дагуу Цагаан-Овоо сумын ундны усны цэгт хаягдал хуванцар сав хийх хогийн сав хийж байрлуулсан.



Зураг 54. Ундны ус түгээх цэгт хаягдал хуванцар сав хийх хогийн сав хүлээлгэн өгсөн

Цагаан-Овоо сумын 2-р багийн төвд ангилан ялгалт бүхий төмөр торхоор хийсэн хогийн савыг багийн засаг даргын хүсэлтийн дагуу хийж байрлуулсан. Бид хог хаягдлын менежментийг уурхайн талбайд хэрэгжүүлэхээс гадна бусдад хог хаягдлын ангилан ялгалт, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дээрх газруудад ангилан ялгалт бүхий хогийн сав хийж байрлуулсан.



Зураг 55. Цагаан-Овоо сумын 2-р багийн төвд ангилан ялгалт бүхий хогийн сав байрлуулсан

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Ахуйн хог хаягдлыг орон нутгийн төвлөрсөн цэгт нийлүүлэх	Ахуйн хог хаягдлыг Цагаан-Овоо сумын Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан нийлүүлж байна (Хавсралт 55. Хөөвөр Хөгжил ОНӨААТҮГ-т нийлүүлсэн хог хаягдлын бүртгэл).
2	100%	Хэлтэс, гэрээт компани бүр өөрсдийн үйл ажиллагаанаас гарч буй хаягдлыг, хог хаягдлын түр цэгт хаяхдаа тухай бүрд нь бүртгэл хөтөлж, бүртгэлийн хуудсыг байгаль орчны хэлтэс өгнө	Хэлтэс гэрээт компаниуд 7 хоног бүр өөрсдийн үйл ажиллагаанаас гарч буй хаягдлыг бүртгэлжүүлж байна (Хавсралт 58. Хог хаягдлын бүртгэлийн хуудас)
3	100%	Кемпийн хог хаягдлын цэгт ангилан ялгалтыг сайжруулах, шаардлагатай газруудад хогийн сав байрлуулах	Ажилчдын кемп, уурхайн талбайд байрлах оффисуудад ахуйн хог хаягдал болон хуванцар сав ангилах хогийн савнуудыг байрлуулсан. Хог хаягдлын цэгийн тэмдэг тэмдэглэгээг сайжруулж, шинэчилсэн
4	100%	Хуванцар усны сав, HDPE хуванцрыг ангилан ялгаж TML XXK-д нийлүүлэх	Тайлант жилийн 10 сарын байдлаар 2750 кг хуванцар сав нийлүүлээд байна (Хавсралт 54. Хуванирын хог хаягдал зайлуулсан бүртгэл).

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
5	100%	Бусад дахивар хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах холбогдох үйлдвэрийг судалж нийлүүлэх /Хаягдал дугуй, картон цаас/	Аккумулятор, тосны шүүлтүүр зэрэг техникийн аюултай хог хаягдлыг Түмэн Эгшиг ХХК-д, дахивар хог хаягдлыг уурхайн талбайгаас зайлуулах түр журмын хүрээнд хаягдал мод, төмөр зэрэг хог хаягдлыг ахуйн хэрэгцээнд ашиглах хүсэлтийн дагуу орон нутгийн иргэдийн хүсэлтийг харгалзан үзэн нийлүүлээд байна.
6	100%	Хог хаягдлын ангилан ялгалтад хяналт тавих үзлэг шалгалт хийх	Байгаль орчны хэлтэс уурхайн хог хаягдлын цэгт тайлант жилд 1 удаа, ажилчдын кемпийн үйл ажиллагаанд 4 удаа үзлэг шалгалтыг хийж, холбогдох дутагдал, зөрчлийг арилган ажилласан.
7	100%	Уурхайн талбайд шинээр ажиллахаар ирж буй бүх ажилчдад хог хаягдлын сургалт орох	Тайлант жилд 123 удаагийн сургалтаар 647 хүнд ерөнхий зааварчилгаа өгсөн байна (<i>Хавсралт 36. Байгаль орчны сургалтын бүртгэл</i>).
8	100%	Уурхайн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих	Уурхайн талбайд нийт хогийн савны тэмдэг тэмдэглэгээг нэгдсэн байдлаар сайжруулж, нэг загварт оруулан шинэчилсэн.
9	50%	Хоол үйлдвэрлэлээс гарч буй хог хаягдлыг бордоо болгох зориулалтын бетондсон талбай бэлдэх, туршилт судалгааны ажлыг хийх	Тус талбайг байгуулах зөвшөөрлийг компанийн удирдлагаас авсан, зураг, төслийг боловсруулсан. Гэвч тайлант жилд уурхайн үндсэн бутлуурын бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа учир компост сило хийх боломжгүй байсан. 2023 онд тухайн сило-г байгуулахаар болсон.
10	100%	Арчих тослох материал устгах, тостой хаягдлыг торхыг турбо бурнер ашиглаж цэвэрлэх	Тоног төхөөрөмж нийлүүлэлтийн компанитай гэрээ байгуулан хог хаягдлын менежментийн тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан. Турбо бурнер нь АНУ-с хүргэгдэж ирэх тул 2022 оны 10-р сарын байдлаар уурхайн талбайд ирээгүй байна. Ханган нийлүүлэлтийн компаниас ирүүлсэн мэдээллээр тайлант жилийн 12-р сар гэхэд уурхайн талбайд нийлүүлэгдэнэ гэж мэдэгдсэн болно (<i>Хавсралт 55. Ханган нийлүүлэлтийн компаниас ирүүлсэн албан бичиг</i>).
11	100%	Үйлдвэрт ашиглах химийн бодисын сав баглаа боодлыг цэвэрлэх, ангилан төрөлжүүлж бүртгэх	Баяжуулах үйлдвэрийн химич мэргэжилтэн 7 хоног бүр химийн бодисын сав баглаа боодлын бүртгэлийг хийж ажиллаж байна. (<i>Хавсралт 35. Химийн бодисын сав баглаа боодлын бүртгэл</i>)
12	100%	Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах эрх бүхий Түмэн эгшиг ХХК-тай гэрээ байгуулан хаягдлыг нийлүүлэх	2022 оны 10-р сарын 20-ны байдлаар сав баглаа боодлын хаягдал нийт 3251.5 кг, натрийн цианидийн гаднах төмөр торх 5333 ш, 23731 кг хүчлийн үлдэгдэл, 10 ширхэг принтерийн хор устгуулаад байна (<i>Хавсралт 17. Түмэн Эгшиг ХХК-д хүлээлгэн өгсөн аюултай хог хаягдлын дагалдах бичиг</i>)
13	100%	Эмнэлгийн хог хаягдлыг сумын хүн эмнэлэгт нийлүүлж устгалд оруулах	2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар 62 кг эмнэлгийн хог хаягдлыг гэрээний дагуу Цагаан-Овоо сумын хүн эмнэлэгт нийлүүлээд байна.
14	100%	Үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, БОХ тайланд тусгаж сумын захиргаанд хүргүүлнэ	Хог хаягдлын бүртгэлийг 7 хоног бүр хийж байна. Холбогдох БОХ маягтад заасан хугацааны дагуу 2022 оны 01-р сарын 18-нд 2021 оны 3-БОХ-1.3, 3-БОХ-2.3, 3-БОХ-6.1, 3-БОХ-6.2 маягыг Цагаан-Овоо сумын ЗДТГ-т хүргүүлсэн. (<i>Хавсралт 60. БОХ тайлан хүргэсэн бичиг</i>) 2022 оны БОХ маягт тайланг 2023 онд хүргүүлнэ.
15	100%	Уурхайн хаягдлын цэгийг хашаажуулах	Уурхайн хог хаягдлын цэгийн хашааг барих ажлыг хийж гүйцэтгэсэн.
16	100%	Уурхайн хог хаягдлын цэгт Турбо бурнер худалдан авч байрлуулах, ашиглаж эхлэх	Тоног төхөөрөмж нийлүүлэлтийн компанитай гэрээ байгуулан хог хаягдлын менежментийг сайжруулах тоног төхөөрөмжүүдийг худалдан

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
			<p>авсан. Турбо бурнер нь АНУ-с хүргэгдэж захиалагдаж ирнэ. 2022 оны 10-р сарын байдлаар уурхайн талбайд ирээгүй байна. Ханган нийлүүлэлтийн компаниас ирүүлсэн мэдээллээр тайлант жилийн 12-р сар гэхэд уурхайн талбайд нийлүүлэгдэнэ гэж мэдэгдсэн болно (<i>Хавсралт 55. Ханган нийлүүлэлтийн компаниас ирүүлсэн албан бичиг</i>).</p>
17	100%	<p>Уурхайн хог хаягдлын цэгт хуванцар, химийн бодисын сав баглаа боодол бяцлагч, прецесслэгч худалдан авч байрлуулах, ашиглаж эхлэх</p>	<p>Тоног төхөөрөмж нийлүүлэлтийн компанитай гэрээ байгуулан хог хаягдлын менежментийг сайжруулах тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан. Хог хаягдлын менежментийг сайжруулах тоног төхөөрөмжүүд нь Хятад улсаас захиалагдаж ирнэ. 2022 оны 10-р сарын байдлаар уурхайн талбайд ирээгүй байна. Ханган нийлүүлэлтийн компаниас ирүүлсэн мэдээллээр тайлант жилийн 12-р сар гэхэд уурхайн талбайд нийлүүлэгдэнэ гэж мэдэгдсэн болно (<i>Хавсралт 55. Ханган нийлүүлэлтийн компаниас ирүүлсэн албан бичиг</i>).</p>

5.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Степ Голд ХХК нь байгаль орчныг хамгаалах удирдлагын систем чиг баримтлалыг боловсруулан ажиллахдаа “Байгаль орчны удирдлагын тогтолцоо, шаардлага, хэрэглэх арга зүйн заавар-MNS ISO 14001:2015, Байгаль орчны удирдлагын тогтолцоо, зарчим, тогтолцоо, дэмжих аргачлалын заавар MNS ISO 14004:2005” стандартуудыг баримталж ажилладаг.

Цаашид бид ISO 14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо стандартын шаардлагыг хангасан байгаль орчны менежментийн системийг бий болгохыг зорин ажиллаж байна.

Алтан Цагаан-Овоо уурхайн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэй ажиллалаа. Үүнд:

- Байгаль орчны менежер – 1
- Байгаль орчны мэргэжилтэн – 1
- Байгаль орчны инженер – 1
- Байгаль орчны ажилтан – 2
- Байгаль орчны туслах ажилтан – 14

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайг бүрэн хашаажуулах	Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайн 1.5 га газрыг бүрэн хашаажуулж ажилласан.
2	100%	Хүлэмжид ургамлыг үрээр тарьж суулгац бэлдэх	Мод үржүүлэг бойжуулгын туршилтын талбайд 10х6 харьцаатай зуны хүлэмж барьсан. Хүлэмжид хайлаас модны үрээр тариалалт хийж суулгац бэлдсэн.
3	100%	Хүлэмжид бойжуулсан модыг шилжүүлэн суулгах	Тайлант жилд бид хүлэмжид 3000 ширхэг хайлаас модны суулгацыг тарьж бэлдсэн. Тухайн суулгацуудыг 2023 онд гадаа талбайд шилжүүлэн суулгана. Дэлгэрэнгүй мэдээллийг нөхөн сэргээлтийн бүлгийн 5.2.7-р хэсгээс харна уу.
4	100%	Мод үржүүлгийн амьдралтын хувь тогтоох үзлэг хийх тайлан гаргах	Дэлгэрэнгүй мэдээллийг нөхөн сэргээлтийн бүлгээс харна уу.
5	100%	Мод үржүүлгийн талбайд нөхөн тарилт хийх	
6	100%	Хаягдал иметрийн усалгааны системийг сайжруулах	Мод үржүүлэн бойжуулгын туршилтын талбайд болон зурвас хэлбэрээр тарьсан модны усалгаанд 20 тонны 2 усны сав байрлуулсан. Тухайн усны саванд иметр холбож усалгааг хийж байна.
7	100%	Мод үржүүлгийн талбайг тэмдэгжүүлэх, танилцуулга самбар байрлуулах	Мод үржүүлгийн талбайд ерөнхий танилцуулга самбар, зохион байгуулалтын схем зураг, модны зүйл тус бүрийн мэдээлэл бүхий QR код самбар байрлуулсан.
8	100%	Ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамран ажиллах	Ургамал хамгааллын хүрээлэнтэй холбогдож ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, зөвлөн туслах үйлчилгээний гэрээ байгуулсан. Үүний хүрээнд уурхайн талбайд Ургамал хамгааллын хүрээлэнгийн 2 зөвлөх 2022 оны 10-р сарын 2-оос 4-ний өдрийн хооронд хүрэлцэн ирж мод үржүүлэг, бойжуулгын талбай, ажилчдын кемп, хамгаалалтын ойн зурвас зэрэг газруудаар зочилсон. Бидэнд хүргүүлсэн илтгэх хуудсанд ургамал хамгааллын зөвлөгөөг тусган ирүүлсэн болно (Хавсралт 62. Ургамал хамгааллын хүрээлэнгийн судалгааны тайлан).

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
9	100%	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний бэлтгэл ажлын хүрээнд Алтан Цагаан-Овоо уурхайн мод үржүүлэг болон уурхайн хашааны хамгаалалтын ойн зурвас хэлбэрээр мод тарих ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах	Уурхайн хашааны хойд болон баруун хэсгүүдээр нийт 900 м урт бүхий 3 хамгаалалтын ойн зурвас байгуулсан бөгөөд улиангар модны мөчир тарьсан.
10	100%	Уурхайн мод үржүүлэг бойжуулгын талбайд зарим модыг саваа мөчир болон үрээр үржүүлэх, бойжуулах туршилтын ажлыг эхлүүлэх	Бид Дорнод аймгийн Баяндун, Баян-Уул, Хэрлэн сумдын нутгийн байгалийн модноос (бургас, чацаргана, өрөл, улиас, улиангар, монос) тайрдас мөчир тайрч бэлтгэсэн. Тайрдас мөчрийг бэлдэхдээ эх модноос 30 см орчим урттай бэлдэж, мод үржүүлгийн талбайн өргөтгөлд тарьсан.
11	100%	Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд туслах ажилтан авч ажиллуулах	Орон нутгийн түр гэрээтэй 14 туслах ажилтнуудыг нэг ээлжид 7 хүнтэй байхаар авч ажиллуулж байна.
12	30%	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хамгаалалтын ойн зурвас байгуулах талаар судалгааны ажлыг эхлүүлэх	ТЭЗҮ боловсруулах судалгааны ажил хийгдэж байна.
13	30%	10 сая мод тарих ажлын хүрээнд Цагаан-Овоо сумын 2-р багийн Нарст гэдэг газар ойжуулалтыг орон нутаг болон мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхтэй холбоотой судалгааны ажлыг хийх	
14	100%	Байгалийн талбайгаас 3-4 зүйл олон наст ургамлын үр түүх	Байгаль орчны туслах ажилчид шеллийн бутнуур, хялгана 2 зүйлийн ургамлын үрийг түүсэн бөгөөд үрийн чанарыг тодорхойлох зорилгоор лабораторид шинжлүүлэхээр өгсөн.
15	100%	Түүсэн үрийн соёлолт, цэвэршилтийг лабораторийн нөхцөлд зүйл тус бүрээр тодорхойлох	
16	100%	Шимт хөрсний овоолгод болон мод үржүүлэг бойжуулалтын туршилтын талбайн хүлэмжид түүсэн нутгийн ургамлын үрээр тариалалт хийх, туршилт судалгааны ажил хийх	Шимт хөрсний овоолго #1-н 1/3-г ургамалжуулах ажилд 2021 онд түүсэн шеллийн бутнуур, хялгана ургамлын үрийг ашигласан
17	100%	Ургамалжуулсан шимт хөрсний овоолгод ажиглалт судалгаа явуулах	2021 онд ургамалжуулалтын ажил хийгдсэн шимт хөрсний овоолго #2 дээр ургамлын ажиглалт хийсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 73-аас харна уу.
18	100%	Туршилт судалгааны ажлыг үргэлжлүүлэн сайжруулж гүйцэтгэх	Бид цианидаар бохирдсон хүдрийн овоолгыг нөхөн сэргээх чиглэлээр судалгаа, туршилтуудыг тайлант жилд хийж гүйцэтгэсэн.
19	100%	14 хоног тутам гэрээт компаниудад ажлын байранд үзлэг хийх /Гэрээт компанид байгаль орчны чиглэлээр тавих хяналтыг сайжруулах/	2022 оны 10-р сарын байдлаар туслан гүйцэтгэгч компаниудын ажлын байранд нийт 10 удаа үзлэг, шалгалт хэрэгжүүлсэн бөгөөд тухайн үзлэгээр илэрсэн зөрчил, дутагдлыг нэн даруй арилгуулан ажилласан.
20	0%	Гэрээт компаниуд техникийн засвар үйлчилгээ хийхдээ хөрс бохирдуулахгүй бетондсон эсвэл хулдаас дэвссэн талбайд засвар үйлчилгээ хийх	Бэлтгэл ажил хийгдэж байгаа.
21	100%	Степ Голд ХХК-д MNS ISO 14001 "Байгаль орчны менежментийн тогтолцоо" стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, зөвлөх үйлчилгээний компанитай гэрээ байгуулах	Бид ISO 14001 стандартыг нэвтрүүлэх зорилгоор Eco National компанитай зөрүүгийн шинжилгээ хийлгэх гэрээ байгуулсан. Тухайн компанийн мэргэжилтнүүд уурхайн талбайд 10-р сарын 6-ны өдөр хүрэлцэн ирж ISO 14001 стандартыг нэвтрүүлэх зөрүүгийн шинжилгээг хийсэн.
22	100%	Степ Голд ХХК-ийн байгаль орчны ажилтнуудыг байгаль орчны чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад элсүүлэн суралцуулах	Байгаль орчны мэргэжилтэн Г.Гүнбат нь Канад улсын уул уурхайн тогтвортой хөгжил чиглэлээр туршлага судлах сургалтад хамрагдсан.

5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго нь тухайн төслийг хэрэгжүүлэх нутгийн байгаль орчин, нутгийн оршин суугчдад тухайн төслийн хэрэгжилтийн улмаас үзүүлэх нөлөөллийг хянах, тэдгээрийг бууруулах оновчтой арга хэмжээг сонгох, уг сонгосон арга хэмжээнүүд үр дүнгээ өгч буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн засаг захиргаа, хяналт тавих эрх бүхий байгууллагууд болон нутгийн оршин суугчдыг бодитой мэдээллээр хангахад оршино.

Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, тэдгээрийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал болон холбогдон гарах зардлуудыг урьдчилан тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулсан.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч Степ Голд ХХК нь орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг хариуцан гаргаж, аливаа ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүн, гэрээт компанийн тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

АЦО уурхайн улирал тутмын ус, хөрс, агаарын дээжлэлт, хэмжилтийн ажлыг Байгаль орчны мэргэжлийн байгууллага болох Өлзий Энвайронментал хэрэгжүүлэн ажилладаг. Тус байгууллага нь АЦО уурхайн 1, 2, 3-р улирлын дээжлэлт, хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд улирал бүрийн ОХШХ-ийн тайланг холбогдох талуудад хүргүүлэн ажиллаж ирсэн.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар 20 цэгт гүйцэтгэх, үр дүнг боловсруулах	Агаарын чанарын хэмжилт сар бүр тогтмол хийгдэж байна. (Хавсралт 9. Агаарын чанарын хэмжилтийн хуудас), (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).
2	100%	Хөрсний дээжлэлтийг 25 цэгт гүйцэтгэж лабораториудад харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх	Хөрсний дээжлэлт шинжилгээний ажлыг улиралд 1 удаа гүйцэтгэж байна. (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).
3	100%	Гүний усны хяналтын 24 кооногуудаас дээжлэлт гүйцэтгэж харгалзах үзүүлэлтүүдийг лабораторид шинжлүүлж үр дүнг нэгтгэн боловсруулах	Гүний усны дээжлэлт, шинжилгээний ажил сар бүр хийгдэж байна. (Хавсралт 59. Сар бүрийн усны дээжлэлтийн маягт), (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).
4	100%	Малчдын 7 худгаас дээжлэлт гүйцэтгэж харгалзах үзүүлэлтүүдийг лабораторид шинжлүүлж үр дүнг нэгтгэн боловсруулах. Улирал тутам нийт СN шинжлүүлэх	Малчдын худгийн дээжлэлт шинжилгээний ажил сар бүр хийгдэж байна. (Хавсралт 59. Сар бүрийн усны дээжлэлтийн маягт), (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).
5	100%	Гадаргын усны 5 цэгт устай саруудад дээжлэлт гүйцэтгэж харгалзах үзүүлэлтүүдийг лабораторит шинжлүүлж үр дүнг нэгтгэн боловсруулах	Тайланг жилд 4 удаагийн дээжлэлт хийсэн. (Хавсралт 59. Сар бүрийн усны дээжлэлтийн маягт), (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).
6	100%	Питүүдээс шүүрлийн усны дээжлэлт гүйцэтгэж харгалзах үзүүлэлтүүдийг лабораторид шинжлүүлж үр дүнг нэгтгэн боловсруулах	Сар бүр хийгдэж байна. (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
7	100%	Ундны усны дээжийг гал тогоо болон нийтийн ариун цэврийн өрөөн зэргээс авч химийн болон бактерлогийн үзүүлэлтийг шинжлүүлэх	Улиралд 1 удаа хийгдэж байна. (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).
8	100%	Цэвэршүүлэх байгууламжийн оролт гаралтаас дээжлэлт гүйцэтгэж харгалзах үзүүлэлтүүдийг лабораторид шинжлүүлж үр дүнг нэгтгэн боловсруулах	Улиралд 1 удаа хийгдэж байна. (Хавсралт 61. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШХ улирлын тайлангаас харна уу).
9	100%	Тодорхой талбайн хэмжээнд зэрлэг ан амьтны судалгаа гүйцэтгэх	9-р сард тус зэрлэг амьтны мониторингийг хийсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт 66-с харна уу).
10	100%	Ургамлын 19 цэг дээр хэмжилт гүйцэтгэж үр дүнг нэгтгэн боловсруулах	6-р сараас эхлэн ургамлын хяналт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт 64-с харна уу).

5.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн биелэлт

Степ Голд ХХК-ийн Алтан Цагаан-Овоо уурхай нь Дорнод аймгийн хувьд отгон уурхай болж байгаа хэдий ч Цагаан-Овоо сумын хувьд ууган уурхай юм. Тэр утгаараа нутгийн иргэд, малчид уул уурхайн талаар мэдээлэл хомс, зарим тохиолдолд буруу ташаа ойлголттой байсны улмаас уурхайн бэлтгэл үйл ажиллагаа тодорхой хугацаагаар зогсож төлөвлөсөн ажлууд хойшилж, хоцорсон тохиолдлууд гарсан байдаг. Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж, нээлттэй байх, хамтран ажиллах зарчмыг “Степ Голд” ХХК баримталж байна.

Төслийн үйл ажиллагаа эхэлсэн цагаас хойш нутгийн малчин иргэдэд уурхайн үйл ажиллагаа, хэтийн төлөв, байгаль орчны асуудлууд ба тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замууд гэх мэт олон талын мэдээллийг уулзалт хурал, цуглаан, ганцаарчилсан уулзалтуудаар өгсөн. Тухайлбал:

Сурагчдын Эко Клуб

БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч талуудад тайлагнах төлөвлөгөөний дагуу бид 2022 онд Цагаан-Овоо сумын ЕБС-н дунд ангийн сурагчид болон Эко Клуб-н гишүүдийг уурхайн талбайтай танилцах аяллыг зохион байгуулсан. Тус аяллаар тухайн жилийн БОМТ-ний биелэлт, уурхайн байгаль орчны үйл ажиллагааны танилцуулга, мод тарих мэргэжил арга зүйн зөвлөгөө, хөрсний бүтцийг танилцуулах зорилго бүхий хөрсний зүсэлт хийх зэрэг ажлыг зохион байгуулсан.




Зураг 56. Цагаан-Овоо сумын Эко клубийн сурагчид

Цагаан-Овоо сумын иргэдийн төлөөлөл, Хяналтын хорооны гишүүд

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2-р багийн Иргэдийн нийтийн хурлаас Степ Голд ХХК-ийн Алтан Цагаан Овоо уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих зорилго бүхий Хяналтын хорооны гишүүдийг сонгодог. Тухайн сонгогдсон гишүүдийг Цагаан-Овоо сумын ИТХ-н тогтоолоор баталж, уурхайн үйл ажиллагаанд иргэдийн төлөөлөл болж хяналт тавих, хамтран ажиллах (уурхайн байгаль орчны үйл ажиллагаа, хүний нөөц, орон нутаг, худалдан авалт) зохион байгуулалттай болно.

Тус хяналтын хорооны гишүүдэд Цагаан-Овоо сумын 2-р багаас 9 иргэн, бусад багаас 5 иргэн буюу нийт 14 гишүүнтэй хороо юм. Энэхүү хяналтын хороо нь Алтан Цагаан-Овоо уурхайн үйл ажиллагаа, байгаль орчин, орон нутгийн харилцаа зэрэг үйл ажиллагаанд хяналт тавин ажилладаг бөгөөд АЦО уурхайн байгаль орчны хэлтэс нь хамтын ажиллагааг ханган, ил тод нээлттэй зарчмыг баримтлан ажиллаж байна.



Зураг 57. Хяналтын хорооны гишүүд уурхайн талбайд хүрэлцэн ирж, үйл ажиллагаатай танилцаж буй байдал

Хяналтын хорооны гишүүд нь уурхайн ОХШХ-ийн хүрээнд хийгдэж буй дээжлэлт, хэмжилтийн үйл ажиллагаанд оролцож, хяналт тавин ажилладаг. Тухайлбал 2022 оны 9-р сарын 30-с 10-р сарын 1-ны өдрүүдэд Дорнод аймгийн БОАЖГ, Хэрлэн голын сав газрын захиргаа, Цагаан-Овоо сумын Хяналтын хорооны гишүүд АЦО уурхайн 3-р улирлын ОХШХ-ийн дээжлэлт, хэмжилтийн ажилд оролцон ажилласан. Ийнхүү ОХШХ-ийн дээжлэлт, хэмжилтийн ажилд оролцсоноор орон нутгийн иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах, ОХШХ-ийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаатай танилцахаас гадна, авсан дээж лабораторид хүргэх хүртэл лацыг хамтран баталгаажуулах ач холбогдолтой.



Зураг 58. ОХШХ-ийн 3-р улирлын дээжлэлт, хэмжилтийн ажилд орон нутгийн төлөөллүүд оролцож буй байдал

Хяналтын хорооны гишүүд нь хяналт тавихаас гадна уурхайн байгаль орчны үйл ажиллагаанд хамтран оролцож ажилладаг. Үүний нэг нь Цагаан-Овоо сумын 2-р багийн малчдын гар болон гүний худгуудын түвшин болон урвалын орчин, хуурай үлдэгдэл, давсжилт, цахилгаан дамжуулах чанар зэрэг үзүүлэлтээр хэмжилт хийх ажил юм. Тухайн ажлыг 2019 оноос хойш жил бүр тогтмол хийж байна. 2-р багийн нутаг дэвсгэрт гүний худаг 60, гар худаг 42, нийт 102 худагт хэмжилт хийсэн байна. Худгийн хэмжилтийг хийхэд нутгийн малчин өрхийн гишүүдтэй биечлэн уулздаг бөгөөд уулзалтаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөний талаар мэдээллүүдийг өгч, санал солилцон ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт 65. Орон нутгийн иргэдийн худгийн түвшинд хэмжилт хийсэн ажлын тайлангаас харна уу).



Зураг 59. Орон нутгийн иргэдийн худагт хэмжилт хийж буй байдал

Цагаан-Овоо сумын багийн ИНХ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга

Степ Голд ХХК-н байгаль орчны хэлтэс болон Пенин ХХК-н төлөөллүүд Цагаан-Овоо сумын 2-р багийн ИНХ-д оролцож байгаль орчны үйл ажиллагаа, БОМТ-ний биелэлтийн төлөв, хүний нөөц болон орон нутгаас худалдан авалт болон бусад холбогдох мэдээллүүдийг танилцуулсан. Тус хурлын үеэр байгаль орчны мэргэжилтэн Г.Гүнбат болон Пенин ХХК-н аюулгүй ажиллагааны ажилтан Цэрэндулам нар орон нутгийн иргэдийн асуултад хариулт өгч, АЦО уурхайд санал, хүсэлт, гомдол зэрэг байгаа эсэхийг тодруулж, аливаа саналыг хүлээн авсан болно. Иргэдээс гарсан санал, гомдол, хүсэлтийг бүртгэлжүүлж, арга хэмжээ авч ажиллаж байна.



Зураг 60. Байгаль орчны мэргэжилтэн Г.Гүнбат болон Пенин ХХК-н аюулгүй ажиллагааны ажилтан Цэрэндулам нар 2-р багийн ИНХ-д мэдээлэл танилцуулсан

Уурхай (ил уурхай, баяжуулах үйлдвэр, бутлуур, нуруулдан уусгалтын талбай, уусмалын сан, ажилчдын кемп) болон уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үйл ажиллагаатай танилцахаар Цагаан-Овоо сумын ЗДТГ-ийн төрийн албан хаагчид 2022 оны 5-р сарын 4-ны өдөр уурхайн талбайд хүрэлцэн ирсэн. Тус үйл ажиллагаагаар бид уурхайн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар танилцуулсан болно.



Зураг 61. Орон нутгийн төлөөллүүд уурхайн талбайд зочилж буй байдал

Бусад зочид төлөөлөгч, хамтын ажиллагаа

Дорнод аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга М.Энхтөрийн баталсан “Дорнод аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Дорнод аймгийн прокурорын газар, Экологийн цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газрын албан тушаалтнууд уурхайн талбайд ирж чиглэл тус бүрийн хяналт, шалгалтыг хийлээ.

Эдгээр албан тушаалтнууд нь дээрх удирдамжийн дагуу өөрсдийн чиглэл тус бүрийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн бөгөөд, байгаль орчны хувьд БОННУ, БОМТ, ОХШХ-н хэрэгжилтийн тайлан, усны зөвшөөрөл, гэрээ, дүгнэлт, аюултай хог хаягдал устгах тээвэрлэх гэрээ зэрэгтэй танилцаж, химийн бодисын агуулах дээр ирж үзлэг шалгалт гүйцэтгэсэн. Энэхүү хяналт шалгалтаар хуулийн хэрэгжилтийн хүрээнд хяналтын хуудас бөглөөгүй бөгөөд хүрээлэн байгаа орчинтой холбоотой гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага болон аж ахуй нэгж хоорондын харилцааны хүрээнд хууль зөрчигдөх асуудал гарч байгаа эсэхийг судлах хянах үндсэн зорилготой байсан.

Хяналт шалгалтын хүрээнд Байгаль орчинтой холбоотой дутагдал болон зөрчил гэж үзэхээр зүйл гараагүй бөгөөд цаашид аюултай хог хаягдлын асуудал, нөхөн сэргээлтийн хэрэгжилт зэрэгт илүү анхаарал хандуулж ажиллах талаар зөвлөмж өгсөн.



Зураг 62. Дорнод аймгийн албан тушаалтнууд уурхайн талбайд хүрэлцэн ирж, хяналт, шалгалт хийсэн

Газрын доорх усны түвшин хэмжилтийн автомат багаж худалдан авч, байрлуулах ажлын хүрээнд тус багажийн хэмжилтийн үр дүнг Монгол улсын усны мэдээллийн санд бүртгүүлж, Хэрлэн голын сав газрын захиргаанд хүлээлгэн өгөх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүний хүрээнд 2022 оны 5-р сард Хэрлэн голын сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүдийн хамт уурхайн талбайд хүрэлцэн ирж дараах ажил, арга хэмжээнүүдтэй танилцсан. Үүнд:

- Уурхай болон уурхайн байгаль орчны үйл ажиллагаа,
- Ус ашиглалт, гэрээний хэрэгжилт,
- БОМТ-ний хэрэгжилт (устай холбоотой),
- ОХШХ-ийн газрын доорх усны хяналт, шинжилгээ

Мөн Хэрлэн голын сав газрын захиргаа нь уурхайн газрын доорх усны хяналт шинжилгээний цэгүүдээс дурын цэгийг сонгон авч хөндлөнгийн дээжлэлт хийж, лабораторид хүргүүлсэн.



Зураг 63. Хэрлэн голын сав газрын захиргааны ажилчид уурхайн талбайд зочилж буй байдал

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ЗДТГ-с АЦО уурхайн үйл ажиллагаа болон мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайн арга хэмжээтэй танилцах тухай хүсэлтийг 2022 оны 5-р сард бидэнд хүргүүлж байсан. Гаргасан хүсэлтийн дагуу тус сумын төрийн албан хаагчид уурхайн талбай дээр хүрэлцэн ирж, уурхайн байгаль орчны үйл ажиллагаа, мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайн арга хэмжээтэй танилцаж, туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулсан.



Зураг 64. Хөлөнбуйр сумын ЗДТГ-н төрийн албан хаагчид уурхайн талбай болон мод үржүүлэг, бойжуулгын туршилтын талбайтай танилцаж буй байдал

"Уул уурхай, усны менежмент - Байгаль орчин" сайн дурын кодекс нь анх 2013 онд Олон улсын санхүүгийн корпорацын дэмжлэгтэйгээр байгуулагдсан бөгөөд уул уурхайн тэргүүлэх 11 компани кодексийг баталж, гишүүнээр элссэн байдаг. Степ Голд ХХК нь тус сайн дурын кодекст 2019 онд элсэн орсон. Тус сайн дурын кодекст элсэн орсноор улирал тутамд уул уурхайн тэргүүлэгч компаниуд сайн туршлагаа солилцох, салбарын мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх, төрийн байгууллагуудад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, тулгамдсан асуудлын талаар засгийн газрын зөвлөх, шийдвэр гарагчид танилцуулах, ээлжит болон төлөвлөгөөт семинарт зочин илтгэгч урьж оролцуулах, хэлэлцүүлэг явуулах зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулдаг. Мөн уул уурхайн байгаль орчны сайн туршлагыг хэрэгжүүлж буй уул уурхайн компанид зочлох, туршлага судлах, танилцах аялал зохион байгуулдаг.

Үүний хүрээнд Степ Голд ХХК-ний Алтан Цагаан-Овоо уурхайн талбайд 2022 оны 10-р сарын 7-ний өдөр тус сайн дурын кодекст элсэн орсон гишүүд болох Бадрах Энержи ХХК, Эрдэнэс Таван Толгой ХХК, МАК ХХК, Энержи Ресурс ХХК, Оюу Толгой ХХК, Грийн Трендс ХХК, Эс Жи Эс ХХК болон Эрдэнэс Монгол ХХК-ийн байгаль орчин болон орон нутгийн харилцаа хариуцсан ажилчид зочилж, уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны сайн туршлагатай танилцах, туршлага судлах аяллыг зохион байгуулсан.



Зураг 65. Сайн дурын кодексийн гишүүн байгууллагуудын төлөөлөл уурхайн талбайгаар зочилж буй байдал

Олборлох салбарыг үр дүнтэй удирдах төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулснаар Монголын улсын тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилго бүхий MERIT төсөл нь Степ Голд компанитай хамтран ажиллаж "уурхайд хяналт хийх хээрийн гарын авлагуудыг ашиглах практик дадлага сургалт"-ыг АЦО уурхайн талбайд зохион байгуулсан. Тус сургалтад МХЕГ, БОАЖЯ, Усны Газар, Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Дорнод аймгийн уул

уурхайн компаниудын байгаль орчны мэргэжилтнүүд, аймаг сумдын байгаль орчны байцаагч, холбогдох мэргэжилтнүүд зэрэг нийт 39 хүн хамрагдсан.



Зураг 66. MERIT төслийн сургалтад хамрагдсан зочид төлөөлөгчид



Зураг 67. Хээрийн дадлага, сургуулилтыг хийж буй байдал

Байгаль орчны хэлтсийн зүгээс орон нутгийн холбогдох талуудтай хамтын ажиллагааг эрхэмлэх, ил тод, нээлттэй зармаар ажиллахыг зорьдог. Үүний хүрээнд бид БОМТ-н биелэлтийн хагас жилийн тайлан, ОХШХ-н улирал тутмын тайлан болон бусад хамаарал бүхий тайлан, мэдээллийг Цагаан-Овоо сумын ЗДТГ, ИТХ, Хяналтын хороо, Байгаль хамгаалагч, байцаагч болон Дорнод аймгийн ЗДТГ, БОАЖГ, МХГ, Хэрлэн голын сав газрын захиргаа, Тусгай хамгаалалттай газар нутгуудын захиргаа зэрэг холбогдох талуудад тогтмол хүргүүлж ажилласан (*Хавсралт 74. ОХШХ-н 1 болон 2-р улирлын үр дүнг хүргүүлсэн баримт, Хавсралт 75. БОМТ-н Хагас жилийн биелэлтийн тайлан хүргүүлсэн баримт*).

Тайлант жилд уурхайн талбайд 37 удаагийн нийт 173 зочид төлөөлөгчид уурхайн талбайд хүрэлцэн ирж, уурхайн болон байгаль орчны үйл ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний явцын биелэлт зэрэгтэй танилцсан байна. Дээрх зочид төлөөлөгчдийн 78 нь Цагаан-Овоо сумын иргэд, төрийн албан хаагчид, хяналтын хорооны гишүүд байсан байна.

Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг танилцуулах, хэлэлцүүлэх	БОМТ-н биелэлтийн явцыг 2-р багын ИНХ-д оролцож танилцуулсан. Мөн тайланг холбогдох талуудад хүргүүлж ажилласан (<i>Хавсралт 75. БОМТ-н Хагас жилийн биелэлтийн тайлан хүргүүлсэн баримт</i>).
2	100%	Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ-ийн талаарх мэдээллүүдийг танилцуулж, хэлэлцүүлэх	
3	100%	Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ, Хяналтын хорооны үйл ажиллагаа болон хамтын ажиллагааны талаарх мэдээллүүдийг танилцуулж, хэлэлцүүлэх	Хяналтын хорооны гишүүд уурхайн талбайд 8-р сарын 12-ны өдөр хүрэлцэн ирж уурхайн үйл ажиллагаа, БОМТ, ОХШХ-н биелэлттэй танилцсан. Мөн бид холбогдох тайлан, мэдээллүүдийг тогтмол хүргүүлэн ажиллаж байна (<i>Хавсралт 74. ОХШХ-н 1 болон 2-р улирлын үр дүнг хүргүүлсэн баримт</i>).

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
4	100%	Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ-ийн талаарх мэдээллүүдийг танилцуулж, хэлэлцүүлэх	2022 оны 05-р сарын 04-ны өдөр сумын ЗДТГ-ын 40 ажилчид уурхайн талбайд хүрэлцэн ирж үйл ажиллагаатай танилцсан.
5	100%	Уурхайн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цаг алдалгүй олон нийтэд түгээх цахим нүүр хуудас ажиллуулж, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь тогтмол хугацаанд шинэчилж байх	Степ Голд ХХК-ийн албан ёсны цахим нүүр хуудас болон Дорнод аймгийн телевизээр дамжуулан мэдээлэл хүргэж байна.
6	100%	Багийн засаг дарга нартай хамтран уурхайн талбайд зочлох хүсэлтэй иргэдийг зохион байгуулалттайгаар уурхайн талбайд хүлээн авч үйл ажиллагаатай танилцуулж санал, хүсэлтийг нь авах	Уурхайн талбайд Цагаан-Овоо сумын ЕБС-н сурагчид, 2-р багийн Хяналтын хороо, Цагаан-Овоо сумын ЗДТГ-н алба хаагч нар хүрэлцэн ирж үйл ажиллагаатай танилцах, санал хүсэлт хүлээн авах, БОМТ-н биелэлтийн талаар мэдээллүүдийг танилцуулсан.
7	100%	Байгаль орчны чиглэлээр их дээд сургуулиудад суралцаж байгаа оюутнуудаас сонгон шалгаруулж 2-3 оюутныг Байгаль орчны хэлтэст дадлагажигч оюутнаар ажиллуулах	Байгаль орчны чиглэлээр суралцаж буй орон нутгийн оюутныг АЦО уурхайн байгаль орчны хэлтэст дадлага хийлгэх хүсэлтэй байгаа тухайгаа албан бичгээр Цагаан-Овоо сумын засаг даргад хүргүүлсэн. 2022 оны 10-р сарын байдлаар дадлага хийх оюутан байхгүй гэсэн хариу өгсөн тул хэрэгжих боломжгүй байсан (<i>Хавсралт 76. Цагаан-Овоо сумын засаг даргад дадлагажигч оюутан авах хүсэлтэй байгаа тухай албан бичиг хүргүүлсэн баримт</i>). Гэхдээ бутлуур, нуруулдан уусгалт, механикийн болон баяжуулах үйлдвэрийн хэлтсүүдэд холбогдох оюутнууд дадлага хийсэн.
8	100%	Цагаан-Овоо сумын сурагчдын эко клубээр дамжуулан мэдээлэл түгээх, тухайн клубийг идэвхжүүлэх	Цагаан-Овоо сумын Эко клубийн сурагчид уурхайн талбайд зочилсон. Дэлгэрэнгүй мэдээллийг дээрхээс харна уу. Мөн тус Эко клубийн гишүүдтэй хамтран Цагаан-Овоо сумын төвд хуванцар ангилан ялгах хогийн сав байрлуулж, хамтран ажилласан.
9	100%	2022 оны БОМТ төлөвлөгөөний хэрэгжилтийг харуулсан 8-10 минутын нэвтрүүлэг бэлдэж, олон нийтэд мэдээлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг харуулсан бичлэгийг тухайн жилийн төлөвлөгөөг дүгнүүлж, оноогоо авсны дараа бэлтгэж, олон нийтэд мэдээлнэ.

6. ДҮГНЭЛТ

Степ Голд” ХХК нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн холбогдох заалтууд болон 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2022 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь “Уурхайн үйл ажиллагаа, химийн бодис тээвэрлэх, хадгалах болон ашиглах, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, баяжуулах үйлдвэр, хүдэр бутлах зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдээс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга зам, тэдгээрийг хэрэгжүүлэх болон тухайн ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох” болно. Дээрх үйл ажиллагаанаас учирч болзошгүй сөрөг нөлөөллийг тогтмол хянах, хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг товч байдлаар нэгтгэн дүгнэвэл:

- Тайлант онд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 60 арга хэмжээ төлөвлөснөөс 56 ажлыг хэрэгжүүлсэн буюу тогтмол хэрэгжиж байгаа. Үүнээс 17 ажил бүрэн хэрэгжиж дууссан, үлдсэн 39 ажил нь тогтмол байнга хэрэгждэг арга хэмжээ болно. Үлдсэн 4 ажил хэрэгжиж эхэлсэн бөгөөд бүрэн дуусаагүй ажлууд болно. Тус ажлуудыг бид тайлант жилд багтаан бүрэн хэрэгжүүлж дуусахаар төлөвлөн ажиллаж байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 10-р сарын 20-ны өдрийн байдлаар 94%-тай байна.
- Алтан Цагаан-Овоо уурхай нь 2022 оны 10-р сарын байдлаар нийт 30,684 м³ ус ашигласан байна. Үүнээс ажилчдын кемпийн унд ахуйн хэрэглээнд 5220 м³, зам, талбайн усалгаанд 11,997 м³, мод үржүүлэг, ногоон байгууламжийн усалгаанд 2052 м³, өрөмдлөг, хайгуулын ажилд 5879 м³, баяжуулах үйлдвэрт 5536 м³ ус ашигласан байна. 2022 оны 10-р сарын байдлаар ус ашигласны төлбөрт нийт 23,173,063.2 төгрөг төлсөн байна.
- Төслийн үйл ажиллагаа эхэлсэн 2018 оны 6 сараас 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар байдлаар 120.39 га талбай газар /кемп, зам талбай, бутлуур, үйлдвэр г.м./ хөндөгдсөн байна. Тухайн хөндөгдсөн талбайгаас үйл ажиллагааны туршид дунджаар 0.3 метрийн зузаантай хуулж, нийт 397’566.8 м³ шимт хөрсийг хадгалсан байна. Үүнээс тайлант жилд нийт 10 удаагийн газар хөндөлтөөр нийт 10.1 га талбай хөндөж, 38452.1 м³ шимт хөрсийг хуулж, овоолгод хадгалсан байна.
- Тайлант жилд бид уурхайн талбайн хуучин хог хаягдлын цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн. Тус ажлын хүрээнд техникийн нөхөн сэргээлтийг уулын олборлолтод ашигладаг Caterpillar D8 бульдозероор хэлбэржүүлэлт, хөмсөг болгож орхисон байсан шимт хөрсөөр хучиж, олон наст ургамлын үр тарих ажлыг хийсэн. Биологийн нөхөн сэргээлтийн хүрээнд царгас, соргүй согоовор, саман ерхөг, шеллийн бутнуур зэрэг 4 зүйл олон наст ургамлын үрийг хальж гараар тариалалт хийсэн. Мөн шимт хөрсний овоолго #1-н 1/3-г ургамалжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
- Ажилчдын тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 10 гаруй зүйлийн цэцгийн үр ашиглан цэцгийн мандал мөн сагсны талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор нэг наст улаан ботууль ургамлын үрээр тариалалт хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажилласан. Уурхайн зочдын талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 1000 м² талбайд улаан ботууль ургамлын үрийг тарьсан.
- Тосон-Хулстайн БНГ-т хамаарагдах Цагаан-Овоо сумын Эрээн Толгой гэдэг газарт 100 бодгаль тарвага нутагшуулахаар холбогдох талуудтай тохиролцож, тарвага нутагшуулах ажлыг 6 болон 7-

р саруудад амьтны мэргэжлийн байгууллага болох “Авралын Эрэлд” ХХК-тай байгуулсан гэрээний хүрээнд бүрэн хэрэгжүүлсэн.

- Мөн 2021 онд сэргээн нутагшуулсан 100 толгой тарваганы тоо толгой, нүүдэлсэн байдлыг судлах зорилгоор Авралын Эрэлд ХХК болон холбогдох орон нутгийн оролцогч талуудын оролцоотойгоор мониторинг судалгааг хийсэн. Тооллогоор 32 бүлийн идэвхтэй 71 тарваганы дош түүний орчимд 87 тооны Монгол тарвага тоологдсон.
- Лицензийн талбайд давхцал бүхий 13 айлтай нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг гэрээний дагуу 2017-2020 онуудад бүрэн хэрэгжүүлсэн. 2022 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болно.
- Уурхайн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, химийн бодисын нөөцийг хангалттай байлгах зорилгын дагуу химийн бодисын агуулахыг өргөтгөх ажлыг тайлант жилд хийж эхэлсэн. 2022 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаар барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа бүрэн дууссан. Улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлтийг холбогдох байгууллагуудад өгсөн, мөн БОННУ-ний нэмэлт тодотгол тайланг батлуулсан. Тухайн ажлын хүрээнд дахин 10 ширхэг 40 тонны контейнер байрлуулсан бөгөөд тус талбай нь мөн адил MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангасан асгаралт, гал болон байгалийн гамшгаас сэргийлсэн шийдэл, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.
- Тайлант жилд баяжуулах үйлдвэрт 12 төрлийн 566.7 тн химийн бодис ашигласан байна. Энэхүү нийт ашигласан химийн бодисын хэмжээнд шохойг оруулж тооцоогүй болно.
- Тайлант жилийн байдлаар уурхайн үйл ажиллагаанаас гарсан хуванцар савыг “TML” ХХК-тай гэрээ байгуулан 2750 кг хуванцар сав нийлүүлсэн, хуурай хог хаягдлыг Цагаан-Овоо сумын Хөөвөр хөгжил ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан 340 м3 хог хаягдал устгуулсан байна. Аюултай хог хаягдлыг Түмэн эгшиг ХХК-тай гэрээ байгуулан 2022 оны 10-р сарын 20-ны байдлаар сав баглаа боодлын хаягдал нийт 3251.5 кг, натрийн цианидийн гаднах төмөр торх 5333 ш, 23731 кг хүчлийн үлдэгдэл, 12300 кг зэсийн нитрат, 10 ширхэг принтерийн хор зэргийг устгуулаад байна.
- Тайлант жилд уурхайн талбай руу нийт 13 удаагийн натрийн цианидын татан авалт хийгдсэн байдаг. Тээвэрлэлт тус бүрд маршрутыг Цагдаагийн Ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвөөр батлуулж, тээвэрлэлтийг тусгай зөвшөөрөлтэй компани болох “Брайт транс” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн байна.
- 2022 оны ОХШХ-ийн хүрээнд ус, агаар болон хөрсний дээжлэлт, шинжилгээний ажлыг хуваарийн дагуу хэрэгжүүлэн ажилласан байна. Мөн зэрлэг амьтан болон ургамлын мониторингийг АЦО уурхайн байгаль орчны хэлтэс дотооддоо хийсэн гүйцэтгэлээ.
- Алтан Цагаан Овоо уурхайн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэй ажиллалаа. Үүнд: Байгаль орчны менежер – 1, Байгаль орчны мэргэжилтэн – 1, Байгаль орчны инженер – 1, Байгаль орчны ажилтан – 2, Байгаль орчны туслах ажилтан – 14 .

Алтан Цагаан-Овоо уурхайн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд компанийн удирдлагаас эхлээд гүйцэтгэх түвшний бүх ажилчид, мөн гэрээт компанийн ажилчид, сум орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, малчдын бүлэг түүний гишүүдийн оролцоотойгоор амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна.

**“СТЕП ГОЛД” ХХК-ИЙН
“АЛТАН ЦАГААН-ОВОО” УУРХАЙН
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН
ХАВСРАЛТ**

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаал	4
Хавсралт 2. БОННУ тодотгол тайлан нүүр	6
Хавсралт 3. БОМТ-2021-ийн хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн хуудас	7
Хавсралт 4. БОМТ-2022 хүргүүлсэн баримт	10
Хавсралт 5. Археологи, Палеонтологийн ажлын дүгнэлт	11
Хавсралт 6. Дорнод аймгийн БОАЖГ-аас 2022 оны 01-р сарын 21-ны 78 тоот Санал хүргүүлэх тухай албан тоот	11
Хавсралт 7. Уурхайн талбайд байрлуулсан тэмдэг, тэмдэглэгээний байрлал харуулсан зураг	12
Хавсралт 8. Засагт Хаан ХХК-ийн зам усалгааны бүртгэл	13
Хавсралт 9. Агаарын чанарын хэмжилтийн хуудас	14
Хавсралт 10. Цагаан-Овоо, Хөлөнбуйр сумдын цаг уурын мэдээ	15
Хавсралт 11. Хөдөлгөөнт техник, суурин тоног төхөөрөмжид үзлэг, засвар үйлчилгээ хийсэн хуудас	16
Хавсралт 12. ШТС-ын операторын өдөр тутмын үзлэгийн хуудас	16
Хавсралт 13. Онцгой байдлын дадлага сургалтын тайлан	17
Хавсралт 14. Асгаралттай тэмцэх иж бүрдэл шалгасан хуудас	20
Хавсралт 15. Хог хаягдал зайлуулсан бүртгэл	21
Хавсралт 16. Хог хаягдлын журмын сургалт орсон бүртгэлийн хуудас	21
Хавсралт 17. Хог хаягдал зайлуулсан маягт	22
Хавсралт 18. Нуруулдан уусгалт, уусмалын сангийн операторын өдөр тутмын үзлэгийн хуудас	22
Хавсралт 19. Химийн бодисын агуулахын өдөр тутмын үзлэгийн хуудас	23
Хавсралт 20. 2022 оны 5-р сарын 6-ны өдрийн автомат түвшин хэмжигч багаж суурилуулж, хүлээлгэн өгсөн тухай албан тоот	23
Хавсралт 21. 2022 оны 09-р сарын 13-ны өдрийн Шинжилгээний хариу хүргүүлэх тухай албан бичиг	24
Хавсралт 22. Долоо хоног тутмын газрын доорх усны түвшин хэмжилтийн хуудас	25
